



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХООРОНДЫН **ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулан бүтээв.

Улаанбаатар хот

2021 он



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулан эмхэтгэсэн товхимол

АГУУЛГА

Унгар, Монголын ШУА хоорондын хамтын ажиллагааны түүх.....	8
Унгар, Монгол Улсад эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэд	13
Унгар, Монголын ШУА хооронд хэрэгжүүлсэн төслүүд	37
Түүх, угсаатны зүйн хүрээлэн	38
Биологийн хүрээлэн	59
Археологийн хүрээлэн	71
Хэл зохиолын хүрээлэн	84
Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	90
Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Усны нөөц, Ус ашиглалтын салбар.....	94

Эрхлэн гаргасан:

Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам

Эмхэтгэсэн:

Элчин сайдын Нарийн бичгийн дарга Г.Хишигбадам

*ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний
ажилтан М.Энхбаатар*

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Т.Бат

“Хүслийн онго” ХХК-д эхийг бэлтгэн хэвлэв.

ННА 63.4

ДАА 930.1

ISBN 978-9919-9372-0-1

Унгар Улсаас Монгол Улсад суугаа
Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
ДР.ОБРУЦАНСКИЙ БОРБАЛА АННА



МЭНДЧИЛГЭЭ

Дипломат харилцааны 70 жилийн түүхтэй манай хоёр орны Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа нэлээн эрт үеэс эхэлсэн гэж хэлж болно. Энэ нь Дорнын гарал үүсэлтэй Унгарын ард түмэн гарал угсаагаараа холбоотой байж болох садан төрөл, тэдний хэл соёлыг сонирхох болсон тэр цагаас эхлэлтэй юм. Тухайлбал, 1870 онд Унгарын ШУА шийдвэр гарган, залуу судлаач Габор Балинтыг монгол хэл, аялгуу судлуулахаар Халимаг руу явуулсан бөгөөд судлаач цаашлан Өргөөд ирж, Халх, Буриад болон Чахар аялгуунд нарийвчилсан судалгаа хийжээ.

Унгарын үе үеийн язгууртан, аялагчид, элчин сайд зэрэг хүмүүс дорно зүг рүү, ялангуяа Унгарын дундад зууны үеийн түүхийн шастирт тэмдэглэгдэн үлдсэн Хар Тэнгис, Кавказ зэрэг газар нутгаар явж, өвөг дээдсийнхээ ул мөрийг хайж байсан.

1877 онд Сечени Бела ноён тэргүүтэй эрдэм шинжилгээний экспедиц Өвөр Монгол болон Гансу-д очиж, түүхийн дурсгалуудыг цуглуулав. 1897 онд Зичи Енөө тэргүүтэн эрдэм шинжилгээний

экспедиц Монголд долоо хонож, түүх болон биологийн судалгаа хийсэн. Тэрээр энэхүү аялалаараа Монгол болон Өргөөгийн тухай маш олон сонирхолтой материалуудыг цуглуулсан боловч эдгээрийг Монгол судлалд хэрэглээгүй байна.

Мөн XX зуунд Лигети Лайош монгол хэлний судалгаа хийж, хэл сургах үйл ажиллагаа явуулснаар Унгарын монгол судлалд чухал алхам болж, энэ салбарт эрдэм шинжилгээний ажлууд өрнөсөн юм. Үүний зэрэгцээ дараагийн эрдэм шинжилгээний экспедицүүд унгаруудын үүсэл гарвалын тухай судалгаа, байгалийн шинжлэх ухааны судалгааг ч үр дүнтэй хийсэн юм.

Унгар, Монгол хоёр улс 1950 оны 4 дүгээр сарын 28-нд Дипломат харилцаа тогтож, 1957 онд Улаанбаатар болон Будапешт хотуудад харилцан Элчин сайдын яамаа нээсэн түүхтэй. Ийнхүү манай хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтсоноор харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарыг хамран хөгжих үүд хаалга нээгдсэн юм.

1957 онд Унгар, Монголын соёл, шинжлэх ухааны салбарын хамтын

ажиллагааны анхны хэлэлцээр байгуулагдснаар хоёр улсын холбогдох талууд хамтарсан экспедицүүдийг зохион байгуулах боломжтой болов. Ингэснээр угсаатны зүй, археологи, хэл шинжлэл, биологи, ус, геологийн гэх мэт экспедицүүд 1960 оноос эхлэн зохион байгуулагдах болов. Энэ хүрээнд 1960 онд бөө судлаач Вилмош Диосеги мөн Монголд ирж, бөөгийн шүтлэгийн түүх, уламжлалын талаар судалгаа хийсэн бол мөн тэр онд Тибор Хорват Бэлхийн амны Хүннүгийн булшны малтлагыг хийсэн байна. Археологич Иштван Эрдели 1961-1989 онд Төв Азийн бүс нутаг дахь Хүннү, Түрэгийн булшинд археологийн малтлага хийв. 1969 онд Лигети Лайош Унгарын Шинжлэх Ухааны Академийн дэргэд Алтай судлалын судалгааны бүлгийг байгуулсан бөгөөд тус бүлэг нь 2006 он хүртэл ажилласан гэх мэтчлэн хамтын ажиллагааны түүх маш урт үргэлжилнэ.

Өдгөө манай Элчин сайдын яамнаас хоёр улсын Шинжлэх ухааны академи хоорондын энэхүү уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг улам

илүү өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд миний бие өнгөрсөн 5 дугаар сард ШУА-аар зочилж, хоёр орны шинжлэх ухааны хамтын ажиллагааны талаар санал солилцсон. Мөн 7 дугаар сарын 1-нд Унгарын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол Улсын ШУА хооронд хамтран ажиллах санамж бичгийг байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд талууд археологи, археогенетик, түүх, хэлний түүх, угсаатны зүй, ардын хөгжим болон бусад чиглэлээр хамтарсан судалгааны хөтөлбөрүүд эхлүүлэх юм байна. Мөн бие биенийхээ мэргэжлийн хөтөлбөрүүдэд туслах, харилцан туслалцаа үзүүлэх юм. Бидний хамтын ажиллагааны бас нэгэн дэвшил бол 1961 онд эхлүүлж байсан Бэлхийн амны археологийн малтлагыг энэ онд үргэлжлүүлсэн явдал юм.

Бид цаашдаа олон олон судалгаа, шинжилгээний ажлуудыг хамтдаа хийж, хоёр орны шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлнэ гэж итгэж байна.



Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч, Академич **ДҮГЭРИЙН РЭГДЭЛ**

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухаан үүсэж хөгжсөний 100 жилийн ой, Шинжлэх ухааны Академи байгуулагдсаны 60 жилийн ойн баярын мэнд хүргэхийн ялдамд давхар давхар олон баяр тохиосон энэ онцлог жил манайд суугаа Унгарын элчин сайдын яамнаас санаачлан хоёр улсын ШУА-ууд хоорондын хамтын ажиллагааг дүгнэн товхимол гаргаж байгаа явдалд талархал илэрхийлье.

Манай хоёр улсын Шинжлэх ухааны Академиудын хооронд хамтран ажиллах гэрээг 1995 онд байгуулж, эрдэмтэд, судлаачид солилцох, хамтарсан төсөл хэрэгжүүлэх чиглэлээр голлон ажиллаж, шинжлэх ухааны салбарын хоёр талт хамтын ажиллагааг харилцан ашигтай, хамтын сонирхолтой байлгах, жилээс жилд өргөжүүлэн хөгжүүлэх зарчмыг барьж, хүчин чармайлт, хүсэл эрмэлзэл дүүрэн ажиллаж ирсэн билээ. Эдгээр жилүүдэд хоёр орны судлаачид геологи, соёл,

археологи, биологи болон бусад чиглэлээр цөөнгүй хамтарсан төсөл хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний олон арван бүтээл туурвисан байна.

XX зуунд эхэлж, нийгмийн шилжилтийн жилүүдэд бодит шалтгааны улмаас суларч ирсэн шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа маань XXI зууны 20-оод оноос дахин эрч хүчээ сэлбэн үргэлжилж байгаад би ихээхэн баяртай байна.

Та бүхэнд Монгол улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100, Шинжлэх Ухааны Академи байгуулагдсаны 60 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэж, хоёр улсын хамтын ажиллагаа харилцан ашигтайгаар өргөжин тэлж, эрдэмтэн судлаачдын маань хамтын үйл хэрэг өргөжин тэлж, үсрэнгүй амжилтаар үргэлжид баяжиж байхын ерөөл өргөө.



Найрсгаар хүндэтгэсэн:

Унгарын Шинжлэх Ухааны Академийн
Хүмүүнлэгийн ухааны судалгааны төвийн
Ерөнхий захирал
ДОКТОР БАЛОГ БАЛААЖ

МЭНДЧИЛГЭЭ

Хүмүүнлэгийн ухааны судалгааны төвийн ерөнхий захирлын хувьд Шинжлэх ухааны баярыг тохиолдуулан Унгар, Монголын шинжлэх ухааны хамтын ажиллагааны олон арван жилийн үр дүн, өнгөрсөн үе, өнөөгийн судалгаа, ирээдүйн талаар ярилцах завшаан тохиож байгаад баяртай байгаагаа илэрхийлье.

2020 онд Унгар, Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой тохиосон бөгөөд энэ харилцааны хамгийн амжилттай салбаруудын нэг нь шинжлэх ухаан, боловсролын хамтын ажиллагаа гэж хэлж болно. Хүмүүнлэгийн ухааны судалгааны төв нь 1950-иад онд Лигети Лайош, Бямбын Ринчен нарын ажлын үр дүнд улам батжин бэхжиж ирсэн болсон Унгар, Монголын эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг өмнөх харилцааны сэтгэлгээгээр үргэлжлүүлж, нэгэнт амжилттай хэрэгжиж байсан энэхүү хамтарсан ажлуудыг шинэ үр дүнгээр баяжуулан хөгжүүлэхийн төлөө байна.

Сүүлийн 15 жилийн хугацаанд Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Судалгааны төвийн Угсаатны зүйн

хүрээлэн нь Унгар, Монголын ШУА-ийн хамтын ажиллагааны Унгарын бааз суурь болж ирсэн. Академиуд хоорондын гэрээт ажлын хүрээний үндсэн дээр бид Монголын түншүүд, тэр дундаа ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн (хуучнаар Түүх, археологи)-тэй түүх, угсаатны зүйн сэдвээр нэлээд олон хамтарсан судалгааны хөтөлбөр хэрэгжүүлсэн.

Одоогийн байдлаар бид орчин үеийн Монгол орон дахь түүх, уламжлал, түүх, өвийн судалгаа гэсэн нэртэй түүх, угсаатны зүйн судалгаа, нөгөө нь 2017 онд байгуулсан гэрээт ажлын хүрээнд “Монгол дахь Ки-Ланд ландшафтын археологи” хөтөлбөр гэсэн хоёр хамтарсан судалгааны ажлыг хийж байна. Энэ хоёр хамтын ажиллагааг манай хүрээлэнг төлөөлөн манай ахлах мэргэжилтэн Силадьи Жолт удирдаж байгаа болно. Эдгээрээс гадна манай хүрээлэнгийн угсаатны экологийн судалгааны гол чиглэлүүдийн нэг нь Монгол улс бөгөөд ШУА-ийн Ботаникийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн залуу судлаач уг хөтөлбөрт хамрагдаж байна.

Ки-ланд төсөл нь Монгол Улсын

нутаг дэвсгэрт байрлах 10-12-р зууны үеийн Киданы суурингуудын ландшафтын археологи, түүх, угсаатны зүйн аргыг голчлон ашигласан судалгаа бөгөөд энэ нь бэхлэгдсэн суурингийн үлдэгдлийг археологийн эвдрэлгүйгээр судлах, түүний түүх, соёлын үүрэг, өнөөгийн Монголын соёлын уламжлал дахь ач холбогдлыг судлах зорилготой юм. Хөтөлбөрийн гол судалгааны талбар нь Төв Монголын Булган аймгийн Хар Бухын Балгасын дурсгалт газарт чиглэж байгаа боловч судалгааны баг нь Булган, Хэнтий, Дорнод аймгийн Киданы үеийн бусад суурингуудыг мөн судалжээ. Судалгааны үр дүнг Өмнөд Солонгос, Хятад болон Европын олон орны олон сэтгүүл, шинжлэх ухааны арга хэмжээн дээр танилцуулсан. 2021 онд тус төслийн өнөөг хүртэл хийсэн ажлуудыг нэгтгэсэн танилцуулгыг монгол хэл дээр мөн хэвлэн нийтлэх тул эрхэм хамтран ажиллагч та бүхнийг анхаарлаа хандуулахыг зөвлөж байна. Хөтөлбөрийн хүрээнд бид ойрын хугацаанд Хар бухын балгас хэмээх

газарт археологийн малтлага хийх хүсэлтэй байгаа бөгөөд үүнд Монгол талын хамтран ажиллагсдынхаа дэмжлэгийг авна гэж найдаж байна.

Хүмүүнлэгийн ухааны судалгааны төв нь шинжлэх ухааны есөн байгууллагын ажлыг нэгтгэдэг. Судалгааны төвийн тэргүүний хувьд өнөөдрийг хүртэлх уламжлалт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлснээр Монгол Улсын ШУА, Түүх, угсаатны зүй, Хэл зохиол, Археологийн хүрээлэн болон бусад судалгааны хүрээлэнгүүдтэй судалгааны шинэ хөтөлбөрүүд дээр үргэлжлүүлэн ажиллана гэдэгт итгэж байна. Энэхүү завшааныг ашиглан, хүрээлэнгүүдийн удирдлагууд, судлаачид шинэ санаа, судалгааны сэдвээр бидэнтэй зоригтой холбогдоорой гэж хэлмээр байна, бид та бүхэнтэй хамтран ажиллахад ямагт нээлттэй байна. Үүний зэрэгцээ манай судалгааны төвийн хамт олонтой өнөөг хүртэл шинжлэх ухааны өндөр түвшинд хамтран ажиллаж ирсэн Монгол хамт олондоо талархал илэрхийлье!

УНГАР, МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭЭС

Унгар, Монгол хоёр улс 1950 оны 4 дүгээр сарын 28-нд Дипломат харилцаа тогтоож, 1957 онд Улаанбаатар болон Будапешт хотуудад харилцан Элчин сайдын яамаа нээсэн түүхтэй. Ийнхүү манай хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтсоноор харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарыг хамран хөгжих үүд хаалга нээгдсэн юм.

Унгар, Монголын соёл, шинжлэх ухааны харилцаа 1953 оноос эхэлж, 1957 оны 10 дугаар сарын 09-нд хамтын ажиллагааны анхны хэлэлцээр байгуулагдсан ба 1974, 1987 онуудад шинэчилсэн боловч уг хэлэлцээр мөрдөгдөхгүй болсон тул “Монгол Улсын Засгийн газар, БНУУ-ын Засгийн газар хооронд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хэлэлцээр”-ийг 1996 онд шинэчлэн байгуулсан юм.

Хоёр орны ШУА-ийн хооронд эрдэм шинжилгээний салбарт хамтран ажиллах төлөвлөгөөг 1991-1995 онд, 1995-2000 онд байгуулжээ. Боловсролын салбарт Унгарын тал 1957 оноос эхлэн манай залуучуудыг өөрийн их, дээд сургуулиудад үнэ төлбөргүй суралцуулж эхэлсэн. Хоёр орны ШУА-ийн хамтын ажиллагааны хүрээнд аспирант, дэд докторууд, их дээд сургуулийн багш нарыг БНУУ-д сургасан ба Унгарын Өтвөш Лорандын нэрэмжит их сургуулийн Монгол ба Төв Ази судлалын тэнхимд монгол хэлний багш, МУИС-д Унгар хэлний багш харилцан солилцож ажиллуулсан юм.

Ийнхүү хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтож, Хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдснаар хамтарсан экспедицийг зохион байгуулах боломжтой болов. Үүний үр дүнд угсаатны зүй, археологи, хэл шинжлэл, биологи, геологийн гэх мэт экспедицүүд 1960 оноос эхлэн зохион байгуулагдах болов. Энэ хүрээнд 1957 онд Унгарын талаас монгол судлаач Хар Дорж (Кара Дьёрдь), Каталин Кохальми, Андраш Рона-Таш нар Монголд судалгааны аялал хийсэн байна. 1960 онд бөө мөргөл судлаач Вильмош Диосеги мөн Монголд ирж, бөөгийн шүтлэгийн түүх, уламжлалын талаар судалгаа хийсэн. Археологич Иштван Эрдели 1961-1989 онд Төв Азийн бүс нутаг дахь Хүннү, Түрэгийн булшинд археологийн малтлага хийв. 1969 онд Лигети Лайош Унгарын Шинжлэх Ухааны Академийн дэргэд Алтай судлалын судалгааны бүлгийг байгуулсан бөгөөд тус бүлэг нь 2006 он хүртэл ажиллажээ. Төв Азийн тэнхимийг 1972 он хүртэл Лигети Лайош, 1972-2001 оны хооронд Хар Дорж (Кара Дьёрдь), 2001 оноос Агнеш Бирталан удирдаж байна¹. Унгарын монголч эрдэмтэн Кара Дьёрдь 1992 онд Монгол судлалын олон улсын холбооны гишүүнээр сонгогдсон бөгөөд Монгол судлалыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, түүнийг “Алтан гадас” одонгоор, 2005 онд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор тус тус шагнажээ.

¹ Central and Eastern Europe, №5, 2020, 149-р тал.

1960 онд БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, БНУАУ-ын Шинжлэх Ухааны Академийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Унгарын Азийг судлах нийгэмлэгийн дарга, Будапешт хотын Азийн Урлагийн Музейн дарга Т.Хорват Монгол улсад нэг сарын хугацаагаар ирж, Монгол дахь Хүннүгийн үеийн булшны байдалтай танилцах, улмаар зарим булшийг малтан судлах хүсэлт тавьсан байна. Т.Хорватын хүсэлтийг Түүхийн хүрээлэн хүлээн авч, Улаанбаатар хотын ойролцоох Бэлхийн амны Хүннү булшийг малтан судлахаар тохиролцжээ. Ийнхүү 1961 онд ажилласан хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас Н.Сэр-Оджав, Ц.Доржсүрэн, Д.Дорж, Д.Наваан нар МУИС-ийн таван оюутны хамт ажилласан байна. Монголын эртний нүүдэлчдийн анхны төрт улс Хүннү гүрний ихэс дээдсийн булш, оршуулга бүхий Бэлхийн амны дурсгал нь нийслэл хотын нутаг дэвсгэрт оршдог бөгөөд Монгол ба бүс нутгийн Хүннүгийн археологийн судалгаанд томоохон байр суурийг эзэлдэг. Энэхүү малтлагаар морины тоног хэрэгсэл, зэр зэвсэг, төмөр эдлэл, антропологийн хэрэглэгдэхүүнийг илрүүлэн анх удаа эрдэм шинжилгээний эргэлтэд оруулжээ. 2021 онд Унгар улсын Унгар судлалын хүрээлэн, Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Нийслэлийн Соёл урлагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булшны археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний анги малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна.

1974 онд Сегед хотын Йожеф

Аттилагийн нэрэмжит Их сургуулийн дэргэд Алтай судлалын судалгааны бүлэг байгуулагдсан бөгөөд одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Ардын уламжлалт соёл, хэлний судалгааг 1991 оноос хоёр орны эрдэмтэн, судлаачдын хамтарсан баг эхлүүлсэн байна. Одоогийн байдлаар судалгааны үр дүнг нэгтгэсэн гурван боть ном гарсан байна.

1975 оноос эхлэн монголчууд Унгарт аспирантурт суралцсан бөгөөд өдгөө 20 гаруй хүн Унгарт эрдмийн зэрэг хамгаалсан бол, 1999 онд Унгар улсаас түүхч, судлаач Др.Обрушанский Борбала Анна Монгол Улсын Их Сургуульд Түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан юм.

1991 онд Монголын үлэг гүрвэлийн олдворын үзэсгэлэнг Унгар Улсад анх удаа гаргаж, зургаан сарын турш ажиллуулсан бөгөөд монголч эрдэмтэн, монгол хэл сурч буй унгар оюутнуудыг жил бүр Монголд дадлага хийлгэх, судалгааны экспедиц илгээх, эрдэмтэд хоёр орны их, дээд сургуулиудад харилцан лекц унших, соёлын өдөрлөг, үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээнүүд үндсэндээ тогтмолжсон.

Манай хоёр орны Байгалийн шинжлэх ухааны хамтын ажиллагаа Унгарын нэрт эрдэмтэн, Байгалийн Түүхийн музейн ерөнхий захирал, доктор, шавж судлаач, хожмоо Унгарын ШУА-ийн гишүүн болсон Золтан Касаб докторын 1963-1968 онуудад Монгол улсын нутагт явуулсан хээрийн судалгааны ажлаар эхэлсэн. Тэрээр Монголд хийсэн нийт 6 удаагийн хээрийн судалгааныхаа дүнд 480 гаруй мянган биологийн дээж материал цуглуулж судлан тэдгээрийн үр дүнд тулгуурлан 200 гаруй эрдэм шинжилгээний хамтарсан бүтээл хэвлүүлжээ.

1973 онд Унгар улсын буцалтгүй тусламжаар Монгол улсад Нарны зайн лаборатори байгуулагдахаар болж, Монгол эрдэмтэд Унгар улсын Тунгсрам фирмийн болон Цахилгаан техникийн судалгааны хүрээлэнгийн лабораториудад мэргэжил дээшлүүлж, үр дүнд нь ШУА-ийн ФТХ-ийн Нарны зайн лабораторийн суурь тавигдаж байв. Мөн 1979 онд ШУА-ийн Биологийн хүрээлэнд анхны Генетикийн лаборатори байгуулагдан хөгжихөд Унгар улсын дэмжлэг тусалцаа чухал ач холбогдолтой байсан. Унгар улсын ЗГ-ын буцалтгүй тусламжаар тус Генетикийн лабораторийн хэсгийг тоноглон, хамтарсан судалгаа шинжилгээний ажлуудыг хийж, 10 орчим мэргэжилтэн судлаачдыг Унгарын холбогдох лабораториудад сурган бэлтгэжээ.

2000 оноос хоёр орны эрдэм шинжилгээний хамтын ажиллагаанд Унгарын талаас Угсаатны зүйн судалгааны баг тэргүүлэн оролцож, археологийн салбарын хамтын ажиллагаа 2016 оноос дахин сэргэн хөгжиж байна.

2014 онд Монголын талын санхүүжилтээр Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургуулийн Монгол ба Төв Ази судлалын тэнхмийн дэргэд “Монгол судлалын төв” байгуулагдсан бөгөөд эрхлэгчээр нь эрдэмтэн Агнеш Бирталан ажиллаж байна. Тус тэнхим нь Монгол судлал болон Буддын шашны сэдвээр хэд хэдэн Олон улсын бага хурлыг зохион байгуулсан байна.

Унгар дахь Монгол судлалын хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн эрдэмтэн Агнеш Бирталаныг 2005 онд Монгол Улсын “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор, 2010 онд Агнеш Бирталан, Жолт

Силадьи нарыг “Найрамдал” медалиар шагнажээ. Эрдэмтэн Агнеш Бирталан 2016 онд Олон Улсын Монгол судлалын холбооны Ерөнхийлөгчөөр сонгогдсон бөгөөд мөн тэр ондоо “Соёлын элч” хэмээх цолыг хүртжээ. Олон Улсын Монгол Судлалын Холбоонд Унгараас Акош Авар, Агнеш Бирталан, Др.Обрущанский Борбала Анна, Андраш Рона-Таш, Жолт Силадьи, Алис Саркози, Кристина Телеки нарын эрдэмтэд ажиллаж байна.

Унгарын Монголч эрдэмтэд эдүгээ хэд хэдэн чиглэлээр судалгаа хийн үр бүтээлтэй ажиллаж байна. Тухайлбал, судлаач Алис Саркози, Агнеш Бирталан, Кристина Телеки нар монголын бурхны шашны чиглэлээр судалгаа хийж байгаа бол, Др.Обрущанский Борбала Анна, Балаж Салонтай (Balázs Szalontai), Жолт Силадьи нар түүхийн асуудлаар судалгаа хийж байна. Угсаатны зүйн чиглэлээр Акош Авар (Ákos Avar), Иштван Серес (István Seres), Иштван Санта (István Sántha), Давид Кара Сомфай (Dávid Kara Somfai) нар, монгол хэл шинжлэлийн чиглэлээр Ракош Аттила (Rákoss Attila), Акош Апатоски (Akos Apatóczky) судалгаа хийж байна. Эдгээр нь Олон улсын Монгол судлалд Унгарын монголч эрдэмтдийн оруулж буй хувь нэмэр бөлгөө.

Хөдөө аж ахуйн салбарт, Унгарын Сент-Иштваны Их сургуулийн захирлаар ажиллаж байсан, Мал эмнэлгийн шинжлэх ухааны доктор, профессор, Унгарын Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүн, академич Шолти Ласло Монголын Шинжлэх Ухааны академийн гадаад гишүүнээр 2005 оноос, Унгарын Хэрцэгхаломын Мал аж ахуй, тэжээллэгийн хүрээлэнгийн захирал, Мал эмнэлгийн шинжлэх ухааны доктор, профессор

Ратки Ёжеф мөн ХАА-н Шинжлэх ухааны салбар Академийн гадаад гишүүнээр 2006 оноос тус тус сонгогдон ажилласан. Эдгээр хүмүүс ХААИС, түүний харьяа хүрээлэнгүүдийг Унгарын холбогдох чиглэлийн судалгааны байгууллагуудтай холбох, эрдмийн боловсон хүчин бэлтгэх, хамтарсан судалгаа явуулах, гэрээтэй ажиллахад томоохон хувь нэмэр оруулсан юм. Тэдний дэмжлэгтэйгээр ХААИС түүний харьяа хүрээлэнгүүд Будапештийн Мал эмнэлгийн шинжлэх ухааны Их сургууль, Сент-Иштваны Их сургууль, Дэбрецений Их сургууль гэх зэрэг найман байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна. Мөн эдгээр эрдэмтэд Монголын Биокомбинатын шинэчлэлийн онол арга зүйн үндэслэлийг боловсруулах, боловсон хүчин сургахад ихээхэн анхаарал хандуулж, дэмжлэг үзүүлж байна.

Ийнхүү Унгар, Монголын Соёл, шинжлэх ухааны Хамтын ажиллагааны хүрээнд Ус, Түүх, угсаатны зүй, Археологи, Биологи, Хэл шинжлэл, Ботаникийн салбарт хамтын ажиллагаа эрчимжиж, өнөөдрийг хүртэл идэвхтэй үргэлжилж байна.

Унгарын үндэсний музей “Чингис хаан, түүний өв” үзэсгэлэнг Будапешт хотын Үндэсний музейд 2007 оны 5-9 дүгээр сард арилжааны нөхцөлөөр гаргасан бөгөөд уг үзэсгэлэнг 100 мянга гаруй хүн үзэж сонирхжээ.

2008 онд ЭСЯ, Унгарын ШУА, Өтвөш Лорандын нэрэмжит Эрдмийн Их сургуулийн Монгол ба Төв Ази судлалын тэнхимтэй хамтран “Европ дахь Монгол судлал” эрдэм шинжилгээний хурал, 2011 онд “Монголын эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойд” сэдэвт эрдэм

шинжилгээний бага хурал, 2010 онд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд “Монгол-Унгарын соёл, шинжлэх ухааны салбарын харилцаа 60 жилд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, 2013 оны 7 дугаар сард “Монгол судлалын асуудлаар” эрдэм шинжилгээний бага хурлыг Будапешт хотноо тус тус зохион байгуулжээ.

2014 оны 11 дүгээр сард Унгар Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн урилгаар Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин тэргүүтэй төлөөлөгчид Унгар Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын хүрээнд ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал, доктор С.Чулуун, Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор Я.Цэрэндагва нарын бүрэлдэхүүнтэй ШУА-ийн зочид төлөөлөгчид Унгарын ШУА-ийн Байгалийн ухааны судалгааны Төв, Хүмүүнлэгийн ухааны Судалгааны Төв, Унгарын Үндэсний музей, Унгарын Угсаатны музейд тус тус зочлон судлаач эрдэмтдийн тавьсан эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа шинжилгээ, олдвор ховор үзмэрүүдтэй танилцаж, хоёр орны ШУА, хүрээлэн хоорондын шууд хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцов. Мөн “Монголын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Унгарын Үндэсний түүхийн музейн хооронд судалгаа хийх, ном бүтээлүүд хэвлүүлэх, эрдэмтэд харилцан солилцох, хээрийн судалгаа хамтран зохион байгуулах тухай Хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

Өдгөө манай Элчин сайдын яамнаас хоёр улсын Шинжлэх Ухааны Академи хоорондын энэхүү уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг улам илүү өргөжүүлэн хөгжүүлэх зорилт

тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Др.Обрущанский Борбала Анна 2021 оны 5 дугаар сарын 25-нд Монгол Улсын ШУА-аар зочилж, хоёр орны шинжлэх ухааны хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Мөн 2021 оны 7 дугаар сарын 1-нд Унгарын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол Улсын ШУА хооронд хамтран ажиллах санамж бичгийг ШУА-ийн ерөнхийлөгч

Д.Рэгдэл, Унгарын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Хорват Лугошши Габор нар үзэглэв. Хамтын ажиллагааны хүрээнд талууд археологи, археогенетик, түүх, хэлний түүх, угсаатны зүй, ардын хөгжим болон бусад чиглэлээр хамтарсан судалгааны хөтөлбөрүүд эхлүүлэх зорилготой байна. Мөн бие биенийхээ мэргэжлийн хөтөлбөрүүдэд туслах, харилцан туслалцаа үзүүлэхэд оршиж байна.



*ШУА-ийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Унгарын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Хорват Лугошши Габор нар Санамж бичиг үзэглэж буй нь.
Улаанбаатар хот, 2021.07.01*

Өнгөрсөн онд тохиосон Унгар, Монголын Дипломат харилцааны 70 жилийн ойд зориулан Унгарын Элчин сайдын яам, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн судлаачид, Монголын их дээд сургуулийн багш нарын Төв, Зүүн Европ судлалын Монголын Холбоо (ТЗЕСМХ)-той хамтран “Central and Eastern Europe” сэтгүүлийн тав дахь дугаарыг “Монгол, Унгарын харилцаа” нэртэйгээр хэвлүүллээ. Энэхүү сэтгүүлд, хоёр улсын Дипломат

харилцааны 70 жилийн тухай түүхэн эргэцүүлэл, хамтын ажиллагааны хөгжил, өнөө ирээдүйн тухай, Унгар дахь Монгол судлалын тухай, Унгар, Монголын археологич эрдэмтдийн хамтын ажиллагаа, мөн Монгол Улсаас Унгар улсад томилогдон ажилласан эрхэм Элчин сайд нар, Унгарт боловсрол эзэмшиж, эх орны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа хүмүүсийн сонирхолтой ярилцлага, дурсамжууд багтжээ.



МОНГОЛ УЛСАД
ЭРДМИЙН ЦОЛ, ЗЭРЭГ
ХАМГААЛСАН
УНГАР ЭРДЭМТЭД



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ДОКТОР АРПАД БОГШ (1919-2004)

Америкийн нийгмийн нэрт зүтгэлтэн Арпад Богш нь 1919 оны 2 дугаар сарын 24-нд Унгарын Будапешт хотод төржээ. 1959 онд АНУ-ын иргэн болсон бөгөөд 1959-1997 оны хооронд дэлхийн Оюуны Өмчийн байгууллагад ерөнхий захирал хүртэлх албан тушаалд ажиллаж байсан төдийгүй Шинэ төрлийн ургамал хамгаалах дэлхийн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгээр ажиллаж байжээ. А.Богш нь 2004 оны 9 дүгээр сарын 19-нд насан эцэслэх хүртлээ Дэлхийн оюуны өмчийг хамгаалах үйл ажиллагааг шинэ шатанд хөгжихөд хувь нэмрээ оруулсаар байсан юм. Түүний ажил хөдөлмөрийн замнал 1942 онд Будапешт хотод хуульчаар ажилласнаас эхэлсэн бөгөөд Дэлхийн оюуны өмчийг хамгаалах ажилтай холбогдсон нь 1948 онд Парис хотноо шилжин суурьшиж НҮБ-ын ЮНЕСКО-ийн Зохиогчийн эрхийн хэлтэст ажилласан явдал юм. 1954 оноос Вашингтон хот дахь хэлтэст шилжин ажиллаж 1959 онд АНУ-ын иргэн болсон. 1963 онд өнөөгийн ДООБ-ын үндэс суурь болох Оюуны өмчийн хэлтсийн нэгдүгээр нарийн бичгээр томилогдон ажилласан. 1967 онд ДООБ байгуулагдаж Арпад Богш анхны ерөнхий захирлаар 1970 оноос ажиллаж эхэлснийг ерөнхийд нь 1963-

1997 оны хооронд дэлхийн оюуны төв байгууллагыг тэргүүлсэн гэж үздэг. Түүний удирдсан жилүүдэд ДООБ-ын үйл ажиллагааны хүрээ, чиг үүрэг тэлж оюуны өмчийн бүхий л салбарыг хамран идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэл болон болж хүчирхэгжсэн юм. Тэрээр маш олон онцгой санаачилгуудыг хэрэгжүүлж цөөнгүй олон улсын гэрээ, конвенцийг үндэслэн дахин сайжруулж, хөгжиж буй болон буурай улс орнуудад зориулсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, Олон улсын бүртгэлийн тэмдгийг шинэчилсэн. Мөн тэрээр Олон улсын багш, судлаачдын оюуны бүтээлийн нийгэмлэг (ATRIP)-ийг үндэслэсэн юм.

Энэ мэтчилэн түүний дэлхийн оюуны өмчийг хамгаалах үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлэн 1994 онд МУИС-ийн ХҮНДЭТ ДОКТОР цол өргөмжилжээ².

² Ууган их сургуулийн Хүндэт индэр, 2012, УБ

ОБРУЦАНСКИЙ БОРБАЛА АННА



Боловсрол, эрдмийн зэрэг, цол: Түүхийн ухааны доктор Ph.D

Төгссөн сургууль:

- 1997 - 1999 онд Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Ухааны Факультет - Түүхийн ухааны доктор
- 1992 - 1997 онд Унгар Улсын ELTE Их Сургуулийн Нийгмийн Ухааны Факультет, Түүх, монгол судлалын аспирант

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Мажар, Монгол улсын түүхэн дэх нийтлэг ба онцлог шинж”

Эрхэлсэн ажил:

- 2020 онд Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
- 2020 - онд Унгарын Элчин сайдын яамны Хэргийг хамаарагч
- 2019 - 2020 онд Унгарын Элчин сайдын яамны Дэд тэргүүн
- 2018 - 2019 онд Гүрж дэх Унгарын Элчин Сайдын Яаманд Нарийн бичгийн дарга
- 2015 - 2018 онд Унгарын Гадаад хэрэг, худалдааны яаманд Монгол болон Азербайжан улсыг хариуцсан мэргэжилтэн
- 2012 оноос Унгарын Карули Гашпар Их Сургуулийн Нийгэм соёлын угсаатны зүйн факультет – Адъюнкт
- 2009 - 2014 онд “Journal of Eurasian Studies”, Хааг хот, Холланд улс - Ерөнхий редакторын орлогч
- 2004 - 2005 онд Унгарын Шинжлэх Ухааны Академи, Угсаатны зүйн Институт, Бөө мөргөлийн төвд судлаач
- 2000 - 2002 онд Унгарын Печь хотын Их Сургуулийн Ази Судлалын Төвд судлаач, Зөвлөх
- 1998 - 2015 онд Редактор, Ерөнхий редактор (Соёл болон Түүх)
- 1998 - 2000 онд Унгарын Деак Ференц Соёлын Сангийн захирал
- 1994 - 1995 онд Унгарын Шинжлэх Ухааны Академи, Угсаатны зүйн Институт, Бөө мөргөлийн төвд судлаач

Гавьяа, шагнал:

- 2015 онд Секей үндэстний төлөө шагнал
- 2019 онд Улаанбаатар хотын шагнал



УНГАР УЛСАД
ЭРДМИЙН ЦОЛ, ЗЭРЭГ
ХАМГААЛСАН
МОНГОЛ ЭРДЭМТЭД

ЕНШӨӨБҮ ОВОГТ БЯМБЫН РИНЧЕН

(1905.11.21-1977.03.04)



Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгчдийн нэг, XX зууны манлай монголч эрдэмтэн байв.

1914-1920 онд Алексеевский сургуульд сурсан. 1923-1924 онд Бямбын Ринчин Верхнеудинск буюу өнөөгийн Улан-Үд хотын багшийн техникумд сураад 1924 онд хэсэг монгол оюутнуудын хамт Ленинградд үргэлжлүүлэн суралцахаар явж, Дорно хэлний ангид элсэн сурсан байна. 1927 онд сургуулиа төгсөөд Дорно судлалын диплом өвөртлөөд Улаанбаатарт ирж, Монголын Гэгээрүүлэх яамны харьяа Судар бичгийн хүрээлэнд ажиллаж байжээ. 1937 онд Улс төрийн хилс хэргээр баригдан шоронд хоригдоод, 1942 онд суллагдаж, МАХН-ын Төв хорооны шийдвэрээр “Үнэн” сонины газарт заагдан 1958 он хүртэл арван зургаан жил ажиллажээ.

1961 онд “Монгол бичгийн хэлний зүй” бүтээлээрээ Шинжлэх ухааны академич цол тус, тус хүртжээ. Монгол хэл бичиг, ардын билиг, угсаатны зүйн судалгаа хийсэн, Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишүүн, хэл бичгийн ухааны доктор цолтой байв. 1929 онд байгуулсан Монголын зохиолчдын анхны дугуйлангийн гишүүн байсан бөгөөд орос, чех, польш, франц, англи, эсперанто, герман хэлтэй

агуу их эрдэмтэн хүн байв. 1956 онд Унгар улсад “Монгол бичгийн хэлний зүй” сэдвээр судалгаа хийж, “Монгол хэлнүүдийн харьцуулсан түүхэн хэлний зүй” бүтээлээрээ хэл бичгийн ухааны доктор болсон. Хэл шинжлэлийн докторын зэрэг хамгаалсан бөгөөд уг бүтээлээ дөрвөн ботиор (1964-67) хэвлүүлжээ. Харин уг бүтээлийн III ботийг нь тухайн үед үзэл суртлын шалтгаанаар худалдаанд гаргалгүйгээр шатааж устгасан байна. 1958 онд Финно-Угро нийгэмлэгийн хүндэт профессор цол хүртсэн. Түүний бичсэн “Хэлийг эвдэн гутаах лугаа тэмцэн тулах цаг ирсэн бишүү” (1934), “Монгол шүлгийн учир” (1969-70), “Монгол ард улсын хамниган аялгуу” (1965) зэрэг бүтээл нь эрдэм шинжилгээний хувьд үнэ цэнтэйд тооцогддог. Тэрээр эрдэм шинжилгээний бүтээлээс гадна орчуулгын болон уран бүтээлийн баялаг өв үлдээжээ.

Зохиолч эрдэмтэн, бичгийн их хүн Бямбын Ринчен 1977 оны 3 дугаар сарын 4-ний өдөр таалал төгсжээ. Бямбын Ринчений мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан түүний дурсгалын хөшөөг Улсын төв номын сангийн өмнөх талбайд 2005 онд босгожээ.



ЧОЙ.ЛУВСАНЖАВ (1930-1998)

Чойжавын Лувсанжав 1930 оны 12 сарын 16-нд Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошуу, одоогийн Өвөрхангай аймгийн Өлзийт суманд төржээ. 1940 оноос бага сургуульд орж, улмаар 1949-1953 онд УБДС-ийн тооны анги дүүргэн, 1954-1960 онд Бээжингийн их сургуульд сурч төгсжээ. 1947-1950 онд сумын бага сургууль, 1953-1954 онд Хужирт сумын сургуульд багш, захирал, 1960-1961 онд ГЯЯ-нд референт, 1961-1977, 1981-1989, 1992-1993 онд МУИС-д багш, тэнхимийн эрхлэгч, декан, 1977-1980 онд Чехословак Улсын Карлын их сургуульд, 1989-1992 онд Япон Улсын Токио хотын Гадаад хэлний их сургуульд монгол хэл бичиг, угсаатны судлалын багшаар уригдан ажиллаж байлаа.

1966 онд “Монгол хэлний өвөрмөц хэллэг” сэдвээр Унгар Улсад дэд эрдэмтний зэрэг, 1972 онд “Англи-монгол хэлний харьцуулсан хэлзүй” сэдвээр ЗХУ-д докторын зэрэг хамгаалжээ. Чой.Лувсанжав багш МУИС-д ажилласан 37 жилийн хугацаандаа англи, хятад, япон, герман, франц, солонгос хэлийг заан сургахад анхааран ажиллаж, МУИС-ийн Гадаад хэлний тэнхим, Дорно дахины хэлний тэнхимийг хариуцан

ажиллаж байв. Дотоод, гадаадын 40 гаруй эрдэмтний эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар ажиллаж, англи, орос, хятад, япон, франц, герман, манж, төвөд, латин, чех, мажар зэрэг арав гаруй хэлийг эзэмшин, эрдмийн судалгаандаа хэрэглэж байсан юм.

Эрдэм шинжилгээний 300 гаруй өгүүлэл бичиж, 40 гаруй ном, сурах бичиг, толь бичгийг зохион хэвлүүлжээ. Монгол бичгийг сэргээн, төрийн бичиг болгох их үйл хэрэгт хүчин зүтгэж, монгол хэл бичиг, гадаад хэлний боловсролтой олон зуун шавь нарыг Монгол Улсад бэлдэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан тул Монгол Улсын төрөөс 1993 онд профессор Чой.Лувсанжавд Монгол Улсын Гавьяат Багш, МУИС-ийн хүндэт профессор цол хүртээжээ. Мөн 1971 онд Чехословак Улсын Карлын Их сургуулийн хүндэт профессор цол хүртэж байсан юм.

Чой.Лувсанжав багш ШУА-ийн Эрдмийн Зөвлөлийн гишүүн, Эрдмийн цол зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, Улсын Нэр Томьёоны комиссын гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн гишүүн, МУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн гишүүн байв.

ЦЭМБЭЛЦОГТЫН БАЯСГАЛАН (1947-2006)



Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Математикч, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Төгссөн сургууль:

1965-1970 онд Ломоносовын нэрэмжит Москвагийн Их Сургууль.

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

1976-1979 онд Унгар улсын Шинжлэх Ухааны Академийн математикийн хүрээлэнгийн аспирантурт суралцаж, “Тодорхой бус метриктэй огторгуй” сэдвээр дэд докторын (Ph.D) зэрэг хамгаалсан.

2001 онд Монголын ШУА-д “Тодорхой бус метриктэй огторгуй дахь шугаман операторын спектрал анализ” сэдвээр шинжлэх ухааны доктор (Sc.D) хамгаалсан.

Эрхэлсэн ажил:

1970 оноос МУИС-ийн математик анализын тэнхимийн багш, эрхлэгч, тэргүүлэх профессор.

Гавьяа, шагнал:

1992 онд “Ардын боловсролын тэргүүний ажилтан”

1997 онд “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”

2002 онд “Алтан гадас” одонгоор шагнагдсан.



РЭНЦЭНГИЙН БАТМЭНД

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Техникийн ухааны доктор (Ph.D), профессор

Төгссөн сургууль:

Будапештийн Техникийн Их Сургуулийн аспирантурт суралцаж төгссөн

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Үр тарианаас ялгахад төвөгтэй хольцыг вибропневматик сепаратороор салгах нь”.

Эрхэлсэн ажил:

Гурил-тэжээлийн үйлдвэрлэлийн нэгдэлд Үйлдвэр технологийн хэлтсийн дарга, ХХҮЯ-ны ЭШЗТИ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Үндэсний хөгжлийн дэд сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, Мобиком корпорацийн ерөнхий захирал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэнгийн Эдийн засгийн аюулгүй байдлын секторын эрхлэгч.

Гавьяа, шагнал:

“Монгол Улсын гавьяат эдийн засагч”



ШИРЧИНГИЙН ДЭМБЭРЭЛ

Эрдмийн зэрэг, цол:

Малын их эмч (*микробиологи, физиологич*), Мал эмнэлгийн шинжлэх ухааны доктор, профессор.

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

Унгарын Шинжлэх Ухааны Академийн аспирантурт 1979-1983 онд суралцаж, “A bárányok korai elválasztásának legalkalmasabb időpontja növekedési-, bendőemésztési- es anyagforgalmi vizsgálatok alapján” сэдвээр Мал эмнэлгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан.

Монголын Шинжлэх ухааны Академи, ХААИС-д “Хурганы тэжээл боловсруулалт, өсөлтийг идэвхжүүлж, эмгэгтэй тэмцэх нь” сэдвээр Мал эмнэлгийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан.

Төгссөн сургууль:

Монголын Хөдөө Аж Ахуйн Их сургууль,

Эрхэлсэн ажил (*Аспирантур төгссөнөөс хойш*):

1983-1987 онд МААЭШХ, Мал эмнэлгийн салбарт Ахлах ажилтан, салбарын эрдэмтэн нарийн бичгийн дарга,

1987-1990 онд ХХААЯ-ны дэргэдэх Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны зөвлөлд Эрдэмтэн нарийн бичгийн дарга,

1990-2003 онд ХААИС, Мал эмнэлгийн хүрээлэнд Эрдэм шинжилгээний ахлах, тэргүүлэх ажилтан, лаборатори, тэнхмийн эрхлэгч, төслийн удирдагч,

2003-2012 онд Хөдөө аж ахуйн их сургуульд Эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор бөгөөд Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны зөвлөлийн дарга (2003-2009), Инноваци, технологи дамжуулах төвийн захирал (2009-2012),

2012 оноос ХААИС, Мал эмнэлгийн хүрээлэнд Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Төслийн удирдагч

Гавьяа, шагнал:

1999 онд Шинжлэх ухааны тэргүүний ажилтан

2001 онд Алтан гадас одон

2006 онд Боловсролын тэргүүний ажилтан

2012 онд Хүнс, хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан

2013 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон

1991-2011 онд Ардын хувьсгалын 70, 80, 90 жилийн ойн медалиуд

2007 онд Сибирийн шинжлэх ухааныг хөгжүүлсний төлөө академич Синягиний нэрэмжит алтан медаль (ОХУ-ын ШУА)

2019 онд ОХУ-ын Зэвсэгт хүчний “Мал эмнэлгийн салбарт гавьяа байгуулсны төлөө” дурсгалын медаль



ЖИГЖИДДОРЖИЙН АЛИМАА

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Дээд, биохимич-инженер, химийн ухааны доктор, Монгол Улсын Төрийн соёрхолт, дэд профессор

Төгссөн сургууль:

1969 онд Нийслэлийн лаборатори 1 дүгээр сургууль, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай анги

1975 онд Москвагийн Мах, сүүний үйлдвэрийн технологийн дээд сургууль (одоо Хэрэглээний биотехнологийн Москвагийн их сургууль)

1983 онд Унгарын Хүнсний эрдэм шинжилгээний төвд Энзимологийн тасагт докторын зэрэг хамгаалсан.

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Монгол хонь, ямааны нойр булчирхайн уураг задлагч ферментийг ялган цэвэршүүлсэн нь”

Эрхэлсэн ажил:

1975 - 1979 онд ШУУ-ийн Монэнзим ХХК-д Ерөнхий инженер

1979 - 1983 онд Унгарын Хүнсний эрдэм шинжилгээний төвд аспирант

1984 - 2001 онд Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн “МОНЭНЗИМ” нэгдэлд Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд захирал

2001 - 2004 онд ШУТИС-ийн ХБТС (одоо ХИБС буюу Хүнсний инженер, биотехнологийн сургууль)-д Биотехнологийн багийн профессор

2004 - 2008 Тарилгын шингэний “IVCO” хамтарсан үйлдвэрийн Үйлдвэрлэл хариуцсан захирал

2008 - 2011 ШУУ-ийн “Монэнзим” компанийн Судалгаа, хөгжлийн захирал

2011 - оноос АНУ-ын эрүүл мэндийн бүтээгдэхүүний “Юнисити Интернэшнл ХХК”-д Зөвлөхөөр ажиллаж байна.

Гавьяа, шагнал:

1991 онд Монгол Улсын төрийн соёрхолт

1991 онд Аж үйлдвэрийн тэргүүний ажилтан

2001 онд Шинжлэх ухааны тэргүүний ажилтан

2006 онд Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан

ЦЭНДСҮРЭНГИЙН ОЮУНСҮРЭН



Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Дээд боловсролтой, Биологич Генетикч, Биологийн шинжлэх ухааны доктор, профессор, Академич

Төгссөн сургууль:

Улаанбаатар хотын 1-р 10 жилийн сургууль,

ЗХУ-ын Одессын Их Сургууль

БНУУ-ын Будапештийн Их сургуулийн аспирантур

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

1983 онд Унгарын ШУ-ны Академид “Монгол орны *Agropyron cristatum* L-ийн популяциудын кариотипийн онцлог” сэдвээр Биологийн ухааны дэд доктор,

2010 онд Монголын ШУ-ны Академид “Монгол хүн амын дунд тархсан хедатитийн В,С,Д вирусн молекул генетик онцлог” сэдвээр Биологийн шинжлэх ухааны доктор

Эрхэлсэн ажил:

1976 оноос эдүгээ хүртэл ШУА-ийн Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэн, Биотехнологийн хүрээлэн, Биологийн хүрээлэнд Эрдэм шинжилгээний ажилтан, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, ШУА-ийн Биологийн Бага чуулганы дарга, Лабораторийн эрхлэгч

Унгар улсад ажилласан газар:

1979-1983 онд Унгарын Байгалийн түүхий музейн Ботаникийн салбар

1984-1987 онд Сегедийн Биологийн судалгааны төвийн Биохимийн хүрээлэн

Гавьяа, шагнал:

2000 онд Шинжлэх ухааны тэргүүний ажилтан

2022 онд Монгол улсын ШУА-ийн дээд шагнал “Хубилай Хаан” алтан медаль

2022 онд “Алтан гадас” одон



ЦЭДЭВИЙН ӨНӨРБАЯН

Боловсролын зэрэг, цол:

Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, 1990 онд дэд профессор, 1998 онд профессор цол, 2011 онд БНХАУ-ын Өвөр Монголын Багшийн их сургуулийн хүндэт профессор цол хүртсэн.

Төгссөн сургууль:

1957 - 1961 онд Увс аймгийн Хяргас сумын бага сургууль

1961 - 1967 онд Увс аймгийн Баруунтуруун сумын 10 жилийн бүрэн дунд сургууль

1967 - 1971 онд Улсын багшийн дээд сургуулийн Монгол хэл, уран зохиолын багшийн анги төгссөн багш мэргэжил эзэмшсэн.

1976 - 1977 онд Оросын Холбооны Улсын Москвагийн их сургуульд хэл шинжлэлийн чиглэлээр сурсан.

1984 - 1986 онд Унгарын Шинжлэх ухааны академид аспирантурт суралцаж төгссөн.

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

1986 онд Унгарын Шинжлэх Ухааны Академид “Орчин цагийн монгол хэлний залгаврын аргаар үйл үг бүтэх ёс” сэдвээр доктор (Ph.D) зэрэг хамгаалсан.

1988 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнд “Орчин цагийн монгол хэлний хэлзүйн үгийн тогтолцоо” сэдвээр доктор (Sc.D) зэрэг хамгаалсан.

Эрхэлсэн ажил:

1971 - 1983 онд Улсын Багшийн дээд сургуулийн Монгол хэлний тэнхимд багш

1984 - 1987 онд Унгарын Өтвөш Лорандын шинжлэх ухааны их сургуулийн Төв Азийн тэнхимд зочин багш

1987 - 1996 онд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Монгол хэлний тэнхмийн эрхлэгч

1996 - 2014 онд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал

2014 оноос өнөөг хүртэл МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол судлалын төвийн эрхлэгч

Гавьяа шагнал:

1999 онд Шинжлэх ухааны тэргүүний ажилтан

2000 онд Монгол Улсын Гавьяат багш цол

2009 онд Английн Кембриж дэх Дэлхийн намтар судлалын төвөөс “Дэлхийн тэргүүлэх сурган хүмүүжүүлэгч” цол, тэмдэг

2016 онд Монгол Улсын Ардын багш цол

2021 онд Унгарын Төрийн дээд “Хүлэг баатрын загалмай” одонгоор шагнагдсан.

РАДНААСҮМБЭРЭЛИЙН ГОНЧИГДОРЖ



Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Математикч, Физик-Математикийн доктор (Ph.D), Математикийн шинжлэх ухааны доктор (Sc.D)

Төгссөн сургууль:

1975 онд Монгол Улсын Их Сургууль

1981 онд Новосибирскийн (ЗХУ) Их Сургуулийн аспирантур

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Многообразия ассоциативных алгебра с дистрибутивным произведением” (Ph.D), (ЗХУ); “Direct Product and Sheaf Representation of Rings and Theire Quotient Rings” (Sc.D), (Унгар).

Эрхэлсэн ажил:

1975-1988 онд МУИС-д багш

1988-1990 онд ШУА-ийн Математикийн хүрээлэнгийн захирал

1990-1992 онд Монгол Улсын дэд Ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын дарга

1992-1996 онд УИХ-ын гишүүн

1996-2000 онд УИХ-ын дарга

2004-2008, 2008-2012, 2012-2016 онуудад УИХ-ын гишүүн

2013-2016 онд УИХ-ын дэд дарга

2016-2020 онд УИХ-ын дэд даргын зөвлөх

Сонгуульт ажил:

1994-2000 онд Монголын Социал Демократ Намын дарга

2004-2006 онд Ардчилсан Намын дарга

Гавьяа шагнал:

Төрийн дээд “Чингис Хаан” одон, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн.



ЗУРМАНЫ ЦЭРЭНДОРЖ

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Геологийн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

Унгар улсын Мишкольц хотын Хүнд Үйлдвэрийн Их Сургууль (*Nehezipari Muszaki Egyetem*)

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Монгол орны Говийн бүсийн газрын доорх усны томоохон хуримтлалуудын гарал үүсэл, тархалтын зүй тогтол”

Эрхэлсэн ажил:

1978 - 1988 онд Геологи Уул Уурхайн Үйлдвэрлэл Шинжилгээний Институтэд эрдэм шинжилгээний ажилтан

2000 - 2021 онд Унгар улсын “Eszak Magyarorszagi Regionalis Vizmu” Zrt-д инженер

2000 - 2021 онд Монгол, Унгарын хамтарсан “Дунар-Од” ХХК-ийн Захирал

Гавьяа, шагнал:

Алтан гадас одон, Хөл бөмбөгийн спортын мастер.



ЖАГВАРАЛЫН ХАСБОЛД

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Дээд, Биологи Иммунологич, Биологийн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

Улаанбаатар хотын 1-р 10 жилийн сургууль,
ЗХУ-ын Москвагийн Их Сургууль, Биологийн факультет
Унгарын Өтвөш Лорандын Их сургуулийн аспирантур

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

1989 онд Унгарын ШУ-ны Академид “Иммуноглобулины биологийн идэвхтэй хэсгүүд дархлаанд модуляц хийх чадварыг ин витро судлах нь” сэдвээр Биологийн ухааны Ph.D хамгаалсан.

Эрхэлсэн ажил:

1977-1989, 1995-1997 онуудад ШУА-ийн Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэн, Биотехнологийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, лабораторийн эрхлэгч

1990-1994 онуудад Их Британи улсын Үндэсний Анагаах Ухааны хүрээлэнд (NIMR, Mill Hill, London) эрдэм шинжилгээний ажилтан

1997-2001 онуудад Хорт хавдар, эсийн биологийн хүрээлэнд (Centenary Institute of Cancer Medicine and Cell Biology, Sydney, Australia) эрдэм шинжилгээний ажилтан

2002-2012 онуудад Валтер Элиза Халлын нэрэмжит Анагаах Ухааны хүрээлэнд (Walter and Eliza Hall Institute of Medical Research, Melbourne, Australia) эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Унгар улсад ажилласан газар:

1982-1987 онд Унгарын Өтвөш Лорандын Их сургуулийн Иммунологийн лаборатори

1978-1979 онд Сегедийн Биологийн судалгааны төвийн Эсийн биологийн хүрээлэн



ЖАМБАЛСҮРЭНГИЙН БАТЗАНДАН

Эрдмийн зэрэг, цол:

Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль, мэргэжил:

1992 онд Сүхбаатар аймгийн 10 жилийн сургууль

1993 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль

1994 онд БНУУ-ын Будапешт хотын хэлний бэлтгэлийн дээд сургууль

1999 онд БНУУ-ын Мицкольцийн их сургуулийг Улс төр судлал, эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн.

2000 онд БНУУ-ын Мицкольцийн их сургуульд Захиргааны эрх зүй, Нийтийн эрх зүй, Захиргааны шүүхийн чиглэлээр харьцуулсан судалгаа хийж, докторын зэрэг хамгаалсан.

Ажилласан байдал:

1999- 2004 онд Унгар улсын их сургуульд судлаач багш

2004- 2006 онд Их засаг их сургуульд эрдэмтэн багш, эрдмийн зөвлөлийн гишүүн

2006- 2008 онд Иргэний хөдөлгөөний тэргүүн

2006- 2010 онд Иргэний хөдөлгөөний намын дарга

2010- 2012 онд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн

2011- 2012 онд “Эрдэнэс Таван толгой” Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

2012- 2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн

2021-2022 онд Австрали дахь Элчин сайдын яаманд Зөвлөх

ДОРЖГОТОВЫН ДӨЛГӨӨН



Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Биологийн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

1991-1992 онд МУИС, Биотехнологи

1992-1993 онд Унгар хэлний бэлтгэл, Будапешт

1993-1999 онд Унгарын Сегедийн их сургууль, Биотехнологи, молекул биологи, магистр

1999-2002 онд Унгарын Сегедийн их сургууль, Биотехнологи, молекул биологи, Биологийн ухааны доктор (Ph.D)

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Rop-GTPase-тай харилцан үйлчилдэг рецептор төст киназуудын ялган авах болон функцийг тодорхойлох”

Эрхэлсэн ажил:

2010 оноос хойш ШУТИС, УТС, Хүнсний биотехнологи шим тэжээлийн салбар сургуульд ахлах багш

2007-2010 онд Бай Золтаны нэрэмжит Ургамлын геном, хүний биотехнологийн эрдэм шинжилгээний хүрээлэнд Эрдэм шинжилгээний ажилтан

2003-2007 онд Унгар улс, Унгарын Шинжлэх Ухааны Академийн харьяа Сегедийн Биологийн Эрдэм Шинжилгээ Судалгааны Төвд Эрдэм шинжилгээний ажилтан

Туурвисан бүтээлийн дээж:

Гарын авлага:

Ц.Энхтуул, С.Дэлгэрмаа, Д.Дөлгөөн “Хөрөнгөний бичил биетний судалгааны арга, аргачлал”. 2 дахь хэвлэл, Улаанбаатар: Алмаз пресс хэвлэлийн газар, 2018, 8 х.х.

Зохиогчийн эрх:

Ц.Энхтуул, С.Дэлгэрмаа, Д.Дөлгөөн “Хөрөнгөний бичил биетний судалгааны арга, аргачлал, Зохиогчийн эрхийн гэрчилгээ №10745, 2019.06.28-ны А/105 дугаар тушаал



ЦЭРЭННАДМИДЫН РЭНЦЭНХАНД

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Биологийн ухааны доктор (Ph.D), эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

Төгссөн сургууль:

1983-1984 онд Унгар улсын Будапештийн Олон улсын хэлний бэлтгэл

1984-1990 онд Унгар улсын Сегедийн Их Сургууль (хуучнаар Jozsef Attila Tudományi Egyetem)

2009-2011 онд Унгар улсын Сегедийн Их Сургуулийн Микробиологийн тэнхим, Биологийн ухааны доктор (Ph.D)

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Effect of essential oils and their combinations on food spoilage microorganisms”

“Illóolajok és kombinációk hatása élelmiszerromlászt okozó mikroorganizmusokra”

Эрхэлсэн ажил:

1990 оноос ШУА-ийн Биологийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан

2011 оноос ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

2015 оноос ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Микробын нийлэгжлийн лабораторийн эрхлэгч

Туурвисан бүтээлийн дээж:

Tserennadmid R., Tako M., Galgoczi L., Papp T., Miklos P., Vagvolgyi Cs., Almassy K.,Krisch J. (2011) Anti yeast activities of some essential oils in growth medium, fruit juices and milk. International Journal of Food Microbiology. 144; 480-486.

Judit Krisch, Rentsenkhand Tserennadmid, Csaba Vagvölgyi: (2012) Interaction of essential oils and food components: consequences in food preservation. In: Luca Valgimigli (ed.) Essential Oils as Natural Food Additives. Composition, applications, antioxidant and antimicrobial properties. Book series: Advances in Food Microbiology and Food Safety” ISBN: 2152-2006, Nova Publishers, Inc. N.Y., USA, pp. 361-377.

Ажиллах хугацаандаа олон улсын болон дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл -56, номын бүлэг, товхимол -5, эмхэтгэн хэвлүүлж, редакторласан бүтээл -12, эрдэм шинжилгээний илтгэл 25-ийг хэлэлцүүлж, Оюуны өмчийн патент -13, Зохиогчийн эрхийн гэрчилгээ -1, технологийн заавар -9, Монгол Улсын Стандарт 3-ыг бичиж батлуулсан байна.

Гавьяа, шагнал:

БСШУЯ-ны Жуух бичиг, Шинжлэх ухааны Тэргүүний ажилтан, Байгаль орчны Тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медаль, Монгол улсын “Шинийг санаачлагч” цол тэмдгээр шагнагдсан.



ДОРЖИЙН ЛХАГВАСҮРЭН

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

- 1993-1998 он Увс аймгийн Хяргас сумын 8-жилийн дунд сургууль
- 1998-2000 он Нийслэлийн 97-р дунд сургууль
- 2000-2002 он Намдолдэчэнлин хийдийн дэргэдэх шашны бага сургууль
- 2002-2007 он Энэтхэг улсын Дрепунг Гоман буддын гүн ухааны их сургууль, Буддын гүн ухаан судлаач
- 2008-2013 он Монголын бурхан шашны дээд сургуульд “Буддын гүн ухаан”-ны бакалавр
- 2014-2015 он Монголын бурхан шашны дээд сургуульд, “Эх бичиг судлал”-ын магистр
- 2015-2020 он Унгар улсын Элтэ их сургууль, “Хэл шинжтэлийн ухаан”-ны доктор (PhD)
- 2017-2019 он Улаанбаатарын их сургууль, “Түүхийн ухаан”-ны доктурант
- 2017-2019 он Унгар улсын Корвинусын их сургууль, “Олон улсын харилцаа, аюулгүй байдлын шинжээч” магистр
- 2019-2020 он Унгар улсын Элтэ их сургууль, Унгар хэлний бэлтгэл
- 2020-2021 он Унгар улсын Элтэ их сургууль, Хятад хэлний тэнхимд тус тус суралцсан.
- 2022-Хүмүүнлэгийн их сургуулийн харьяа Билиг дээд сургууль, Эрх зүйч, бакалавр

Ажилласан байдал:

- 2007-2008 он Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх буддын гүн ухааны Гунгаачойлин, Дашчоймпэл дацангийн багш
- 2007-2012 он Намдолдэчэнлин хийдийн ловон лам
- 2012-2014 он Намдоллин хийдийн ловон лам
- 2014-2015 он Гандантэгчэнлин хийдийн хамба ламын туслах
- 2016-Унгар улсын Элтэ их сургуульд багш
- 2017-Унгар улс дахь Будда Дарма монголын соёлын төвийн тэргүүн
- 2017-Дэлхийн Буддын шашны дээд чуулганд /World Buddhist summit/ Унгар улсыг төлөөлөгч
- 2021-Монголын бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн гадаад харилцаа хариуцсан ажилтан, Тэргүүн хамба ламын нарийн бичгийн дарга
- 2021-Монголын бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Өндөр гэгээн Занабазрын нэрэмжит Бурханы шашны дээд сургуулийн багш

Гишүүнчлэл:

- Олон улсын Монгол судлалын холбоо
- Кирёши Чомогийн нийгэмлэг
- Дэлхийн буддын шашны дээд чуулганы албан ёсны гишүүн /Унгар улс/

Гадаад хэлний мэдлэг: Төвөд, Англи, Унгар, Хинди, Хятад



ӨӨЛДИЙН АМАР

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Эдийн засагч, Бизнесийн удирдлага, менежментийн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

2005 онд Ховд аймгийн 10 жилийн 1-р дунд сургууль, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай анги

2009 онд Монгол улсын их сургууль, Эдийн засгийн сургууль (хуучин нэрээр)

2011 онд Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Эдийн засаг, бизнесийн сургууль

2021 онд Унгар улсын Хөдөө аж ахуй, Амьдралын ухааны их сургууль (хуучнаар Сент Иштван их сургууль)

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Монгол Улсын хүнсний ногоо тариалдаг өрхүүдийн үйлдвэрлэлийн үр ашиг болон Армингтоны орлуулалтын мэдрэмжийн шинжилгээ”

Эрхэлсэн ажил:

Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Эдийн засаг бизнесийн сургуулийн Хөдөө аж ахуй, хэрэглээний эдийн засгийн тэнхимийн ахлах багш



АНДРЕЙН БУЛГАН

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Хөдөө аж ахуйн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

1996 онд Улаанбаатар хотын 10 жилийн 31-р дунд сургууль, 2000 онд Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургуулийг Ургамал зүйч-Агрономич мэргэжлээр, 2003 онд Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургуулийг Хөдөө аж ахуйн магистрын зэрэг, 2021 онд Унгар улсын Хөдөө аж ахуй, амьдралын ухааны их сургууль (хуучнаар Сент Иштван их сургууль)

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Улаан лоолийн ашигт бодисын агууламжинд усалгааны нөлөө”

Эрхэлсэн ажил:

2000-2003 онд Хөдөө аж ахуйн их сургууль, Экологи технологи, хөгжлийн сургууль, Шинжлэх ухаан технологийн төсөлд эрдэм шинжилгээний ажилтан, 2003-2005 онд Арьсны өвчин судлалын төв, Харшил судлалын лаборатори, Шинжлэх ухаан технологийн төсөлд биологич, 2005 оноос өнөөг хүртэл Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн Бэлчээр тэжээллэг, химийн тэнхимийн багшаар ажиллаж байна.

Гавьяа, шагнал:

2015 онд Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан



БАТ-ЭРДЭНИЙН ОЮУНТОГТОХ

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Биологийн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

2016 онд АНУ-ын Атлантикийн Олон Улсын Их Сургууль, 2016 онд МУ-ын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, 2021 онд Унгар улсын Хөдөө Аж Ахуй, Шинжлэх Ухааны Их Сургууль (Magyar Agrár- és Élettudományi Egyetem)

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Өргөст хэмхийн суулгацад силикатын нөлөөг молекул генетикийн түвшинд судалсан дүн” сэдвээр Биологийн ухааны докторын зэрэг хамгаалсан

Эрхэлсэн ажил:

2013-2017 онд Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан,

2021 оноос хүртэл Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн Ой хамгааллын лабораторийн эрхлэгч

Гавьяа шагнал:

2016 онд Нэрт эрдэмтэн Д.Цэрмаагийн нэрэмжит Эрдэм Шинжилгээний бага хурлын дэд байр,

2016 онд Докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл,

2017 онд “Тэргүүний залуу” Алтан медаль

ОДГЭРЭЛИЙН ХОНГОРЗУЛ



Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Биологийн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

2005-2009 онд МУИС, Биологийн факультетийн Биохими-Биоорганик химийн тэнхимд бакалавр,

2011-2013 онд МУИС, Биологи-Биотехнологийн сургуулийн Ургамал судлалын тэнхимд магистр,

2018-2022 онд Унгарын Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Ургамлын шинжлэх ухааны сургуульд Докторын зэргээр сурч төгссөн.

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Эрт ургацын төмс (*Solanum tuberosum* L.) гарган авах боломж, түүний молекул генетик, метаболитийн судалгаа”

Эрхэлсэн ажил:

2011 оноос Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэнгийн Ургамлын биотехнологийн лабораторид эрдэм шинжилгээний ажилтан



БАДГАРЫН ХАНДСҮРЭН

Боловсрол, эрдмийн зэрэг, цол:

Мал аж ахуйн ухааны доктор (Ph.D)

Төгссөн сургууль:

2004 онд Завхан аймгийн Цагаанхайрхан сумын 8 жилийн сургууль,

2005 онд Завхан аймгийн “Тэгш хэм” 10 жилийн сургууль,

2009 онд Хөдөө аж ахуйн их сургууль, Малын их эмч,

2014 онд Хөдөө аж ахуйн их сургууль, Мал эмнэлгийн ухааны магистр,

2022 онд Унгар улсын Дебрецен их сургууль, Мал аж ахуйн ухааны доктор

Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв:

“Studying the toxicity and testing of nanosize elemental selenium”

Эрхэлсэн ажил:

2010-2015 онд Мал эмнэлгийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан,

2015 оноос Хөдөө аж ахуйн их сургууль, Мал эмнэлгийн сургуульд багш



УНГАР, МОНГОЛ УЛСЫН ШУА-УУД ХООРОНД **ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД**



ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал,
доктор, дэд профессор **Ц.ЦЭРЭНДОРЖ**



МЭНДЧИЛГЭЭ

Монгол, Мажар хоёр улс өнө эртнээс хэлхээ холбоотой явж ирсэн билээ. Монгол нутгаас өрнө зүгт нүүдэллэсэн хүннүчүүд мажаруудын өвөг дээдэс болсон гэж эрдэмтэн судлаачид таамагладаг. Түүнээс арай хожуу мөн л Монгол нутгаас нүүдэллэсэн жужан буюу аварчууд мажар үндэстэн бүрэлдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж бас үздэг. Монгол, мажар хэлний ижил төстэй үг хэллэг зэрэг нь энэхүү таамаглал ор үндэсгүй зүйл бус гэдгийг харуулж байна гэлтэй. Монголын эзэнт гүрний үед монголчууд мажарчуудтай шууд харилцах болсноос хойш ХХ зуун болоход хоёр орны харилцаа улам нягт цэцэглэн хөгжсөн билээ. Эртний угсаа гарал, түүхийн хэлхээ холбоотойгоос шалтгаалсан уу, Мажар улсад монгол судлал өндөр түвшинд хөгжиж, олон монголч эрдэмтэд Мажараас төрөн гарч, Европ дахь монгол судлалын томоохон төв болжээ. Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн Мажарын монголч эрдэмтэдтэй эртнээс харилцаж, хамтарсан судалгаа явуулж ирсэн бөгөөд Мажарын эрдэмтэд Монголын түүх, археологи, угсаатны зүйн чиглэлээр олон эрдэм

шинжилгээний бүтээлийг туурвисан, эдүгээ ч туурвисаар байна. Манай хүрээлэн энэ онд Мажарын Элтэ Их сургуулийн Монгол судлалын төвтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан агаад цаашид түүх, угсаатны зүй, археологийн талаар илүү идэвхтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Миний хувьд 15, 16-тай хүүхэд байхдаа мажар хэлийг бие даан сурахыг оролдож байснаа эргэн дурсахад сонин байна. Монгол хэл дээр сурах бичиг байхгүй тул өөр гадаад хэлээр дамжуулан сурахыг оролдсон зэргээс үүдэн олигтой үр дүнд хүрээгүй ч одоо хүртэл хэдэн мажар үгийг марталгүй санаж явдаг юм. Цаашид Монгол, Мажар хоёр орны хамтын ажиллагаа, тэр тусмаа эрдэм судлалын хамтын ажиллагаа улам цэцэглэн хөгжиж, энэ үйл хэрэгт Мажарын түүхч, археологич, угсаатны зүйч тэргүүтэн монголч эрдэмтэд, манай хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид ихээхэн хувь нэмэр оруулна хэмээн итгэж байна.

Монгол, Мажарын хамтын ажиллагаа улам цэцэглэн хөгжих болтугай! Көсөнөм.

УНГАР ДАХЬ МОНГОЛЫН СОЁЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Зүүн Европын олон улсууд, тэр дундаа Мажарууд өөрсдийгөө угсаа гарлын хувьд Азиас гаралтай гэж үзэх нь бий. Учир нь тэд нэлээд удаан хугацаагаар нүүдэллэн амьдарч, тал нутагт мал аж ахуй эрхэлдэг байсан зэргээрээ монголчуудтай адилавраас гадна хэлний хувьд мажар, монгол хэлүүдэд хоёр хэлний адил буюу “дундын үг” олон байдгийг ч анхааран үзсэн байдаг.

Мажарууд VIII-IX зууны үед Карпатын уулсын хөндийн их талд нүүдэллэн очиж суурьшин, бие даасан үндэстэн болж бүрэлдсэн ба НТ 1000-аад оны үед Христийн шашинтай болсон гэж үздэг.

Дундад зууны үед Унгарын хаант улс нь Европын хамгийн хүчирхэг гүрний нэг байсан бөгөөд Азийг Европтой холбосон худалдааны замууд түүгээр дамжин өнгөрдөг байв. Эрх баригч Арпад нь Аттилагийн удмаас гаралтай байв. Гэгээн Иштван хаан болон Гэгээн Ласло зэрэг унгарын хаад, тэдний хан хүү болон гүнж нарыг ч Ромын хамба лам ариусгаж, гэгээн болгосон. Ийм учраас Аттила хааны удмынхан Христосийн сахиустай болсон гэсэн үг. Унгаруудын анхны үндсэн хууль нь Скифийн нутагт байгуулсан анд бололцох ёс бөгөөд дараа нь 1222 онд гаргасан “Алтан Булаа” байсан гэж унгарын судлаачид үздэг. 13-р зууны 20-аад оны сүүлээр II. Эндрэ хаан эрх мэдлээ зүүн тийш тэлэхээр Куманчуудын удирдагчдыг хүлээн авч, монголчуудын дайралтад өртөхгүйн тулд Унгарын хаант улсын нутаг дэвсгэрт орохыг хүсч, Христийн шашныг хүлээн зөвшөөрөн тангараглав. Куманчуудын дотор

Христосийн номлолын үйл ажиллгааг Доминиканы лам нар хийсэн бөгөөд тэд Куманчуудаас дорно зүгт үлдсэн Унгаруудын талаар сонссон юм. Ингээд Юулианы лам болон хамтрагчид нь 1235 онд анх удаа Унгарын ууган нутаг болох Кавказ руу явж, дараа нь хойшоо эргэн Болгарын хотын ойролцоох (Казань хотын ойролцоо) унгаруудыг олжээ. Мөн Юулиан ламын тэмдэглэлд монголчуудын тухай дурдсан байдаг. 1237 онд Юулианы лам Монголын Бат хаанаас Унгарын Бэла хаанд захидал авчирчээ. Тэр захидалд, Монгол хаан хэрвээ Куманчуудыг өөрт нь шилжүүлэн өгөхгүй бол Унгарын хаан руу дайрна гэж сүрдүүлсэн. 1241 оны 4-р сард Монголын арми Унгарын хаант улс руу довтолсон ба өдгөө түүхийн дурсгал болсон Мухийн тал нутагт Бэла хааны цэрэг ялагдав. Тулалдааны үеэр амиа алдсан цэргүүдийн цогцсыг бөөнөөр нь булшлав. Тэр үед энэ газар цэргийн цогцоснууд овоорч бөөгнөрснийг далимдуулж, баян хүмүүс эд хөрөнгөө тэнд нууж байсан нь илэрсэн байдаг. Тэндээс араб мөнгө гэх мэтээс гадна мэдээж цэргийн зэр зэвсэг, сэлэм дуулга ч ихээр илэрсэн. Эдгээр дурсгалууд Унгарын Үндэсний Музейд хадгалагдаж байдаг бөгөөд 2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойл зориулан Европын олон орон үзэсгэлэн гаргасны жишгээр “Чингис хаан” нэртэй үзэсгэлэнг гаргажээ. Тэр үед Унгарын Бэла хаан Батын байлдан дагууллаас зугтаж, Унгарын газар нутгийн нэгээхэн хэсэг байсан Хорват руу явсан. Тэрээр монголчууд манай нутгаас явбал өөрийн охиныг лам болгож, сүм барина гэж тангараг

тавьсны дагуу нутагтаа эргэж ирээд сүм барьсан байдаг. Монголчуудын довтолгооноор бүх юмс эвдэрч сүйдсэн ч уулан дээрх цэргийн бэхлэлт цайз нь хэвээрээ байв. Цайзаас эхлэн улсаа дахин цэгцлэн байгуулсан нь 1000-аад он юм. Унгар улсыг байгуулснаас хойших Унгар улсын хоёр дахь удаагийн цэцэглэн хөгжилт эндээс эхэлсэн гэж үздэг.

Монголчууд тэрхүү тулалдаанд ялсан боловч Унгарын хаант улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь эзэлж чадаагүй. Тийм ч учраас Бат хаан улс орноо орхихоор шийджээ гэсэн хэдий ч довтолгоог зогсоогоогүй, харин Балканы хойгт үргэлжилж, 1243 онд Каспийн нуурын эрэгт буцаж ирэв. 1285 онд Алтан Ордын нөлөө бүхий удирдагч Ногай армитайгаа Унгар руу довтолсон боловч энэ довтолгоо амжилтгүй болсон. Хожим нь Бат хааны байгуулсан Алтан Орд Унгарын хаант улстай эвтэй найртай харилцаа тогтоохыг эрмэлзэж байв. Хоёр гүрний хувьд худалдааны харилцаа сайн хөгжиж, Хар тэнгисийн бараа бүтээгдэхүүнийг Унгараар дамжуулан Европын баруун хагаст хүргэж байв. Османы дайралтаас үүдэн хоёр талын харилцаа тасарсан.

Хоёр улс түүх, соёлын эртний өв уламжлалтайн дээр Унгар улсад Монголын холбогдолтой эд өлгийн болоод оюуны соёлын өвүүд цөөнгүй байдаг нь дээрх мэт өөрсдийн өвөг дээдэс, уугуул нутгаа хайсан аялагч, судлаачдын үйл ажиллагааны үр дүнд бий болсон ажээ.

XIX зууны үеэс Унгар хүмүүс Монголд цөөнгүй тохиолдлоор ирсэн нь олон шалтгаантай. Урьдын адил

уугуул нутгаа хайн явсан аялагчид, газар зүйн нийгэмлэгийн судлаачид, дэлхийн I дайны дараагаар цөлөгдөгсөд гээд янз бүр байлаа.

Унгарын газар зүйн нийгэмлэгийн анхны судлаачид өөрсдийн адал явдалдаа хөтлөгдөн бараг хөрөнгө мөнгөгүйгээр Төв Ази ба Монголоор аялсан байдаг. Тэдний нэг нь Унгарын анхны түвд судлаач Александр Чома Көөрөши (Alexander Csomo de Körös) бөгөөд Түвдийн хийдүүдийг дамжин долоон жил амьдарч, Түвд-Англи толь бүтээж, Ганжуур, Данжуурыг дэлхийд танилцуулжээ. Тэрбээр Монголоор аялаагүй ч түвд 3000 гаруй бар, гар бичмэлийг авчирсан нь одоо Унгарын ШУА-д хадгалагдаж байна.

1871-1873 онд Унгар улсын эрдэмтэн Балинт Габор (1844-1913) Халимаг ба Их хүрээ зэрэг газар нутгаар зорчин явж түүх, угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүн цуглуулахын сацуу аман зохиол, тэр дундаа монгол ардын дуу, үлгэр, зүйр цэцэн үг, оньсого, аман түүх зэргийг сурвалжлан цуглуулж, эмхлэн боловсруулсныг Унгарын монгол судлалын нэгэн шан татсан гэж үзүүштэй. Тэрээр Өргөөд 155 хоног байсан ба Консулын дэнж дээр нэгэн ламын гэрт амьдарч, олон зүйлийг тэмдэглэн авсны сацуу тэр цагийн халх аялгууны анхны галигийг хийсэн хүн билээ³. Бас олон зүйлийн эд өлгийн зүйлсийг авч явсан боловч ихэнх хэсэг нь замдаа алга болжээ.

Түүнээс хойно Стэйн (Sir Aurel Stein) хэмээх аялагч, судлаач 1903-1908 онуудад Торгоны зам дагуу Туркестан, Турфанд судалгаа хийж, Дунхуангийн агуйгаас уг газар нутгийн талаарх түүхийн маш ховор нандин

3 Балинт Габор. 2016. Чингис хааны цагаан сэтгэлт ард түмэн, Эмхэтгэн гаргасан Бирталан Агнеш, Улаанбаатар

материалуудыг олж авсан ба тэдгээр нь Төв Азийн түүхийн судалгааны суурь болсон. Түүнчлэн олон зүйлийг авч явсан ч хожим нь тэдгээрээсээ нэлээдийг Англичуудад зарсан байна. Гэсэн хэдий ч дараагийн судлаачдад мөнгө хөрөнгөөр тусалж байжээ.

Дэлхийн I дайны дараагаар Сибирьт цөлөгдсөн зарим мажар хүмүүс тухайн үеийн ЗХУ-тай олон талын харилцаа бүхий Монгол улс руу иржээ. Тийм хүмүүс цөөн бус байсан ч нэр ус нь үлдсэн нь цөөн юм. Жозеф Гелета (Joseph Geleta) хэмээх мажаар хүн 1920-1929 онуудад Нийслэл хүрээнд амьдарч байсан агаад “Бөмбөгөр ногоон театр”-ын зураг төсөл, цахилгаан, сантехникийн ажил зэргийг нь хийжээ. Тэрээр монголчуудын жирийн ахуй амьдралын тухай дурсамж бичиж үлдээсэн нь эдүгээ ч үнэ цэнтэй зүйл билээ. Монгол дахь үйл ажиллагааныхаа талаар Ласло Форбат "Монголын шинэчлэл" гэсэн номондоо бичжээ.

Мөн тэр цагт Радноти Андор (Andor Radnoti Roth) гэдэг эмч хүн нийслэлд амьдарч, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нартай сайн харилцаатай байсан учир монголчуудын соёл ахуйг харуулсан гэрэл зураг авах зөвшөөрөл⁴ авчээ. Түүний 1922 оны орчим авсан нийт 66 гэрэл зураг өдгөө Унгарын Угсаатны зүйн Музейд хадгалагдаж байна. Эл зургууд дотор лам нарын бясалгалын жодгор, цам, майдар эргэх ёслол зэргийн зураг байхаас гадна Жалханз хутагт гэх мэт түүхэн хүмүүсийн зураг ч бий.

Үүнчлэн XX зууны тэргүүн хагасаас Унгар улсын Шинжлэх Ухааны

Академийн жинхэнэ гишүүн Лигети Лайош Будапештийн их сургуульд Монгол ба түвд хэл соёлын үндсэн (majority) ангийг нээх, Унгарын Шинжлэх Ухааны Академийн номын санд монгол гар бичмэл, дармал бичигт ном судрын сан хөмрөг бий болгох, “Монголын нууц товчоо”, “Алтан товч” гэх зэрэг эртний сурвалж бичгийг судлах зэргээр монгол судлалын судалгааг улбаалж байжээ. Тэрээр 1928-1930 онуудад Өвөр Монголд шашин, сүм хийдийн түүх, аж байдлын тухай судалгаа хийсэн нь “Шар бурхад, шар хүмүүс”⁵ нэртэйгээр хэвлэгдэн гарсан. Мөн Афганистанд 1936-1937 онд явж, судалгаа хийж байв. 1956 онд эрдэмтэн Б. Ринчен докторын зэрэг хамгаалж, 1956-1957 онуудад Л.Лигетийн эрдмийн шавь нар болох монголч эрдэмтэн Көхалми Каталин (Katalin Köhalmi), Кара Дьөрдь (Хар Дорж/György Kara), Андраш Рона-Таш (András Róna-Tas) нарын хамт Баруун Монголын нутгаар явж, хээрийн шинжилгээ хийсэн байна.

Л.Лигети доктор Б.Ринченгийн болон Монголын улс төрийн эрх баригчдын бэлэглэсэн, өөрийн Өвөр Монголоос авчирсан зэрэг олон тооны монгол, манж бичиг дээрх судар сурвалжуудын каталогийг⁶ хэвлүүлсэн байна. Дараа үеийн монголч эрдэмтэд болох Шаркөзи Алиса, Бирталан Агнеш нар шавь нарынхаа хамт 1990-ээд оноос эхлэн монгол судлал, аман түүх (нутгийн аялгуу, аман соёл, монгол хэл бичиг, түүх)-ийн судалгаагаараа дэлхийн монгол судлалд үнэт хувь нэмрээ оруулсаар байгаа төдийгүй залгамж үе болсон залуу монголч

4 Уг зөвшөөрөлд цэрэг, улс төрийн сэдэвтэй зураг авахыг хоригложээ.

5 Ligeti Louis, *Yellow Gods, Yellow People*, 1934

6 Ligeti Louis, *The Mongol and Manchu Manuscripts and Blockprints in the Library of the Hungarian Academy of Sciences. Budapest, Academiai Kiado, 2000*

эрдэмтэд олноороо төрөн гарч байна.

Өнөө цагт дээр дурдсан их эрдэмтдийн цуглуулсан монгол судлалын холбогдолтой өвүүд болон дурсгалт зүйлс Унгар улсад хэд хэдэн газар хадгалагдаж байна. Тухайлбал,

Унгарын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн сан: Энд монгол бичгээрх судрууд (бэлгийн), Л.Лигетийн Өвөр Монголоос авчирсан судрууд, Александр Чома Көөрөшийн Түвдээс авчирсан ном судрууд⁷ хадгалагдаж байна. Монгол судруудаас “*Богд Чингис хааны цадиг оршвой*”, “*Хөтөл овоог тахихуй судар буй*” зэрэг судруудыг бусад судалгааны төвүүдэд байгаа адил төстэй эхүүдтэй нь харгуулан үзэж байна.

Түүхийн музей:

Энэ музейн XIII зууны үеийн тасагт монгол цэргүүдийн эдлэл хэрэглэл зэрэг байна.

Угсаатны зүйн музей: Вилмос (Dioszegi Vilmos) хэмээх угсаатны зүйчийн 1957-1964 онуудад Өмнөд Сибирээс Ар Монголд хийсэн бөө мөргөлийн судалгааныхаа үр дүнд авчирсан Дархад бөөгийн хувцас, бурханы шашны эд өлгийн зүйлс зэрэг байна. Тэрээр Монголын эрдэмтэн О.Пүрэвтэй хамтран ажиллаж байжээ.

Уг музей дахь бас нэгэн цуглуулга нь Ханс Лэдэрийн цуглуулга (Hans Leder Collection) юм. Тэрхүү Австри хүн Монголоос маш олон зүйлийн бурхны шашин болоод эдийн соёлын үнэт зүйлс авч явсан боловч дараа нь Герман, Австри, Унгар улсуудад заржээ. Түүний Унгарт зарсан зүйлс уг музейд хадгалагддаг ба харин Австрид

байгаа цуглуулгыг Мариа-Катерина Ланг⁸ хэмээх судлаач судлан, каталоги хэвлүүлсэн байна. Энд Монголын бурхны шашин, соёлын 700 гаруй эд өлөг багтжээ.

Хопп Ференцийн (Hopp Ferenc) нэрэмжит Дорно дахины урлагийн музей:

Энэхүү музейд Монголын бурханы шашны эд зүйлс, нүүдэлчдийн эдийн соёлын зүйлс олноор хадгалагдаж байна. Энд бурхны шашны 100 гаруй танка зураг, 10 гаруй зээгт наамал мөн олон тооны бурхдын баримал, шуумал бий. Эдгээрийн дотор Өндөр гэгээн Занабазарын дэг сургуулийн бурхад ч байна хэмээн судлаачид үзэж, судалж байна. Мөн Л.Лигетийн Өвөр Монголоос авчирсан олон тооны бурхад бий.

XX зуунд Унгар болон Монгол оронд адилхан социалист систем тогтож байсан учраас олон талаар хамтран ажиллаж иржээ. Тухайлбал, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамтран Дархан хотыг байгуулах, нийслэлд Био-комбинат, Мах-комбинатыг байгуулах зэрэгт Унгарууд манлайлан ажиллаж байжээ. Ийн ажиллаж байсан Унгар хүмүүсийн дурсамж, тэр үеийн монголчуудын гэрэл зургууд, ахуйн хэрэглээний зүйлс, уриа, лоозон гэх мэт зүйлс өнөөдөр ч хадгалагдаж байна. Эдгээрийг болоод мөн өнөө цагийн Унгаруудын (Атилла, Чингис хаан гэх мэт) дунд шинээр бий болж буй домгуудыг сонирхон судлууштай байна. Нөгөө талаас 1990-ээд оны үед монголчууд Унгар руу тарваганы арьс зөөж, ганзагын наймаа эрхлэх зэргээр харилцаж байв.

7 Orosz, Gergely, *A Catalogue of the Tibetan Manuscripts and Blockprints in the Library of the Hungarian Academy of Sciences*. [2 volume set], 2009

8 Lang, Maria-Katerina, *The Mongolian Collections. Retracing Hans Leder, Austrian Academy of Sciences, Vienne, 2013*

Харин шинжлэх ухааны хувьд хоёр орны судлаачид хамтран геологи, археологи болон бусад чиглэлээр олон арван төсөлд хамтран ажиллах болжээ. Эдгээрээс дурдвал,

- 1962 онд Монголын талаас археологич Ц. Доржсүрэн, Д. Наваан нар, Унгарын талаас Иштван Эрдели, Ласло, Ференц нар оролцож, Төв, Булган, Сэлэнгэ аймагт ажиллажээ⁹.
- Монголын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Унгарын ШУА-тай хамтарсан археологийн судалгааны баг 1974 онд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хүнүйн голын дагуу судалгаа хийсэн. Энэ багт Унгарын талаас И.Эрдели, Шугар Лаойш нар ажиллаж, олон арван дурсгалыг илрүүлж, гэрэл зургаар баримтжуулжээ. Тухайлбал, энэ судалгаагаар 10 буган хөшөө шинээр илрүүлжээ¹⁰.
- 1986 онд Монгол-Унгарын хамтарсан судалгааны баг Дундговь аймгийн Дэлгэрцогт, Дэрэн сумдад ажиллажээ. Энд Монголын талаас Д.Цэвээндорж, Унгарын талаас доктор Иштван Эрдели, дэд эрдэмтэн Янош Маккой нар оролцсон байна.
- 1987 онд мөн Монгол-Унгарын хамтарсан судалгааны баг Архангай аймгийн сумдад ажиллаж, Хүннүгийн үеийн дурсгалуудыг илрүүлсэн байна. Энэ судалгаагаар Хүннү нарын алтан ээмгийг олж, хүлээлгэн өгчээ.

Хоёр орны шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд 2020 онд “Унгар дахь Монголын

өв соёлын дурсгалууд”¹¹ бүтээлийг Монгол улсад хэвлүүлсэн юм.

Мөн хоёр орны ШУА-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс гурван судлаач Унгар улсын ШУА болон ЭЛТЭ их сургуульд ажиллаж, нэг оюутан Төв Ази ба Монгол судлалын тэнхимд докторын түвшинд суралцаж байна.

Тэрчлэн дээрх гэрээний дагуу Унгар улсын ШУА-ийн Угсаатны зүйн хүрээлэн (Szilágyi Zsolt), Монгол улсын ШУА-ийн профессор Л.Эрдэнэболдтой хамтран Киданы үеийн археологийн судалгааг хийж эхлээд байгаа юм.

Мөн Англи улсын номын сантай хамтарсан төслийн хүрээнд Унгар, Монгол улсын судлаачид Түүх, угсаатны зүйн хүрээлэнд хадгалагдаж буй гурван мянга орчим баримтыг цахим хэлбэрт оруулан, гарчиг сэлтийг др. Кристина Телеки англи хэлэнд хөрвүүлэн үйлдээд байна.

Одоогийн байдлаар ЭЛТЭ их сургуулийн “Монгол ба Төв Азийн тэнхим”-д ажиллаж, сурч буй судлаачдын судалгааны чиглэлийг тоймлож үзвэл,

1. Birtalan Ágnes (Sc.) - Монгол соёл, бурхны шашин, бөө мөргөл зэрэг
2. Teleki Krisztina (Ph.) - Монголын бурхны шашны аман түүх, Өргөө, Заяын хүрээний түүхийг судалсан. Хангай ханы сангийн судруудын талаар судалгаа хийж байна.
3. Avar Ákos (Ph.) Монголчуудын уламжлалт байгаль хамгаалал сэдвийн хүрээнд судалгаа хийхээс гадна Монголын Ботаникийн

⁹ Доржсүрэн, Ц., Монгол-Унгарын хамтарсан шинжилгээний ангийн урьдчилсан тайлан, ШУА-ийн Баримт, мэдээллийн төв, ХН-79, Т-123, 1962

¹⁰ Цэвээндорж, Д., 1974 онд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хүнүй голд ажилласан Монгол-Унгарын хамтарсан экспедицийн тайлан

¹¹ Ерөнхий редактор Бирталан Агнеш, Төслийн удирдагч Сампилдондовын Чулуун

цэцэрлэгт хүрээлэнтэй хамтран ажиллаж байгаа.

4. Füredi Zoltán (докторант) - Европ дахь монгол соёлыг шагайн харвааны жишээгээр судалж, мөн Монгол, Унгар харилцааны талаар баримтат кино хийхээр ажиллаж байна.
 5. Halász Ádám (докторант) - Орчин үеийн монголын түүх
 6. Fahidi Csaba (докторант)- Захчины аман зохиол
 7. Bán Kornélia (докторант)- Монгол адуу, морь
 8. Horváth Réka (оюутан)- Монгол, Төвөдийн харилцаа
- 2010-аад оны орчмоос Унгар улсын судлаачид Түүхийн хүрээлэнтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд өмнөх хугацаанд Хэл зохиолын хүрээлэнтэй

хамтран ажиллаж байсан түүхтэй.

Эдгээрээс товч дүгнэж үзэхэд, Монгол, Унгар хоёр улсын түүх, соёлын хувьд олон талаар харилцаж байсан харилцаа нь эртнээс буюу XIII зуунаас өнөөг хүртэл үргэлжилсээр буй чухал харилцаа юм. Иймээс цаашид шинжлэх ухааны олон талаар хамтран ажиллах, тус улсад буй зарим өвүүдийг судалгааны эргэлтэд оруулах зэрэг ач холбогдолтой ажлуудыг хийх нь чухал. Унгар улс нь монгол судлалын арвин уламжлалтай хийгээд өдгөө ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа цөөхөн улсуудын нэг учраас бид энэхүү найрсаг хамтын ажиллагааг улам бүр цэцэглүүлэн хөгжүүлэх нь зүйтэй билээ.


М.ЭНХБААТАР

*ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан*

МОНГОЛ-УНГАРЫН ХАМТАРСАН KHI-LAND ХЯТАНЫ ЛАНДШАФТ АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА ТӨСӨЛ

Монгол, Унгар улсын судлаачдын хамтарсан Хятаны археологийн судалгаа төслийг Унгарын Шинжлэх ухааны академийн Хүмүүнлэгийн судалгааны төвийн Угсаатны зүйн хүрээлэн, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн хамтран “Монгол, Унгарын хамтарсан судалгаа-Монгол дахь Хятаны археологийн судалгаа

2017-2023” нэртэйгээр хэрэгжүүлж байгаа билээ. Эл төсөл нь хоёр улсын эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжиж байгаа бөгөөд энэ хүрээнд Монгол улсын төв хэсэг Булган аймгийн нутаг дахь Хятаны үеийн дурсгалууд, тэр дундаа Дашинчилэн сумын нутагт буй Хар бухын балгаст археологийн судалгаа хийх ажил багтаж байгаа юм.



Энэхүү хамтарсан төслийн Монголын талын эрдэм шинжилгээний зохицуулагчаар академич С.Чулуун, хээрийн судалгааны ангийн судлаачаар археологич, профессор Л.Эрдэнэболд нар ажилласан бол, Унгар улсын

талаас археологич, профессор József Laszlovszky, угсаатны зүйч, доктор Zsolt Szilágyi, археологич, дорно дахин судлаач Katalin Tolnai, археологич доктор Csilla Siklód, газар зүйч András Harmath нар оролцон ажилласан болно.




Хятаны археологийн судалгаа төсөл нь Хятаны түүхэнд холбогдох дурсгалт газрууд, тэдгээрийн орчмын газар нутгийг тандан судалж, Ляо гүрний

нийгэм, улс төрийн зохион байгуулалт, түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийг танин мэдэх зорилготой.



Хэдийгээр Монгол дахь Хятаны үеийн хот суурингуудын нэлээдэд нь түүх, археологийн судалгаа хэдийнээ хийгдсэн боловч тэдгээр дурсгалын ойр орчим хийгээд орчин үеийн суурингуудтай хэрхэн холбогдож

байгаа талаар нарийвчилсан судалгаа одоогоор үгүй юм. Бид энэхүү төслийн хүрээнд Хятаны үеийн дурсгалт газруудыг судалж, эзэнт гүрний умард хязгаар дахь үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулахыг зорьж байна.



Унгарын шинжлэх ухааны академи 1950-аад оноос Дотоод Ази, Монгол судлалын судалгааг идэвхтэй явуулж ирсэн билээ. Уг ажлыг хэл шинжээч Лигети Лайош санаачилсан бөгөөд тэрээр мөн Хятаны хэл, түүхийн асуудлыг судалж байлаа. Түүний араас Жорж Кара, Андраш Рона-Таш нар мөн энэ чиглэлээр судалгаа хийсэн юм. Өнөө ч хятан бичгийн судалгааг тэрээр хийж байгаа билээ. Харин археологийн судалгаа арай хожимхон эхэлсэн агаад

Унгарын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн оролцоотой археологийн малтлага судалгааг явуулсан юм. Унгарын археологич Иштван Эрдэли 1961-1990 онд Монгол улсад хийсэн археологийн судалгааг нэр төртэй удирдсан билээ. Тэрээр хүрлийн үеэс дундад зууны үеийг хүртэлх Монголын түүхийн бүхий л үеийг судалж, Хүннүгээс Түрэгийн үе хүртэлх түүхийн судалгаанд дүн шинжилгээ хийсэн байдаг.

Түүний судалгааны зам мөрөөр Унгар, Монголын судлаачид Монгол улсын нутагт археологийн иж бүрэн судалгаа хийх зорилготой уг төсөл маань уялдаж байна. Ингэхдээ орчин үед ихээхэн үр дүнтэй ашиглагдаж байгаа Ландшафтын археологийн зарчимд тулгуурлан, зайнаас тандан судлах шинэ технологи ашиглаж байгаагаараа бидний судалгааны арга


зүй онцлогтой. Хэдийгээр төсөл маань Хятаны үеийн судалгаа боловч тухайн дурсгалт газар нутгуудтай холбоотой түүхэн бусад үеүдийн археологийн дурсгалуудыг цогцоор нь судлахад чиглэж байна. Чингэхдээ хүрлийн үеэс өнөөг хүртэл бүхий л цаг хугацааны тухай хүүрнэх түүхэн дурсгалуудыг илрүүлэн судлахыг зорьж байна.



Бид дурсгалт газруудыг ойр тойрны хүрээлэн буй орчин, уул, ус, байгальтай нь холбогдох байдлыг судлах зэргээр ландшафтын археологийн аргачлалаар судалгаагаа явуулж байна. Ингэхдээ тухайн бүс нутгийн гол мөрөн, нуур зэрэг усан хангамжийн системийн онцлог, мөн микро топографийн системтэй судалгаагаар тогтоож болох орчны дурсгалт газруудад (эртний хот суурингийн туурь, булш хиргисүүр, янз

бүрийн ердийн хөшөө чулуу гэх мэт) онцгой анхаарч ажиллаж байна.

Хамтарсан төслийн хүрээнд бид Хүннүгийн үеийн Зүрхийн үзүүр, Хятаны үеийн Хар бухын балгас, Улаан хэрэм, Хар бухын чулуун барилгууд болон Цогт тайжийн Цагаан байшин, Хэрлэн барс хот зэрэг дурсгалт газруудад түүх, археологийн судалгааг явуулсан юм.



Хээрийн судалгааны ажлын үр дүнгээс үзвэл, Хятан улсын түүхэнд холбогдох дээр дурдсан дурсгалуудаас гадна олон төрлийн дурсгалуудыг илрүүлсэн агаад тэдгээр нь үүрэг зориулалтын хувьд хоорондоо ялгаатай байсан нь мэдэгдэж байна. Тэдгээрээс бэхлэлт хэрэм бүхий суурингууд хамгийн их сонирхол татах бөгөөд агаараас авсан гэрэл зургуудаас хэрмийн доторх бүтэц зохион байгуулалтын хэсгийг сайтар харж болохоор байна. Эдгээр томоохон дурсгалуудын бүтэц, зохион байгуулалт, үүрэг зориулалтын талаар өмнө нь судлаачид нэлээд нарийн тодорхойлсон тул тэдгээрийн мэдээлэлд тулгуурлан илүү нарийвчилсан зураг, судалгааны материал цуглуулж, тэдгээрт дүн шинжилгээ хийх цогц арга зүйг ашиглалаа. Түүнчлэн томоохон бэхлэлт хэрэм бүхий хот суурины

дурсгалуудын ойролцоо тэдгээрийн дагуул шинжтэй жижгэвтэр, дөрвөлжин хэлбэртэй шавар хэрмийн тууриудыг шинээр нээн илрүүлж судалж байна.

Тэдгээрийн байршил, дотоод, гадаад бүтэц зохион байгуулалт янз бүр агаад эдгээр дагуул дурсгалууд өөр өөр үүрэг зориулалттай байсан нь тодорхой байна. Тухайлбал, зарим нь оршуулгын газрын зориулалттай байсан болов уу хэмээн таамаглаж байгаа ч тэдгээр дурсгалт газруудад нарийвчилсан судалгааг одоогоор хийгээгүй байна. Мөн шавар шороо дэлдэн үйлдсэн дөрвөлжин хэлбэртэй хэрмүүд байгаа боловч тухайн хэрмийн дотор булш, оршуулга эсхүл барилга байшингийн үлдэгдэл мэдэгдэхгүй байна. Тиймээс эдгээр хэрмүүд нь нь мал аж ахуйн зориулалттай юм уу, түр сууж байсан хүмүүсийн гадны

аюулаас хамгаалах хүрээ хашаа байсан болов уу гэсэн сэтгэгдэл төрж байна. Цаашид энэ талаарх нарийвчилсан судалгааг ландшафтын археологийн арга зүйн тусламжтайгаар явуулж (байгалийн болон хүний гараар бүтээгдсэн усан хангамжийн систем, газар ашиглалтын тогтолцоо, эрт үеийн тахилга шүтлэгтэй газрын онцлог гэх мэт) уг бүс нутгийн талаар ил нарийн мэдээллүүдийг тодруулах шаардлагатай байна. Хээрийн судалгааны үеэр дурсгалт газруудын хооронд, газрын гадарга дээрээс шавраар хийсэн ахуйн хэрэглээний болон барилгын материал хэрэглэгдэхүүнийг олон тоогоор олсон

нь тус газрууд ч мөн суурьшлын бүс байсан болов уу хэмээн таамаглахад хүргэж байна. Дурсгалт газруудын хооронд буй сул орон зайгаас илрүүлсэн хүний үйл ажиллагааг илэрхийлэх цөөн тооны зүйлсээр тухайн дурсгалт газруудын цаг хугацааг тодорхойлоход хүндрэлтэй. Түүврээр илрүүлсэн ахуйн хэрэглээний шавар эдлэлийн зарим үлдэгдлүүд нь Хятан нараас хойших түүхийн цаг үеийг илэрхийлэх бөгөөд зарим тохиолдолд бэхлэлт хэрэм бүхий суурингуудыг хожим нутгийн иргэд суурин амьдрах газар, малын хашаа, хороо, сүм хийд, тахилга шүтлэгийн газар болгож байсан нь дамжиггүй.



Хээрийн судалгааны үеэр бид зөвхөн археологийн судалгаа төдийгүй мөн орчин үеийн нүүдэлчдийн өдөр тутмын амьдралыг тодорхойлох, нутгийн ард түмний ахуй амьдралын уламжлалуудад ихээхэн анхаарал хандуулж явлаа. Тэдний өдөр тутамдаа дагадаг уламжлал, хорио цээрийн ёсыг танин мэдэх, нутгийн ард иргэдтэй уулзахдаа тэдний уламжлалыг дагах, тухайлбал гэр нүүлгэх, барих, цагаан идээний ач

холбогдол зэргийг судлах нь нэн чухал байлаа. Босгон дээр гишгэхгүй, галд хог хийдэггүй, газарт хутга зооддоггүй зэрэг цээрлэх зүйлс ч цөөнгүй. Энэ мэт уламжлалууд ч бидний судалгааны ажлын үр дүнд нөлөөлөх бөгөөд хээрийн судалгааны ажлын үед дагаж мөрдөх ёстой. Жишээ нь, газарт гадас хатгалгүйгээр хяналтын цэгийг тогтоох нь бидэнд чамгүй хүндрэлтэй байлаа.



Нөгөө талаар Монгол улсын соёлын өв, археологийн дурсгалуудын хамгаалалтын асуудал угсаатны зүйн судалгаатай нягт холбоотой. Тухайлбал, аливаа нэг дурсгалт газрын орчимд амьдарч буй айл өрх уг өвийг хамгаалах үүрэгтэй. Монголын засгийн газар соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаар сүүлийн жилүүдэд анхаарал хандуулах болжээ. Соёлын өвийн үндэсний төв нь энэ ажлыг хариуцаж ажилладаг агаад сүүлийн үед нутгийн иргэд ч мөн хариуцлагатай байх болжээ. Бидний ажилласан Булган аймаг нь түүх,

соёлын хамгийн олон өвтэй нутгийн нэг бөгөөд энд хамгаалалтын асуудлыг ихэд чухалчилдаг. Жишээлбэл, хүмүүс их очдог Чин толгой гэх тахилгатай овооны орчмыг хамгаалдаг хамгаалагч нар бий. Хээрийн судалгааны үед нутгийн айлууд бидний талаар хоорондоо хэл дуулгалцаж, орон нутгийн цагдаагийн хэлтэст мэдэгдсэн байснаас бид энэ хандлагыг мэдэрч байв. Түүний хажуугаар нутгийн зарим иргэд дурсгалт газрын дунд гэрээ барих зэрэг сөрөг зүйл ч байсныг тэмдэглэх хэрэгтэй.















Танилцуулга бичсэн:
Доктор Л.Эрдэнэболд
Доктор Жолт Слаги
2021.10.11. Улаанбаатар хот



БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн захирал,
доктор
Д.ГАНТУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

Монгол, Унгарын хамтын ажиллагаа эртний сайхан уламжлалтай. Тухайлбал, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа 1950-аад оноос эхтэй бөгөөд ялангуяа манай хоёр орны хамтын ажиллагааны анхны хэлэлцээр байгуулагдсан 1957 оноос эдүгээ хүртэл 60 гаруй жил хөгжиж ирсэн арвин түүхтэй.

Манай хоёр орны Байгалийн шинжлэх ухааны хамтын ажиллагаа нэрт эрдэмтэн, Унгарын Байгалийн Түүхийн музейн ерөнхий захирал, доктор, шавж судлаач, хожмоо Унгарын ШУА-ийн гишүүн болсон Золтан Касаб докторын 1963-1968 онуудад Монгол улсын нутагт явуулсан хээрийн судалгааны ажлаар эхэлсэн. Доктор З.Касаб Монголд хийсэн нийт 6 удаагийн хээрийн судалгааны дүнд 480 гаруй мянган биологийн дээж материал цуглуулж судлан тэдгээрийн үр дүнд тулгуурлан 200 гаруй эрдэм шинжилгээний хамтарсан бүтээл хэвлүүлжээ.

Мөн 1960-аад оны дунд үеэс Унгарын Засгийн газраас мэргэжилтэй боловсон хүчин бэлдэхэд ихээхэн

анхаарч Монголын оюутнуудыг Унгар улсад сургаж эхэлсэнээс гадна 1975 оноос манай хүрээлэнгийн судлаачид Унгар улсад аспирантурт суралцаж 10 гаруй мэргэжилтэн докторын зэрэг хамгаалсан, одоо ч хэд хэдэн хүн магистантур, докторантурт суралцаж байна.

Түүнчлэн ШУА-ийн Ерөнхий ба Сорилын Биологийн хүрээлэнд 1969 онд анхны Генетикийн лаборатори байгуулагдахад мэргэжилтэн бэлтгэх, багаж тоног төхөөрөмжөөр хангахад Унгар улсаас ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлсэн. 1978 онд тус лабораторийн нээлтэнд БНУАУ-ын Сегед хот дахь Биологийн олон улсын төвийн захирал, доктор Алфолди Лаеш хүрэлцэн ирж, тус лабораторийг Монголын талд хүлээлгэн өгөхөд оролцож байв. Тус Генетикийн лабораторийн болон түүнээс салбарлан гарсан Молекул биологийн болон Ургамлын эд, эсийн өсгөврийн лабораторийн 11 ажилтан Унгар улсад урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлснээс гадна 3 судлаач доктор (Ph.D), 3 судлаач магистрын (M.Sc) зэрэг хамгаалсан.

Эдүгээ академич, ШУА-ийн ерөнхийлөгч асан, манай Генетикийн лабораторийн анхны эрхлэгч Д.Баатар 1974 онд Сегедийн Биологийн олон улсын төвийн Будапешт дэх салбарын Биохимийн хүрээлэнд 6 сарын хугацаанд судалгааны ажил хийж, туршлага судалсан ба Сегед дэх Биологийн олон улсын төвд доктор Ж.Хасболд, Х.Төмөрбаатар, Ц.Цогтхишиг, Ц.Оюунсүрэн, эрдэм шинжилгээний ажилтан Д.Бадам-Очир, 1990-ээд онуудад С.Тогос, Ч.Үзмээ, Ц.Туяа нарын судлаачид мэргэжил дээшлүүлж, судалгааны ажил хийж, орчин үеийн арга зүйд суралцаж ирсэн нь цаашид манай лабораториудад биологийн, генетикийн судалгааг молекул биологийн түвшинд хийх боломжийг нэмэгдүүлсэн төдийгүй манай орны молекул биологийн салбарын хөгжилд ихээхэн хувь, нэмэр оруулсан юм.

2000-аад оноос Унгар улсын засгийн газрын тэтгэлгээр монгол судлаачдыг дахин сургаж эхэлсэн ба манай хүрээлэнгийн 2 судлаач доктор (Ph.D), 1 судлаач магистрын (M.Sc) зэрэг хамгаалсан ба одоогоор 4 судлаач докторантурт суралцаж байна.

Мөн манай хүрээлэнд 2010-2011 онд хоёр улсын Засгийн газар хоорондын шинжлэх ухаан, технологийн

“Identification and Evaluation of New Essential Oil Combinations Against Food Spoilage Microorganisms” төслийг амжилттай хэрэгжүүлж төрөл бүрийн ургамлаас эфирийн тосыг гарган авч, тэдгээрийг хүнсний бүтээгдэхүүн бохирдуулагч бактери, дрожж, мөөгөнцрийн эсрэг үйлчлэх нөлөө, ашиглах боломж, технологийн чиглэлээр хамтран ажилласан нь шинжлэх ухааны болон практик ач холбогдолтой төсөл болсон. Манай хүрээлэнгийн судлаачид микробиологийн чиглэлээр Сегедийн Их Сургуулийн Шинжлэх ухаан, информатикийн факультетийн Микробиологийн тэнхимийн захирал, доктор, профессор Csaba Vagvolgyi-ийн удирдлагаар хамтарсан судалгааны төсөлт ажил эхлүүлэх, бүтээл хэвлүүлэх зэргээр хамтран ажиллаж байна.

Ийнхүү Монгол, Унгарын хамтын ажиллагаанд манай хоёр орны шинжлэх ухааны хамтын ажиллагаа томоохон байр суурь эзэлж, ихээхэн үнэлэгдэж ирсэн ба цаашид ч орчин үеийн нөхцөл байдалтай уялдуулан улам эрчимтэй хөгжүүлэх боломжтой юм.

Монгол, Унгарын уламжлалт олон жилийн хамтын ажиллагаа улам өргөжин хөгжиж, хоёр орны цаашдын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах болно гэдэгт итгэл төгс байна.

Та бүхэнд баярын мэнд хүргэж, сайн сайхныг хүсэн ерөөе!

МОНГОЛ, УНГАР ХОЁР ОРНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМААС

Монгол Унгарын хамтын ажиллагаа эртний сайхан уламжлалтай. Тухайлбал, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа 1950-аад оноос эхтэй бөгөөд ялангуяа манай хоёр орны хамтын ажиллагааны анхны хэлэлцээр байгуулагдсан 1957 оноос эдүгээ хүртэл 60 гаруй жил хөгжиж ирсэн арвин түүхтэй.

Манай хоёр орны Байгалийн шинжлэх ухааны хамтын ажиллагаа нэрт эрдэмтэн, Унгарын Байгалийн Түүхийн музейн ерөнхий захирал, доктор, шавж судлаач, хожмоо Унгарын ШУА-ийн гишүүн болсон Золтан Касаб докторын 1963-1968 онуудад Монгол улсын нутагт явуулсан хээрийн судалгааны ажлаар эхэлсэн түүхтэй. Тэрээр Монголд 1963, 1964 онд тус бүр нэг удаа, 1965 онд хоёр удаа, 1967,

1968 онд тус бүр нэг удаа, нийт зургаан удаагийн хээрийн судалгаа хийж, (2-р зураг) монгол орны нутаг дэвсгэрийн ихээхэн хэсгээс (3-р зураг) нийт 486 мянга гаруй биологийн дээж материал цуглуулсан гэдэг. Тэдгээр материалыг боловсруулах, судлахад унгар, монголын эрдэмтдээс гадна бусад олон орны эрдэмтэд оролцож, судалгааны үр дүнгийн талаар одоогоор 200 гаруй эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэн олны хүртээл болгоод байна.

Академич З.Касабаас гадна доктор Жолт Балинт, Ференц Немет, Золтан Варга зэрэг эрдэмтэд 1980-аад оны сүүлчээр Монголын говь, хээрийн бүсэд зарим ургамал, амьтны тухайлбал, эрвээхэйн судалгаа хийж, нэлээд материал цуглуулан судалсан байна.




Унгарын ШУА-ийн гишүүн, академич, шавж судлаач, Унгарын Байгалийн түүхийн музейн ерөнхий захирлаар 1970-1985 онд ажиллаж байсан, нэрт биологич

ЗОЛТАН КАСАБ (1915-1986)



*2-р зураг. З.Касаб Монгол дахь экспедицийн үеэр, Цагаан нуурт.
1968 оны 6-р сар*



3-р зураг. 1963-1968 онуудад эрдэмтэн З.Касабын хийсэн судалгаа болон Унгарын бусад судлаач, эрдэмтдийн 1990 он хүртэл хийсэн судалгаагаар шавж, хэвлээр явагчид, хоёр нутагтан зэрэг амьтдын дээж материал цуглуулсан газар нутгийг хар цэгээр харуулав.

МУИС-ийн багш, шавж судлаач, доктор, профессор А.Цэндсүрэн 1960-аад оны эхээр эрдэмтэн З.Касабтай танилцаж, хээрийн судалгаа хамт хийж, монгол орны шавж судлалын талаар болон монгол нутгаас цуглуулсан бусад дээж материалыг тодорхойлох, боловсруулах зэргээр олон жил хамтран ажиллаж байв. Доктор А.Цэндсүрэн, Хөдөө аж ахуйн их сургуулийн багш, шавж судлаач, доктор Л.Чогсомжав нар 1968 оны зун (4-р зураг) Унгарын Байгалийн түүхийн музейд туршлага судлан ажиллаж, эрдэмтэн З.Касаб болон түүний шавь нартай хамтран тэнд хадгалагдаж буй Монголоос цуглуулсан дээж материалыг боловсруулах судалгаа шинжилгээний ажил хийж, хамтарсан олон бүтээлийг нийтлүүлсэн байна.

Академич З.Касаб болон түүний шавь нар шавжаас гадна монгол нутагт тархсан хэвлээр явагчид, хоёр нутагтан амьтдын нийт зүйлийн 57% орчмыг хамрах 786 дээж материал цуглуулсан гэж тэмдэглэгдсэн байдаг. Нэрт эрдэмтэн, академич З.Касабын эрдэм судлалын ажил одоо ч үргэлжилсээр байгаа бөгөөд шавь нар болон хамтран зүтгэгчид нь 50 гаруй жилийн өмнө түүний монгол нутгаас цуглуулсан шавжийн болон бусад амьтдын дээж материалыг судалсаар байна. Энэ ажилд монголын биологичид, шавж судлаач эрдэмтэд хамтран оролцож, түүний их өв сангийн үр шимээс хүртэж, Унгар, Монголын эрдэмтэд дэлхийн шинжлэх ухаанд хувь нэмрээ оруулсаар байна.



4-р зураг. МУИС-ийн багш, доктор проф. А. Цэндсүрэн (зүүн гар талд), доктор Л. Чогсомжавын хамт Унгарын Байгалийн Түүхийн музейд ажиллах үеэр. Будапешт хот, 1969 оны 8-р сар

БНУАУ-ын нам төрийн зүтгэлтэн Янош Кадар манай улсад зочлох үеэрээ Пионерийн ордны дугуйланд суралцагч

хүүхдүүдтэй уулзаж, хүндэт зочны дэвтэрт гарын үсгээ зуржээ (5-р зураг).



5-р зураг. БНУАУ-ын Нам Төрийн зүтгэлтэн Янош Кадар манай Пионерийн ордонд зочлох үеэр. 1966 он

1960-аад оны дунд үеэс Унгарын Засгийн Газраас манай Монгол улсад мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд ихээхэн анхаарч, оюутан сургаж эхэлснээс гадна 1975 оноос манай судлаачид Унгар улсад аспирантурт суралцах болсон бөгөөд эдүгээ 30 гаруй мэргэжилтэн докторын зэрэг хамгаалаад байна. 1979 оны намар БНУАУ-д аспирантурт сурахаар очих үед Д.Цагаан, Лувсандорж, С.Зориг нар дэд эрдэмтний зэрэг хамгаалаад нутаг буцсан, Ц.Баясгалан (математикч), Д.Монхор (математикч), Ц.Батцэрэн (химич), Р.Батмэнд (хөнгөн үйлдвэрийн инженер механикч), Я.Зэнээмэдэр

(статистикч), Ж.Алимаа (хүнсний технологич), Ш.Дэмбэрэл (малын эмч), Б.Сүхбаатар (холбооны инженер) Ж.Хасболд (иммунологич), Ч.Цэцгээ (эдийн засагч), Ц.Оюунсүрэн (генетикч) (6-р зураг), бид аспирантурт сурч, дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. Харин Ч.Цэцгээ эгч ар гэрийн шалтгаанаар хамгаалаагүй нутаг буцсан юм. Манай Их хурлын эрхэм гишүүн, ШУА-ийн гишүүн, академич Р.Гончигдорж 1991 онд математикийн чиглэлээр Унгар улсад шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Мөн МУИС-ийн багш, математикч, академич С.Төмөрбөт 1999-2004 онд Унгарт математикийн

чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж, хожмоо эх орондоо докторын зэрэг хамгаалжээ.

Унгар улсад докторын зэрэг хамгаалсан мэргэжилтнүүдээс дөрвөн хүн Академич хэргэм, нэг хүн Төрийн шагнал, дөрвөн хүн Шинжлэх ухааны гавьяат цол хүртсэн нь манай хоёр орны шинжлэх ухааны хамтын ажиллагааны томоохон үзүүлэлт юм.

Мөн 1980-аад онд инженер Ч.Давааням (манай НИК компанийг үндэслэгчдийн нэг), ШУТИС-ийн орлогч захирал асан Эрдэнэбат болон Байгаль, Статистикийн газрын ажилтан, мэдээллийн технологич О.Батсүх, хүний их эмч Цэдэн-Иш (хүний гавьяат эмч) зэрэг олон мэргэжилтэн БНУАУ-ын хамтын ажиллагаа, ДЭМБ-

ын шугамаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байсан бөгөөд тэд тухайн үеийн Унгар улсын шинжлэх ухаан технологи, анагаах ухааны ололт амжилт, туршлагаас ихээхэн зүйлийг сурч мэдэн эх орондоо түгээн дэлгэрүүлсэн нь мэдээж билээ. Эдгээрээс гадна Будапештэд Дэлхийн залуучуудын байгууллагын төлөөлөгч Мөнхжаргал гуай, Олон улсын маркийн холбооны төлөөлөгч Найдансүрэн гуай зэрэг хүмүүс ажиллаж байснаас гадна Өтвөш Лорандын их сургуульд манай ШУА-ийн эрдэмтэд, их дээд сургуулийн монгол хэлний багш докторууд тухайлбал, Ж.Цолоо, Лха.Дамдинжав, Ц.Өнөрбаян, Төмөр-Очир зэрэг хүмүүс ажиллаж байв.





6-р зураг. 1980-аад оны аспирантууд

1969 онд манай ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Генетикийн тасаг буюу лаборатори байгуулагдахад боловсон хүчин бэлтгэх, судалгаа шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэхэд тухайн үеийн Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ)-ийн гишүүн орнууд, тухайлбал БНУАУ ба ЗХУ ихээхэн

анхаарч, тусламж дэмжлэгээ үзүүлсэн юм. 1978 онд лабораторийн нээлтэд БНУАУ-ын Сегед хот дахь Биологийн олон улсын төвийн захирал, профессор Л.Альфелди болон ЗХУ-ын ШУА-ийн Ерөнхий генетикийн хүрээлэнгийн захирал, академич Н.П.Дубинин нар хүрэлцэн ирж лабораторийг Монголын талд хүлээлгэн өгсөн (7-р зураг).



7-р зураг. ШУА-ийн Генетикийн тасгийн нээлийн үеэр.

Хоёрдугаар эгнээний баруун гар талаас хоёрдахь нь БНУАУ-ын Сегедийн Биологийн олон улсын төвийн захирал, доктор, ШУА-ийн сурвалжлагч гишүүн Лаеош Альфелди, голд нь БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Ширэндэв нар бусад хүмүүсийн хамт, 1978 он

Тэр үед ЭЗХТЗ-ийн орнууд, тухайлбал БНУАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар манай ШУА-ийн Физик Техникийн хүрээлэн дэх Радиоэлектроны иж бүрэн лабораторийн нэгэн хэсэг болох Нарны зайн лаборатори болон манай Генетикийн лаборатори байгуулагдсан юм. Энэ хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлэхээс гадна мэргэжилтэн бэлтгэх, туршлага судлах, хамтын судалгаа хийх чиглэлээр хэд хэдэн ажлууд хийгдсэн юм. Үүний дагуу Унгарын ШУА-ийн дэргэдэх Байгалийн түүхийн музейн ажилтан доктор Янко Бела манай генетикийн лабораторид гурван жил орчим ажиллаж, монгол орны тэжээлийн ургамал болон ховор, ховордож буй зэрэг ургамлын генетикийн нөөцийн чиглэлээр хамтын судалгаа хийж, залуу судлаачдыг сургаж байв (8-р зураг). Мөн Унгарын тусламжаар генетикийн лабораторийн туршилт судалгааны бааз болох барилга, холбогдох тоног төрөөхөмж

бүхий Биостанцийг Зүүнхараад байгуулж, манай ургамлын генетикчид тэнд ажиллан, улаанбуудайн шинэ сортын хэд хэдэн удам гарган авах зэрэг ажлуудыг хийсэн билээ.

Унгарын Засгийн газраас манай улсад мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж, Будапештийн Өтвөш Лорандын их сургууль, Техникийн их сургууль, Сегедийн их сургууль, Анагаах ухааны их сургууль, Дебреценийн Их сургууль, Карл Марксийн нэрэмжит Эдийн засгийн их сургууль зэрэг олон их дээд сургуульд болон Комло хот дахь техник мэргэжлийн сургуульд ч манай оюутан залуучууд сурч төгсөн эх орныхоо хөгжил дэвшилд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Дээр дурдсан ЭЗХТЗ-ийн хамтын ажиллагааны хүрээнд 1970-аад оноос манай Генетикийн лабораторийн 10 гаруй мэргэжилтэн Унгарын ШУА-ийн холбогдох хүрээлэн, их сургууль

болон Сегед хот дахь Биологийн Олон улсын төвд орчин үеийн генетик, биохими зэрэг чиглэлээр мэргэжил дээшлүүлж, хоёр ажилтан докторын зэрэг хамгаалсан. Түүнчлэн ШУА-ийн ерөнхийлөгч асан, манай Генетикийн лабораторийн анхны эрхлэгч академич Д.Баатар 1974 онд Сегедийн Биологийн Олон улсын төвийн Будапешт дэх салбарын Биохимийн хүрээлэнд зургаан сарын хугацаанд судалгааны ажил хийж, туршлага судалсан юм. Мөн Сегед дэх Биологийн Олон улсын төвд надаас гадна эдүгээ АНУ-ын Эрүүл Мэндийн хүрээлэнд ажиллаж буй доктор Б.Арьяа, доктор Ж.Хасболд, Х.Төмөрбаатар, Ц.Цогтхишиг, эрдэм шинжилгээний ажилтан Д.Бадам-Очир зэрэг судлаачид мэргэжил дээшлүүлж, судалгааны ажил хийж, орчин үеийн арга зүй сурсан зэргээс цаашид манай лабораториудад биологийн, генетикийн судалгааг молекул, гени болон эсийн түвшинд хийх боломжтой болж, улмаар манай оронд молекул генетик, молекул биологийн салбарын хөгжлийн суурь тавигдсан юм.



8-р зураг. 1976-1979 онд Генетикийн лабораторид ажиллаж байсан Унгарын мэргэжилтэн, доктор Бела Янко

Манай хоёр орны ШУА-ууд анх 1966 онд Шинжлэх ухааны хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулсан түүхтэй. Улмаар 1971 онд Унгарын ШУА-ийн хүрээлэнгийн захирал доктор Д.Сигети тэргүүтэй төлөөлөгчид, 1976 онд Унгарын ШУА-ийн ерөнхий эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Иштван Ланг тэргүүтэй төлөөлөгчид манай оронд зочилж, шинжлэх ухааны хамтын ажиллагааны санамж бичгийг үзэглэжээ. Энэхүү хамтын ажиллагааны гол хэлбэр нь хоёр орны эрдэмтэд тэгш солилцооны шугамаар зочилж ажиллах, хамтарсан судалгаа хийх, шинжлэх ухааны арга хэмжээнд төлөөлөгчид харилцан урьж оролцуулах, эрдэм шинжилгээний ном хэвлэл, бусад материал солилцох зэрэг байв.

1964 онд манай ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Ширэндэв Унгарын ШУА-ийн гадаад гишүүнээр, 1967 онд Унгарын монголч эрдэмтэн Лигети Лайош, Унгарын физикч, академич Лаеош Янош нар БНМАУ-ын ШУА-ийн гадаад гишүүнээр тус тус сонгогдсон юм.

1991 онд хоёр орны ШУА-уудын хамтын ажиллагааны хүрээнд Монголын үлэг гүрвэлийн олдворын үзэсгэлэнг Унгар Улсад зохион байгуулж, зургаан сар ажиллуулжээ. Мөн тэр үеэс монголч эрдэмтэн, монгол хэл сурч буй Унгар оюутнуудыг жил бүр Монголд дадлага хийлгэх, судалгааны экспедицид илгээх, эрдэмтэд хоёр орны их, дээд сургуулиудад харилцан лекц унших, соёлын өдөрлөг, үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээнүүд эхэлсэн бөгөөд энэ арга хэмжээ одоо үндсэндээ тогтмолжсон байна.

Унгарын Будапешт хотын Өтвөш Лорандын нэрэмжит Эрдмийн Их сургуульд Монгол судлалын төв

байгуулагдсан ба Төв Ази судлалын тэнхимд монгол судлалаар оюутан сургадаг. Унгарын монголч эрдэмтэд монголын түүх, хэл, уран зохиол, соёл, зан заншлын талаар судалгаа хийж, олон арван бүтээл хэвлүүлсэн байна. Энэ их сургуулийн Монгол ба Төв Ази судлалын тэнхим нь Унгар улсын хэмжээнд монгол хэл, түүх, соёлтой холбоотой бүх салбарыг багтаасан судалгаа, шинжилгээ, боловсрол болон “монголч судлаач” мэргэжлийн диплом олгодог дээд боловсролын ганц нэгж юм. Унгарын монгол судлал бол Европт төдийгүй дэлхий дахинд танигдсан төв бөгөөд манай оюутан судлаач, эрдэмтэд тэнд туршлага судлан суралцаж, хамтарсан судалгаа хийж, хоёр орны хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулсан.

2008 онд ЭСЯ, Унгарын ШУА, Өтвөш Лорандын нэрэмжит Эрдмийн Их сургуулийн Монгол ба Төв Ази судлалын тэнхимтэй хамтран “Европ дахь Монгол судлал” эрдэм шинжилгээний хурал, 2011 онд “Монголын эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, 2010 онд манай хоёр улсын хооронд дипломат

харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд “Монгол-Унгарын соёл, шинжлэх ухааны салбарын харилцаа 60 жилд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, 2013 оны 7 дугаар сард Монгол судлалын асуудлаар эрдэм шинжилгээний бага хурлыг тус тус зохион байгуулсан.

Унгарын ШУА-ийн гишүүн Лигети Лайош Будапештийн Их сургуульд монгол хэл соёлын үндсэн ангийг нээх, Унгарын ШУА-ийн номын санд монгол гар бичмэл, дармал бичигт ном судрын сан хөмрөг бий болгох, “Монголын нууц товчоо”, “Алтан товч” гэх зэрэг монгол эртний сурвалж бичгийг судлах зэргээр монгол судлалыг эхлүүлсэн гэж үздэг. Харин эдүгээ Унгар дахь монгол судлал улмаар өргөжин хөгжиж хэл бичгийн ухаан, түүхийн ухаан, соёл судлал, угсаатны зүй гэх зэрэг салбар ухаанаар залуу монголч эрдэмтэд шинээр төрөн гарсаар байна.

Ийнхүү Монгол Унгарын хамтын ажиллагаанд манай хоёр орны шинжлэх ухааны хамтын ажиллагаа 60 гаруй жилийн өмнөөс томоохон байр суурь эзэлж үнэлэгдэж ирсэн ба цаашид ч орчин үеийн нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэх боломжтой юм.



АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



Археологийн хүрээлэнгийн захирал, доктор,
дэд профессор
Г.ЭРЭГЗЭН

МЭНДЧИЛГЭЭ

Монгол, Унгарын Шинжлэх Ухааны Академи хоорондох хамтын ажиллагаа урт удаан түүхтэй билээ. Хоёр орны Шинжлэх ухааны академиуд хооронд хамтран ажиллах гэрээг 1960 онд байгуулсан бөгөөд энэхүү гэрээ байгуулагдаад хамгийн түрүүнд хэрэгжсэн ажлын нэг нь Хүннүгийн дурсгалыг судлах археологийн хамтарсан судалгаа байсан.

Унгаруудын хувьд Хүннү гүрний археологийн дурсгалыг сонирхох болсон шалтгаан нь Монголоор төвлөрсөн их эзэнт гүрнийг байгуулан 300 гаруй жил оршин тогтносон хүчирхэг нүүдэлчид болох Азийн Хүннү нар болон V зуунд Зүүн Европт гэнэт хүчирхэгжин тодорсон Атилла хаанаар толгойлуулсан Хүн хэмээх нүүдэлчдийн хоорондох холбоо хамаарлын асуудал байсан.

Хүннү гүрэн мөхсний дараа NT I зууны төгсгөлд зарим хэсэг нь баруун зүгт дүрвэн нүүдэллэсэн талаар сурвалжийн мэдээ баримт бий. Энэхүү хүннүчүүд олон хэсэг салж бутран одсон бөгөөд тэдний нэг салбар нь Зүүн Европт очсон хэмээн судлаачид таамагладаг. Үүнийг холбох чухал

сэжим нь Атиллагийн Хүн нарын нэрийн дуудлага юм. Түүнээс гадна тэдний царай төрхийн талаар бичиж үлдээсэн барууны сурвалжийн мэдээ баримт ч үүнийг давхар нотолдог билээ. Гэвч Азийн Хүннү болон Европын Хүн гүрний хоорондын холбоо хамаарлын асуудал нь бодитой судалгаа, нотлох баримт хэрэглэгдэхүүн багатай тул шүүмжлэлд өртдөг төдийгүй зарим судлаачид эрс үгүйсгэдэг асуудал хэвээр байна.

Гэхдээ Азийн Хүннү болон Европын Хүн нарын холбоо хамаарлыг нотлох, илүү нарийвчлан судлах боломж бий бөгөөд үүнийг хийх шинжлэх ухааны салбар бол археологи юм. Тиймээс ч Унгарын Шинжлэх ухааны академи Монголын Шинжлэх Ухааны академитай хамтран ажиллах гэрээ байгуулснаар хамгийн түрүүнд энэ асуудалд анхаарал хандуулсан болов уу. Харамсалтай нь эрчтэй эхэлсэн ажил улс төрийн шалтгаантайгаар зогсонги байдалд орж, амжилт олоогүй байдаг.

Унгарууд өөрсдийгөө Хүн гүрний үр хойчис хэмээн үздэг бөгөөд үүнийг илтгэх тод жишээ бол улсын нэр ажээ. Унгарт Хүн гүрний соёлоос уламжлан

үлдсэн өв их байхын зэрэгцээ археологийн олдвор хэрэглэгдэхүүн ч багагүй байна. Сүүлийн жилүүдэд унгарууд өөрсдийн түүхийн гажуудлыг засч залруулахад ихэд анхаарч, Хүн гүрний талаар судлах болжээ. Энэхүү ажлыг эрхлэх үүрэг бүхий Унгар судлалын хүрээлэн хэмээх төрийн байгууллага байгуулсан байна.

Манай хүрээлэн энэ жил Монгол, Унгарын археологичдийн хамтын ажиллагааны 60 жилийн ойг тохиолдуулан хоёр орны судлаачид хамтарч судалгаа хийж байсан Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булшны малтлага судалгааг хийсэн бөгөөд энэхүү судалгааны ажилд Унгар судлалын хүрээлэн дэмжиж оролцсон. Манай хоёр хүрээлэнгийн хамтын ажиллагаа энэ дурсгал болон Монголын Хүннүгийн үеийн бусад дурсгалаас илэрсэн антропологийн хэрэглэгдэхүүнд генетикийн задлан шинжилгээ хийх хамтарсан шинжилгээний ажил болон өргөжиж байна.

Бидний хамтын ажиллагаа дээр өгүүлсэн Азийн Хүннү болон Европын Хүн гүрний хоорондох холбоо хамаарлын асуудал “домоог, эсвэл үнэн түүх” алин болохыг орчин үеийн шинжлэх ухааны түвшинд тодруулахад чиглэгдэж буй. Ялангуяа, орчин үеийн шинжлэх ухааны ололтын нэг болсон байгалийн шинжлэх ухааны салбар болох генетикийн шинжилгээний аргаар асуудлыг тодруулахаар ажиллаж байгаа нь илүү найдвар төрүүлж байна.

Хоёр хүрээлэнгийн хамтарсан судалгаа, шинжилгээний ажлууд өдрөөс өдөрт илүү хөгжин дэвшинэ гэдэгт илтгэлтэй байна. Бидний энэхүү хамтын ажиллагаанд гүүр болон ажиллаж ирсэн Унгар улсаас Монгол улсад суугаа Элчин сайд, доктор Др.Обрущанский Борбала болон тус Элчин сайдын яамны ажилтнуудад талархал илэрхийлье.

Монгол, Унгарын Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа улам өргөжин дэвжихийн ерөөл өргөө.


УЛААНБААТАР ХОТЫН БЭЛХИЙН АМНЫ ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ БУЛШНЫ АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА ТӨСӨЛ



НТӨ Ш - НТ II зуун хүртэлх хугацаанд хүрлийн үеийн хүчирхэг аймгуудаас Хүннү гүрэн хүчирхэгжин, төрт улсаа цогцлоон байгуулсан нь Евразийн түүхэнд тод мөрөө үлдээсэн юм. Хүннү гүрний хил хязгаар нь хүчирхэг үедээ Солонгосын хойгоос Ил тарвагатай, Байгал нуураас Цагаан хэрэм, Ордос хүртэлх өргөн уудам нутгийг эзлэн байжээ.

Монгол улсын нутаг дэвсгэрээс Хүннүгийн язгууртны есөн оршуулгын газар илэрч мэдэгдээд байгаа бөгөөд эдгээр нь Архангай аймгийн Хайрхан

сумын Гол мод, Өндөр-Улаан сумын Гол мод-2, Булган аймгийн Хангал сумын Хялганат, Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сумын зааг Ноён уул, УБ хотын Бэлхийн ам, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Дуурлиг нарс, Биндэр сумын Борбулаг, Ховд аймгийн Манхан сумын Тахилтын хотгор, Говь-Алтай аймгийн Тайшир сумын Овоон хар зэрэг газрууд болно. Эдгээрийн тархацыг харахад Монголын төв хэсэгт тав, зүүн хэсэгт хоёр, баруун хэсэгт хоёр оршуулгын газар байх ажээ.



Хүннүгийн оршуулгын дурсгалт газрын тархац

Эдгээрээс Улаанбаатар хотын Бэлхийн аманд байрлах Хүннүгийн булш, оршуулгын дурсгалт газар ШУА-ийн Археологийн хүрээлэн, Нийслэлийн Соёл урлагийн газар, Аялал жуулчлалын газар болон Унгар улсын Унгар судлалын хүрээлэнтэй хамтран “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булшны археологийн судалгаа” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус төслийг хэрэгжүүлснээр, Улаанбаатар хотын Бэлхийн амны Хүннүгийн булш, оршуулгын дурсгалт газрын холбогдох он цагийг нарийвчлан тогтоож, Монголын түүхэнд эзлэх байр суурийг тодорхойлох, Монголын эртний түүхийг судалгааны шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулж, нийслэлийн ард иргэдэд өөрсдийн амьдарч буй нутаг орны түүх, соёлын өвөөр бахархах үзэл бий болгох, улмаар аялал жуулчлалын маршрутад хамруулах зорилго агуулж буй юм. Мөн Бэлхийн амны дурсгалт газар нь Улаанбаатар хотын төвөөс нэг их холгүй

байрладаг тул цаашид уг дурсгалд түшиглэсэн “байгалийн нээлттэй үзмэр” болгон хөгжүүлэх боломж бий.

Хүннү гүрэн хүчирхэг байх үедээ асар өргөн уудам газар нутгийг эзэмшиж байсан боловч Хүннүгийн үед холбогдох түүх, соёлын дурсгалуудын дийлэнх нь манай улсын нутагт оршдог. Хүннү гүрэн нь төв, зүүн, баруун жигүүрт хуваагдсан засаг захиргааны хуваарьтай байсан бөгөөд Бэлхийн амны язгууртны оршуулгын газар нь Хүннүгийн төв хэсгийн зонхилгогчид, язгууртнуудын оршуулгын газрын нэг байх магадлалтай.

Улаанбаатар хотын зүүн хойд зах буюу Сүхбаатар дүүргийн 20-р хорооны нутагт Сэлбэ голын цутгал Бэлхийн голын эхэнд Бэлхийн ам хэмээх зүүн талаараа өндөр толгойгоор халхлагдсан урд талаараа задгай, хойноо шилмүүст модон ойтой уулын зүүн бэлийн тэгш дэвсгэ газарт зургаан язгууртны булш болон дагуул дөрвөн жижиг булштай дурсгалт газар бий.



Бэлхийн амны Хүннүгийн оршуулгын дурсгалт газрын ерөнхий байдал

Энэхүү дурсгалт газар 1960 онд БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, БНУАУ-ын Шинжлэх Ухааны Академийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Унгарын Азийг судлах нийгэмлэгийн дарга, Будапешт хотын Азийн Урлагийн Музейн дарга Т.Хорват Монгол улсад нэг сарын хугацаагаар ирж, Монгол дахь Хүннүгийн үеийн булшны байдалтай танилцах, улмаар

зарим булшийг малтан судлах хүсэлт тавьсан байна. Т.Хорватын хүсэлтийг Түүхийн хүрээлэн хүлээн авч, Улаанбаатар хотын ойролцоох Бэлхийн амны Хүннү булшийг малтан судлахаар тохиролцжээ. Ийнхүү 1961 онд ажилласан хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас Н.Сэр-Оджав, Ц.Доржсүрэн, Д.Дорж, Д.Наваан нар МУИС-ийн таван оюутны хамт ажилласан байна¹².



Н.Сэр-Оджав



Д.Дорж




Ц.Доржсүрэн



Д.Наваан

¹² Н.Сэр-Оджав. Монгол-Унгарын хамтарсан эртний судлалын шинжилгээний ажлын тухай. *Studia Archaeologica* (1961 оны хээрийн шинжилгээний хэрэглэгдэхүүн). Т.III, Fasc.3. УБ., 1961. Тал 31-38

Бэлхийн амны Хүннүгийн булш оршуулгын дурсгалт газарт Монгол, Унгарын хамтарсан хээрийн шинжилгээний анги бүртгэл, маллага судалгаа явуулж үүдэвч бүхий язгууртны булш зургаа, цагариг хэлбэрийн жижиг булш дөрвийг бүртгэн дэвсгэр зураг үйлджээ.



Бэлхийн амны Хүннүгийн оршуулгын дурсгалт газрын дэвсгэр зураг. 1961 он.

Бүх булшнуудыг эрт цагт тонож эвдсэн учир ихэнх булшны голд 1,2 - 2,2 метр хүртэл гүнзгий хонхортой байна. Тонохдоо гаргасан шороог малтсан нүхний амсар дээр овоолсон учир булшны анхны дөрвөлжин хэлбэр алдагдаж өөрчлөгдөн цөм дугуй маягтай болсон байна. Иймээс Бэлхийн амны булшийг нутгийн ардууд Хулгайчийн долоон хонхор гэдэг ажээ.

Тэдгээр булшнаас Монгол, Унгарын хамтарсан шинжилгээний анги 1961 онд 1 дугаартай үүдэвчтэй язгууртны булш, 2, 3 дугаартай хоёр дагуул булшийг малтан судалсан байна.

Дөрөвдүгээр булшийг малтах явцад 2,9 метр гүнээс нимгэн бөөртэй, саарал өнгийн том жижиг хоёр ваар, хазаарын төмөр амгай илэрч олджээ.


Харин хоёрдугаар булшнаас төмөр олом, төмөр эдлэл, хүний ясны зарим хэсэг гарсан бол гуравдугаар булшнаас төмөр зэвнээс өөр ямар нэгэн эд өлгийн

зүйл олдоогүй гэж тодорхойлсон байдаг.

Гуравдугаар булшийг Унгарын судлаач Т.Хорватын хүсэлтээр 3x3 метрийн хэмжээтэй хүрээ татан малтжээ. 70 орчим см-ийн гүнээс 3 см урт төмөр хадаас, төмөр олом, гурван дэлбээтэй төмөр зэв, хазаарын амгай, хэлтэй төмөр арал гарсан байна. Тэдгээр олдвороос доош гүнзгийлэн малтахад өрөөсөн цэлбий нь бүтэн исгэрэх нүхтэй төмөр зэв гарчээ.

1961 оны маллагын үеэр урьд өмнө Хүннүгийн булшнаас олдсонтой адил зүйл төдийлөн их олдоогүй боловч Хүннүгийн эдийн ба оюуны боловсролд холбогдох сонирхолтой зүйл нэлээд олдсон нь тус шинжилгээний ангийн ажлын гол үр дүн болжээ.

Түүнээс хойш тус дурсгалт газар ямар нэгэн судалгаа хийгдээгүй байж байгаад 2009 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүннүгийн археологийн судалгааны секторын судлаачид тус дурсгалт газарт бэсрэг хайгуул судалгааны ажил хийж тойм дэвсгэр зургийг шинэчлэн хийжээ.



Бэлхийн амны Хүннүгийн оршуулгын дурсгалт газрын дэвсгэр зураг. 2009 он.

2021 онд ШУА-ийн Археологийн хүрээлэн, Нийслэлийн Соёл урлагийн газар, Аялал жуулчлалын газар болон Унгар улсын Унгар судлалын хүрээлэнгийн хамтарсан “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны

булшны археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний анги малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус төслийн археологийн судалгааны нээлтэд Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга Ж.Дамдинцэрэн, Аялал жуулчлалын газрын

дарга А.Ариунгэрэл, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал Г.Эрэгзэн, Унгар улсын Унгар судлалын хүрээлэнгийн захирал Габор Хорват, Унгар улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Др.Обрущанский Борбала Анна нар оролцсон юм.



Төслийн үйл ажиллагааны нээлт.

“Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булшны археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний анги язгууртны үүдэвчтэй 3-р булш (хуучин бүртгэлээр 6 дугаартай), 1-р булшны дагуул 3-р булшийг (хуучин бүртгэлийн дугаар - Булш 4) сонгон археологийн малтлага


судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус дурсгалт газрын агаарын зургийг авч, нарийвчилсан хэмжилт, тодорхойлолтыг хийж гүйцэтгэв. Хүннүгийн язгууртны булшнуудын бүтэц, рельефийг харуулсан дэвсгэр зураг хийх ажлыг гүйцэтгэж байна.

2021 онд хийсэн малтлагыг булш тус бүрээр танилцуулъя.

3-Р БУЛШ

Энэхүү булш нь Бэлхийн аманд орших бүлэг булшны хамгийн баруун урд талын булш бөгөөд далайн түвшнээс дээш 1727 м-т оршино.

Түүний хойд талд 1960 онд Монгол, Унгарын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн малтсан 4-р булш байх ажээ. Бид уг дурсгалыг 1960 оны бүртгэлийн дагуу 3-р булш хэмээн дугаарлаж, малтлагын ажлыг нийт 53 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.



Бэлхийн амны Хүннүгийн оршуулгын дурсгалт газрын дэвсгэр зураг. 2021 он.

Булш нь газрын өнгөн хөрсөн дээр хойноос өмнө зүгт хандсан тэгш өнцөгт дөрвөлживтөр хэлбэрийн ихэд хөрсөжсөн чулуун хүрээтэй. Чулуун хүрээний хойд, баруун талын хүрээ ихэд эвдэрсэн. Өнгөн хөрсөн дээр мэдэгдэх чулуун дараасны голч 16 м байх ба дараас чулууны урд хэсэгт үл ялиг баруун урагш чиглэсэн 2 м орчим урт, 1.5 м өргөн үүдэвчний чулуун өрлөг битүү ургасан өвс, ширэг, тарааж хаялсан дараас чулуун дундаас ялгарч байв. Чулуун дараасны төвд 8 орчим метрийн голчтой, 1.7 м гүн тонуулчдын нүхний хонхор байх ба булшийг тонохдоо гаргасан шороо,

чулууг зүүн талын чулуун хүрээний дээгүүр тойруулан хаялсан нь зузаан шороон далан болж, зүүн хэсэгт өнгөн хөрснөөс 80 см өндөр даланг үүсгэжээ. Тонуулчдын гаргасан шороо хожим нь эдгэж хөрсжин, хус, бут сөөг ихээр ургасан бөгөөд бид булшны дээд хэсгийн мод, өвс ургамлыг бүрэн цэвэрлэж анхны хэмжилтийг үйлдсэн.



3-р булшны малтлагын өмнөх байдал (16 м голчтой, 2 м гүн хонхортой)

Булшин дээр ургасан мод, бутыг чөлөөлж, анхны байдлаар баримтжуулсны дараа булшны чулуун хүрээг тэр чигт нь багтаасан 18x18м хэмжээтэй талбайд малтлагын ажлыг эхлэв. Малтлагыг эхлэхдээ булшны төвийг дайруулан уртраг, өргөргийн дагуу нэмэх хэлбэрийн 1м өргөн хамрыг хөрсний зүсэлт хийхэд зориулан үлдээсэн. Өнгөн хөрсийг булшны урд талын дараас чулуунаас эхлэн хуулсан бөгөөд ингэх явцад үүдэвч хэсгийн өрлөг илүү тодорхой харагдаж эхэлсэн. Бидний эхний авсан 18x18м хэмжээтэй талбайд үүдэвчийн хэсэг гүйцэд багтахгүй байсан тул талбайг урагш 1.5м-ээр сунгаж малтсан. Ингэснээр нийт малтлагын талбайн хэмжээ 18x19.5м хэмжээтэй болсон. Өнгөн хөрсийг цэвэрлэж дуусахад өргөн нь 16.5 м, урт нь 18.5 м хэмжээтэй чулуун дараас илэрсэн. Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад баруун талын чулуун хүрээ тэр чигтээ эвдэгдэж дараас чулуу зохион байгуулалтгүй болсон нь

мэдэгдсэн. Мөн булшны дараас чулууг бүх тал руу нь тарааж хаялсан болох нь илэрхий болж, дараас чулууны зохион байгуулалт бараг тэр чигтээ эвдэгдсэн болох нь илэрхий болов. Хамгийн бага эвдрэлтэй нь үүдэвчийн чулуун өрлөг л байлаа. Өнгөн хөрсийг хуулах явцад зүүн урд талын дараас чулуун дундаас цэцэг хэлбэрийн авсны хүрэл чимэглэл илэрч олдсон.



Булшны хашилага чулууг тодруулж гаргасан нь

Өнгөн хөрсийг хуулж баримтжуулсны дараа зөвхөн хүрээ чулууг үлдээж бусад дараас чулууг авсан. Ингэхэд булшны хүрээ чулууны хэмжээ 10.6 x 10.8 м хэмжээтэй болох нь мэдэгдсэн. Үүдэвчний урт 4.7 м, өргөн нь үүд хэсэгтээ 1.6 м, багалзуур хэсэгтээ 2 м өргөнтэй байлаа. Түүнчлэн дараас чулууг авах явцад зүүн хойд талын дараас чулуун дундаас ваарын хагархай, бугын хугархай эвэр зэрэг олдвор эд өлгийн зүйлс илэрч олдсон.

Бид малтлага судалгаа хийхийн хажуугаар Бэлхийн амны дурсгалт газрын дэвсгэр зургийг хоёр долгионы GPS төхөөрөмжийг ашиглан хийж гүйцэтгэсэн. Өнгөн хөрсийг хуулсны дараа булшны хүрээг багтай мэдэхийн тулд нэмэх хэлбэртэй үлдээсэн хамрыг дагуулан 1 м өргөнтэй траншийг хүрээ чулууны зах хүртэл татсан. Дээрх траншийг татсанаар булшны дараас чулууны хаяа болон булшны нүхний

хэмжээг багтай мэдэх боломжтой болсон. Өнгөн хөрсний хуулалт болон транш татсаны дараагаар малтлагыг үүдэвчнээс эхлэн явуулав. Үүдэвч булшны гүн рүү налуу байдлаар ордог тул байгалийн хөрс болон анх булсан шорооны заагийг таньж олоход дөхөм байдаг учиртай.

Үүдэвчний малтлагатай зэрэгцүүлэн хүрээ чулууны дотор талд малтлагыг үргэлжлүүлэв. Ингэхдээ талбайг хөндлөн хамраар хойд, урд хоёр хэсэгт зааглан, урд талбайг эхэлж малтахаар тогтов. Энэ нь малтлага болон баримтжуулалтын ажил давхцаж, хүлээлт үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байв. Урд талбайн баруун талаар байгалийн хөрс болон булшны нүхний зааг мэдэгдэхүйц ялгарч байлаа. Аюулгүй байдлын үүднээс чулуун хүрээний ерөнхий байдлыг алдагдуулахгүйгээр дотогш унах магадлалтай зарим том чулууг зайлуулав.

Урд талбайгаас гарсан шороог үүдэвчээр тэрэгний тусламжтай зөөж, булшны өмнө талын сул талбайд асгаж байсан бөгөөд зөөвөрлөлтөд саад учруулж байсан үүдэвчийн хөндлөн зүсэлтийг баримтжуулан, хамрыг авсан. Урд талбайн гүн 1.8 м хүрэхэд малтлага ажлыг түр зогсоож хөндлөн хамрын хойд талын талбайд малтлагыг үргэлжлүүлэн өмнөх хэсгийн гүнтэй тэнцүүлэн тэгшилсэн. Малтлагын гүн өнгөн хөрснөөс доош 2 м хүрэхэд булшны нүхний хэмжээ 7.5 x 5.4 болж багассан ба үүдэвчийн урт 5.8 м болжээ. Энэ үед малтлагаас гарсан шороо чулууг гараар зөөх боломжгүй болсон учир КАМАЗ Кран автомашин ашиглан малтлагыг үргэлжлүүлсэн.

Булшны нүхний гүн өнгөн хөрснөөс доош 4 м хүрэхэд булшны нүх

багасаж, дөрвөн талаасаа 70 см орчим хэмжээтэйгээр шаталж тонуулчдын нүхний голоос ваарын хагархай, төмөр эдлэлийн үлдэгдэл, модонд хадаастай маш нимгэн авсны хүрэл цэцгэн чимэг зэрэг олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдсон. Энэ үед булшны нүхний хэмжээ 5 x 3.3 м хэмжээтэй байв.



Малтлагын явц

Малтлага судалгааг цааш булшны Малтлага судалгааг цааш булшны нүхийг даган үргэлжлүүлсэн бөгөөд байгалийн хөрснөөс ялгахад тун төвөгтэй байсан. Харин тонуулчдын нүхний толбо маш тодорхой ажиглагдаж байлаа. Малтлагын гүн 4.5 м болоход тонуулчдын нүх 2 м голчтой булшны нүхний хойд болон төв хэсэгт мэдэгдэж байв. Энэ үеэс малтлагын талбайн хойд талаас модны үйрмэг хэсэг цөөнгүй илэрч байлаа.

5 м гүнээс малтлагын талбайн хойд, эртний тонуулчдын нүхний төв хэсгээс органик эдлэлийн дээр зүүж тогтоосон морины дүрс бүхий хүрэл чимэглэл нэг ширхэг илэрсэн. Мөн энэ үеэс малтлагын талбайн баруун урд хана талаас модны хэсэг илэрсэн. Тус модыг цэвэрлэхэд 2.6 м урт, хойд талдаа 32 см өргөн, урд талдаа 13 см өргөн нимгэн банз булшны нүхний баруун хана даган илэрсэн бол булшны нүхний урд хананаас 40 см зайд 1.5 м урт 7-9 см өргөн банз, булшны нүхний зүүн хананд шахсан 192 см урт, хойд хэсэгтээ 30 см өргөн, дунд хэсэгтээ 42 см өргөн, урд

талдаа 16 см өргөн нимгэн банз илэрсэн бол үүнээс дотогш 12 см зайд 6 см өргөн 180 см урт нарийн мод илэрсэн.



Малтлагын явц, гүн 5.1 м

Эдгээрээс гадна булшны нүхний төв хэсэгт хоорондоо 45 см зайтай, 70 см урд 8-18 см өргөн нимгэн банз мөн илэрснээс гадна хана дагуу байх банзны дээд талаар цэцгэн хэлбэртэй хүрэл чимэглэл долоон ширхэг (хадгалалт маш муу), нимгэн туузан төмөр чимэглэл анхны байдлаараа байв. Мөн малтлагын талбайн төв хэсэг, булшны нүхний төв хэсгээс хүний дунд чөмөгний ясны хэсэг илрэв.



Бунхны үлдэгдэл, гүн 5.2 м

Малтлагын талбайн хойд хэсэгт 1.6 м голчтой тонуулчдын нүх, 1.2 м голчтой галын ором байсан ба үүнийг тойроод шавар савны хагархай, төмөр эдлэлийн хугархай, модны үртэс үйрмэг их хэмжээгээр л илэрч байлаа. Малтлагын гүн 5.26 м гүн, дурсгалын оршуулгын хэсэг бүрэн тоногдож сүйдсэн байв. Булшны нүх 3.90x2.6 м хэмжээтэй, нимгэн авсыг нимгэн банзаар тагласан байсан бололтой.



*Адууны дүрс бүхий хүрэл чимэглэл илэрч
байгаа нь, гүн 5 м*

Дурсгалын оршуулгын хэсгийн баримтжуулалтыг хийсний дараа олдвор хэрэглэгдэхүүнийг аван, малтлагыг цааш үргэлжлүүлэхэд байгалийн эх хөрсөнд тулсан тул судалгааны ажлыг зогсоон эргүүлэн булж, нөхөн сэргээлтийг хийв.



*Олдвор хэрэглэгдэхүүнийг газар дээр нь
анхан шатны цэвэрлэгээ, бэхжүүлэлт
хийсний дараа*

1-3-Р БУЛШ

Энэ булш Бэлхийн амны Хүннүгийн дурсгалт газрын 1-р булшны зүүн талд байрлана. 1960 онд Монгол, Унгарын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн малтсан дагуул булшны хойд талд 11 м зайд, өнгөн хөрс үл мэдэг хонхойж, цөөн тооны чулуу цухуйсан байгаагаар мэдэгдэж байв. Малтлагын талбайг 8x7.5 м хэмжээтэй татан өнгөн хөрсийг хуулахад дурсгалын дараас чулуу тодорхой мэдэгдсэн хэдий ч зүүн болон хойд тал бүрэн ил гараагүй тул малтлагын талбайг зүүн тийш 1, хойд тал руу 50 см сунгахад 8.3 м голчтой, голдоо чулуугүй хонхор, дараас чулуу илрэв (зураг 32). Дараас чулууны хойд хэсэг сийрэг, урд хэсэг чулуу ихтэй байгаа нь өмнө тонуулчдын гарт өртснийг илтгэх бөгөөд дараас чулууны дунд хэсэгт тонуулчдын нүхний ор үл ялиг мэдэгдэж байлаа.



Дагуул булшны малтлагын явц

Дурсгалын баримтжуулалтыг хийсний дараа, дараас чулууны төв хэсэгт цөөн тооны чулууг зайлуулан малтлагыг үргэлжлүүлэн хойд хэсэгт 55 см, урд хэсэг 40 см гүн болоход малтлагын талбайн төв хэсэгт зүүн хойд зүгт чиглэлтэй 3.6x2.8 м хэмжээтэй бор хүрэн өнгийн хөрс бүхий булшны нүхний толбо цайвар шаргал өнгөтэй, шаварлаг хадархаг хөрснөөс тодорхой ялгарч байлаа. Булшны нүхний баруун

талаар чигжээс маягийн чулуу шигүү байгаа нь мөн л тонуулчдын үлдээсэн ул мөр бололтой. Малтлагыг цааш булшны нүхний толбыг дагуулан үргэжлүүлэхэд 1.7 м гүнд булшны нүхний зүүн хойд талаас шавар савны амсрын хагархай илрэв. Малтлагын энэ түвшин хүртэл ямар нэгэн чигжээс чулуу илэрсэнгүй.



Дагуул булшны малтлагын явц

2.1 м гүнд булшны нүхний төв хэсгээр харьцангуй жигд дарсан булшны чигжээс чулуу илэрсэн ба хойд хэсгийн чигжээс чулуу халуун галд улайссан, эргэн тойрны хөрс нь мөн түлэгдэж улаан болсон байлаа. Малтлага судалгааг цааш үргэлжлүүлэн гүн 2.25 см болоход 2.3х0.8 м хэмжээтэй модны нүүрстэй холилдсон хөрс бүхий толбо илэрсэн (зураг 35) ба малтлагыг цааш тухайн толбыг дагуулан явуулахад байгалийн хаданд тулав. Тухайн үеийн баримтжуулалтыг хийсний дараа булшны нүхний зүүн баруун хана руу шалгалтыг хийн ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрээгүй тул эргүүлэн булж нөхөн сэргээлтийг хийсэн.

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх ажлын хэсгийн хүрээнд уг дурсгалын хамгаалалтын бүсийг тогтоосон бөгөөд дурсгалын хадгалалт хамгаалалт, ил үзмэр, мэдээллийн төв, үйлчилгээний хэсгийг харуулсан төлөвлөлт бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох урьдчилсан эскиз зураг гаргах ажлыг гүйцэтгэж байна.

Бид бүхний хамтарсан судалгаа нь олон чухал үр дүнд хүрснийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд археологийн малтлага судалгааг цаашид тогтмол явуулж, түүхэн дурсгалт газрыг хадгалан хамгаалж, соёлын өв, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон, олон нийтэд зөв зохистой сурталчлан таниулах шаардлагатай байна.

**Н.Батболд, Б.Анхбаяр,
Г.Галдан, С.Энхболд**
*(Монгол Улс, ШУА-ийн
Археологийн хүрээлэн)*



ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал,
доктор, дэд профессор
Ж.БАТ-ИРЭЭДҮЙ



МЭНДЧИЛГЭЭ

Унгар, Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тохиолдуулан Монгол хэл бичгийн улбаатай монгол судлалын эртний түүхтэй Унгар улсын монгол судлаач, эрдэмтэн та бүхний түмэн амгаланг эрэн мэндчилье.

Унгарын монгол судлаачид, эрдэмтэд өнгөрсөн он жилүүдэд Монгол Улсын ШУА түүний дотор Хэл зохиолын

хүрээлэнтэй он удаан жил хамтран ажиллаж, эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлж, эрдэм шинжилгээний ажилтан солилцож, Унгарын их сургуулиудад монгол хэл бичиг заах, Монгол оронд эрдэм шинжилгээний экспедиц зохион байгуулах зэрэг олон хэлбэрээр идэвхтэй хамтран ажиллаж байгааг баярын энэ өдрүүдэд бахархан тэмдэглэж байна.

Та бүхний цаашдын эрдэм судлалын ажилд өндөр амжилт хүсэн ерөөе.

УНГАРЫН МОНГОЛ СУДЛАЛЫН УГ СУУРЬ НЬ МОНГОЛ ХЭЛ БИЧИГ БИЛЭЭ

Унгарын монгол судлалын уг суурь нь анхнаасаа хэл бичгийн ухаан байсан юм. Унгарын монгол судлал анх ЭЛТЭ их сургуулийн Төв Ази Судлалын тэнхимд төвлөрч байсан бол мөн Унгарын ШУА-ийн Угсаатны зүйн хүрээлэн, Сэгэдийн Их сургуулийн Алтай судлалын тэнхимд үргэлжлэн бий болж, Шинжлэх Ухааны Академийн Дорно дахины судлалын салбарт монгол судлалын арвин бөгөөд онцгой бүтээлүүдийг нандигнан хадгалж байна.

Д.Мөнх-Очир нарын бичсэн “Дэлхийн монгол судлал” номд, “XIX зууны хэлбичгийн ухааны хөгжил болон тухайн үеийн Сибирь болон Төв Азийг судалсан шинжилгээний ангиудын үр дүн тайланг олон нийтэд мэдээлж, үүний үндсэн дээр мажар (унгар) үндэстний өвөг дээдэс ямар гаралтай, Азийн аль нутгаас нүүж ирсэн гэсэн асуулт тавигдсан. Үүний хариуг хайж байсан улсуудын дотор түүхийг гажуудуулагчид нэлээд гарч байсан боловч шинжлэх ухааны талаар тайлбарлахыг хичээсэн зүтгэлтнүүдийн зарим нь монгол судлалыг үүсгэн байгуулагч болсон юм.” (Д.Мөнх-Очир нар, Дэлхийн монгол судлал, II, Уб., 2015, 178 дахь талд.) хэмээн дурджээ.

Унгарын монгол судлал бол монгол хэлний ярианы хэлийг анх удаа тэмдэглэн ном бичсэн Сэнткатолнаи Балинт Габор/Gábor Bálint de Szentkatolna (1844-1913)-ын хэл шинжлэлийн бүтээлээс эхтэй бөгөөд мөн Будэнц Жозеф/Joseph Budenz (1836-1892) ЭЛТЭ их сургуульд монгол хэлний хичээл зааж, унгар хэлээр

сонгодог монгол хэлний анхны сурах бичгийг 1887 онд бичсэнээр эхлэсэн гэж үздэг. Балинт Габор бол 1870-аад оноос Оросын Казань болон Халимаг, буриад, Монгол улсад удаан сууж халимагуудын үлгэр, тууль, дуу, ярианы хэлийг судалж, халимаг, буриад, монгол хэл маш сайн сурсан нэгэн байсан ба 1877 онд “Хойд Буриад аялгууны тэмдэглэл” нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлжээ. Мөн Луйс Лоций (Louis Lóczy) 1877-1880 онд Өвөр Ази болон говиор газар зүйн шинжилгээ хийж, Азийн газрын зураг зурж, Стэйн/Sir Aurel Stein (1862-1943) хэмээх аялагч, судлаач 1903-1908 онд Торгоны зам дагуу аялж, Туркестан, Турфанд судалгаа хийж, Турфаны агуйг үзэж, олон зүйлийг авч явсан ч хожмоо тэдгээрээсээ Английн музейд өгсөн.

Ийнхүү XIX зуунаас эхлэсэн Унгарын монголын судлал XX зуунд улам эрчимжин Өтвөш Лорандын Их Сургуульд нэрт эрдэмтэн Пэллио, Маспэро нарын шавь Лигэти Лайоши (1902-1987) гучаад оноос монгол судлалын лекцүүд уншиж монгол бичгийн хэлний эх сурвалжуудын судалгаа хийж, тэр тусмаа “Монголын нууц товчоон” зэрэг түүхийн чухал бүтээлүүдийг унгар хэлнээ орчуулан, мөн галигийг сийрүүлэн хийж “Monumenta Linguae Mongolicae Collecta” цувралаар хэвлүүлсэн нь монгол судлалаар нэрд гарах алхам болсон юм.

1940-өөд оноос Их сургуулийн Төв Ази судлалын тэнхим бий болж монгол судлалын залуу үе өсч хүмүүжин нэрт эрдэмтний шавь Сабоо Тэрээ Мария, Надь Лайош, Уриа Көхмали Каталин,

нар төв ази болон монголчуудын угсаатны асуудал судлан гарч иржээ. Мөн монгол хэл бичгийн судлал Сэгэдийн Их Сургуульд Рона Таш Андрааш алтайн хэлнүүдийн түүхэн харилцаа холбоог судалж, Кара Дёрдь буюу Хар Дорж (1935-) гуай Төв Ази судлалын тэнхимд монгол хэл бичгийн сурвалж бичиг, ном судлал, монгол хэлний нутгийн аялгуу, монгол төвөд уйгар хэлээр туурвисан бурхны шашны дурсгалууд, төвөд монгол шашны нэр

томьёог гүнзгий судалж гарч иржээ. Мөн дараа дараагийн залгамж халаа, залуу үе төрсөөр байлаа. Тухайлбал, Шаркози Ализ (1942-) монголчуудын бурхан шашны дурсгал, төвөд монгол шашны нэр томьёо, Мэллэш Корнэлиа манж судлал, Бэтхлэнфалви Гээза төвөдийн бурхан шашин болон төвөд монголын шашны харилцааны сэдвээр судалгаа хийж, Татар Магдолно монгол угсаатнуудын эдийн ба оюуны өв, хэл соёлыг нарийн судалж эхлэв.



Монголын нэрт эрдэмтэн Бямбын Ринчен 1956 онд Унгарын Шинжлэх Ухааны Академид хэлбичгийн ухааны докторын зэргийг хамгаалж үүний дараа 1958 оноос эхлэн Лигетигийн шавь Кара Дёрдь, Урай-Көхмали (1926-2012), Рона-Таш (1931-), Бэшэ Лаюш (1926-1988), Габори Миклош (1925-1996) нарыг Монгол улсад хэл бичиг, нутгийн аялгуу, угсаатны зүйн хээрийн судалгааг хийхийг урьсан нь Унгарын монгол судлаачдад олон арван жил

энэ чиглэлийн судалгаа хийх үндэс суурь болсон байна. Ингэж хээрийн судалгааны экспедиц олон арван жил үргэлжилж, үе үеийн монголч эрдэмтэд үүнд хамрагдаж, судалгааны үр дүнгүүдээ олон улсын монголч эрдэмтдэд танилцуулж, Унгарын монгол судлалын цувралуудаар хэвлүүлж ирсэн нь Унгарын монгол судлал хүчтэй байхын бас нэгэн үндэс болжээ.

Унгарын монгол судлал, эрдэмтдийн нэг онцлог бол 1990-ээд оны улс төр, нийгэм, эдийн засгийн хүнд хэцүү цаг үед ч Монгол Улсад ирж хээрийн шинжилгээний ангийг тасралтгүй явуулж өдгөө хүртэл үргэлжлүүлэн хийсээр байгаа явдал юм. Үүнийг Rottar Mate гэж нэрлэдэг ажээ.

Эдгээрээс өнөөгийн Унгарын монгол судлалыг оройлон удирдаж, чиглүүлж яваа эрдэмтний хувьд Бирталан Агнеш

багшийг онцгойлон дурдах ёстой. Тэрбээр нэрт эрдэмтэн Хар Дорж багшийн гарын шавь бөгөөд одоо ЭЛТЭ их сургуулийн Хүмүүнлэгийн факультетийн Монгол болон Төв Ази судлалын тэнхимдээ монгол судлалын салбарыг тэргүүлж, Дорно дахины хүрээлэнгийн дэд захирал, ОУМСХолбооны Ерөнхийлөгчөөр ажиллаж байна.



Мөн 2014 оны 10 дугаар сараас Монгол Улсын БСШУЯам болон Унгарын Өтвөш Лорандын нэрэмжит Их сургуулийн (ЭЛТЭ) гэрээний дагуу тус их сургуулийн Монгол, Төв Азийн судлалын Тэнхимийн дэргэд Монгол судлалын төвийг тусгайлан байгуулаад идэвхтэй ажиллаж байна.

Өнгөрсөн он жилүүдэд Унгарын эрдэмтэд дангаараа болон монгол зэрэг бусад орны эрдэмтэдтэй хамтран монгол судлалын олон арван гайхалтай бүтээлүүдийг хэвлэн нийтлүүлсэн. Тухайлбал бид энд зарим бүтээлүүдийг

нэрлэж чадна. Үүнд Georgy Kara, “Books of the Mongolian Nomads”, Indiana; A.Birtalan, Gabor Balint of Szentkatolna, “A Romanized grammar of The East and West Mongolian languages” 2009, “Аврагдсан туульс/ Rescued Epics”, Ágnes Birtalan “Oirad and Kalmyk Linguistics Essays”, G.Kara, “The Mongol and Manchu manuscripts and Blockprints in the Library of the Hungarian Acaedmy of Sciences”, “Манж, хятад, монгол, тод үсэг хавсарсан толь бичиг” зэрэг бүтээлүүдийг юуны урд дурдалтай.

Өнөөгийн Унгарын монгол судлалын судалгааны чиглэл нь монгол хэл бичгийн судалгаа төдийгүй монголын олон ястны аман билиг соёл, нутгийн аялгуу, аман зохиол судлал, бөө мөргөл, ардын шашин, бурхны шашин, сүм хийдийн түүх, түүхэн экологи, хэл шинжлэл, түүх зэрэг олон асуудал руу нэвчин орж байгаа бөгөөд энэ чиглэлээр олон арван залуусыг элсүүлэн сургаж, Унгарын монгол судлал сайн сайн эрдэмтэн залуусаар бэхжсээр байгаад бид сэтгэл нэн ханамжтай байдаг юм.

Ийнхүү Унгарын монгол судлалын байдлыг монголын эрдэмтний хувиар тоймлон дүгнэвэл шинэ мянганд

монгол судлалын хуучны уламжлалтай энэ улсад монгол судлалын төв улам өргөжин тэлж, үйл ажиллагаагаа илүү эрчимжүүлж, угсаатны зүй, археологи, шашин судлалын чиглэлээр идэвхтэй ажиллаж, монгол судлалын залуу халааг олноор нэмэн бэлтгэж, Монгол Улс түүний дотор ШУА, МУИС зэрэг байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, Зүүн Европын монгол судлалын нэгэн чухал төв байсаар байж, Унгарын монгол судлалын ирээдүйтэй, гэрэлтэй, эрдэм мэдлэг ундарсан, өөрийн гэсэн онцлогтой төв байгуулж байна гэж дүгнэж болохоор байна.

*Хэл бичгийн шинжлэх ухааны доктор,
МУИС-ийн дэд профессор*
Ж.Бат-Ирээдүй



БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН



Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал,
доктор, дэд профессор
И.ТҮВШИНТОГТОХ

МЭНДЧИЛГЭЭ

Манай хүрээлэн Монгол орны байгалийн ургамлын ангилалзүй, ургамалжил, ой, түүний хөдлөлзүй доройтол, нөхөн сэргээлт, ашигт ургамлын тархац, нөөц, ашиглалт, биоморфологи, тарималжуулалт, нэн ховор, ховор ургамлын хамгааллын судалгаа болон Ботаникийн цэцэрлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Манай хүрээлэнгийн Ургамлын ангилалзүй, филогенетикийн лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гантуяа 2016 оноос Унгарын Шинжлэх Ухааны Академийн Экологийн судалгааны төв, Экологи-

Ботаникийн хүрээлэнгийн эрдэмтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D) Молнар Жолтоор удирдуулсан, уламжлалт экологийн мэдлэгийн судалгааны багт орж ажиллан, 2021 онд Унгар улсын Өтвөш Лорандын Их Сургуулийн докторантурт энэ чиглэлээрээ суралцаж байгаад баяртай байна. Байгууллага хоорондын хамтын ажиллагаа нь судлаачид, эрдэмтдийн хамтын ажиллагаан дээр тогтдог тул цаашид манай хүрээлэн Унгар улсын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, судалгааны төслүүдийг хэрэгжүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гантуяа Өтвөш Лорандын Их Сургуулийн докторантурт суралцаж байна



2017 оны зуны хээрийн судалгаа, Хөвсгөл аймаг, Арбулаг сум.
Баруун гар талаас: P.Jigjid, Boglárka Anna Éliás, Gantuya Batdelger, Ákos Avar, and
Molnár Zsolt

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн хувьд одоогоор Унгар улсын шинжлэх ухааны академитай хамтарсан албан ёсны төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байгаа юм. Гэхдээ Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гантуяа Унгарын Шинжлэх Ухааны Академийн Экологийн судалгааны төв, Экологи-Ботаникийн хүрээлэнгийн эрдэмтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D) Молнар Жолтоор удирдуулсан, уламжлалт экологийн мэдлэгийн судалгааны багт 2016 оноос хойш одоог хүртэл хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Монгол болон Унгар малчдын уламжлалт экологи, биологийн мэдлэгийн талаар судалгааны ажил хийж байгаа юм.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Б.Гантуяа нь 2016-2020 онд Монголд хийсэн судалгааныхаа ажлын үр дүнгээр Нэгд, “A Herder’s Suty to Think”: Landscape Partitioning and Folk Habitats of Mongolian Herders in a Mountain Forest Steppe (Khvusugul-Murun region), Хоёрт, How Mongolian Herders Percieve Ecological Change in ‘Stable’ Landscape нэртэй хоёр томоохон шинжлэх ухааны өгүүллийг амжилттай хэвлүүлээд байна.

Уламжлалт экологийн мэдлэг гэдэг нь тухайн нутгийн хүмүүсийн олон зуун, мянган жилийн турш байгаль орчинтой шууд шүтэлцэн амьдрах замаар олж авсан болон тэдний өв соёлд шингэн үеэс үед ам дамжин өвлөгдсөн мэдлэг юм. Ерөнхийдөө уламжлалт биологийн судалгаа нь Азийн орнуудын хувьд тренд болж буй сэдэв бөгөөд Пакистан, Энэтхэг,

Непал, Хятад зэрэг орнуудад маш олон судалгааны өгүүлэл хэвлэгдсэн байдаг. Дэлхий дээр мал аж ахуй эрхэлдэг олон улс үндэстэн байдаг ч Монголчуудын мал аж ахуйтай холбоотой соёл, түүх хаана ч давтагдашгүй өвөрмөц өнгө төрхтэй бөгөөд ургамал, амьтан, байгаль экологийн талаар маш нарийн, гүнзгий ойлголттой байдаг. Гэхдээ түүнийг илрүүлсэн судалгаа харахан хийгдээгүй байгаа юм.

Сүүлийн үед угсаатны биологийн судалгааны гол чиглэл нь газар, бэлчээр ашиглалтын уламжлалт арга туршлага, нөөцийн тогтвортой ашиглалтыг судлахад түлхүү анхаарч байна (Молнар, 2014). Өнгөрсөн жилүүдийн жишээнүүдээс харахад, бэлчээрийн менежмент муу, малын тоо толгой өссөнөөс болж олон газар бэлчээр доройтоод байгаа. Тэгвэл орчин үед уламжлалт экологийн мэдлэгийн

судалгаа нэмэгдэж байгаагийн хэрээр олон улсад энэхүү арга туршлагыг газар ашиглалт, бэлчээрийн менежмент, тогтвортой хөгжил зэрэгт ашиглах болсон. Иймд малчдын уламжлалт мэдлэгийг орчин үеийн шинжлэх ухааны арга барилтай хослуулан ашиглах, судлах, цаашлаад байгаль хамгааллын асуудалд зайлшгүй шаардлага бий. Энэхүү судалгааг гүнзгийрүүлэн судлах зорилгоор Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гантуяа Унгар улсын Eötvös Loránd University (ELTE)-ийн Шинжлэх ухааны факультет, Ургамлын ангилалзүй, Экологи, Онолын биологийн тэнхимд (in English: Faculty of Science, Department of Plant systematics, Ecology and Theoretical Biology) этноботаник, этноэкологийн чиглэлээр докторын хөтөлбөр (2021-2024)-т суралцаж байна.



Унгарын ШУА-ийн Экологи, Ботаникийн хүрээлэнгийн судлаач Molnár Zsolt (Sc.D), Biró Marianna (Ph.D), Molnár Ábel (Ph.D student) болон Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн (хуучнаар Ерөнхий болон Сорилын биологи) -гийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гантуяа (Ph.D student) нар 2019 оны 7 сарын 18-нд Монгол болон Унгарын уламжлалт экологийн судалгаа, хамтын ажиллагааны талаар болон өөрсдийн судалгааны ажлын зарим үр дүнгээр семинар хийлээ.



ГАЗАРЗҮЙ, ГЕО-ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



Газарзүй, Геоэкологийн хүрээлэнгийн захирал,
доктор
А.ДАШЦЭРЭН

МЭНДЧИЛГЭЭ

Өнгөрсөн зууны дунд үеэс манай улсын төр засгаас хөдөө аж ахуйн салбарыг системтэй хөгжүүлж эхлэх цогц хөтөлбөр, бодлогууд боловсруулж эхэлсэн ба үүнтэй холбоотойгоор шинээр уст цэгүүд олж тогтоох, ус ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх, бэлчээр усжуулалтын ажлыг зохион байгуулах зэрэг мэдлэг, тоног төхөөрөмж шаардсан ажлууд хийх хэрэгцээ үүсжээ.

Энэ цаг хугацаатай давхцаж 1957 оны 3 дугаар сард Монгол, Унгарын Засгийн газар хооронд усны аж ахуйн талаар хамтран ажиллах гэрээ байгуулагдсан байна. Хамтран ажиллах гэрээний дагуу Монгол улсын нутаг дэвсгэр дээр худаг ус гаргах, усны хайгуул хийлгэх зорилгоор Унгар улсаас геофизик, өрөмдлөгийн мэргэжилтнийг урьж, машин механизм, тоног төхөөрөмж захиалан авсан байдаг. Улмаар хоёр улсын мэргэжлтнүүд хамтран Төв, Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудын нутгуудад ус эрж хайх, худаг гаргах ажлын талбарт амжилттай ажиллаж эхэлжээ. Тухайлбал, 1961-1970 онд Унгар улсын тусламж, өрөмдлөгийн хамтарсан

экспедицийн үр дүнд 400 гаруй худаг бүтээн бий болгосон нь манай орны өргөн уудам, атар зэлүүд бэлчээрийг усжуулах, төв суурин, үйлдвэр аж ахуйн газруудыг усаар хангахад ихээхэн ач холбогдол үзүүлсэн билээ.

Унгар улсаас Монгол улсын усны салбарт үзүүлэх тусламж жилээс жилд өсөн нэмэгдэж байв. 1966-1970 онд жил бүр 32-34 тооны эрдэмтэн судлаач, мэргэжилтнийг усны менежментийг сайжруулахад урьж оролцуулсан явдал нь манай орны усны салбарын хөгжилд чухал ач холбогдол зүйл болсон байдаг.

1970 оны эхэн үеэс Монгол орны хөгжил цэцэглэлт, усны хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан усны нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, хүн амын ундны усыг зөв төлөвлөх, эдийн засгийн салбаруудын усны хэрэгцээг сайжруулах, хүртээмжтэй хангах усны менежментийг зохиох, системтэй төлөвлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон байна. Энэ хүрээнд 1971-1975 онд уг хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан “Монгол улсын усны нөөц, баялгийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах

ерөнхий схем” таван боть бүтээлийг Унгар улсын тусламжтайгаар, Монгол улсын Усны аж ахуйн яамны Усны хайгуул төсөл, эрдэм шинжилгээний институт, Унгар улсын Усны аж ахуйн улсын төв байгууллагын Усны нөөц, ашиглалтын удирдах газрын оролцоотойгоор боловсруулан гаргасан байдаг. Энэхүү бүтээлд Монгол орны байгаль, уур амьсгалын нөхцөл, газрын доорх болон гадаргын усны нөөц, чанарт үнэлгээ өгч эдийн засгийн салбаруудын усны хэрэглээ, ашиглалтын тухайн үеийн байдал, хэтийн төлөвийг үйлдвэрлэлийн хөгжлийн байршилтай уялдуулан тооцож, түүнийг хангах боломж, усны салбараас авч хэрэгжүүлбэл зохих менежментийн бүх арга хэмжээг дэс дараатайгаар тусгасан байдаг. 1980-1989 онд дээрх бүтээл дээр үндэслэн бүс нутгийн усны нөөц, түүнийг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг нэгдмэлээр төлөвлөн хүн ам, эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх хэтийн төлөвийг тусгасан “Усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах схем”-ийг зургаан том сав газраар нарийвчлан боловсруулж гаргасан. Эдгээрээс “Хэрлэн”, “Их нууруудын хотгор”, “Умард говь” сав газрын усны

нөөцийг иж бүрэн ашиглах, хамгаалах схемийг хоёр улсын усны аж ахуйн институт хамтран боловсруулсан бол “Онон, Улз, Халх гол” “Алтайн өвөр говь” зэрэг голуудын сав газрын схем боловсруулах ажилд Унгарын эрдэмтэн судлаачид зөвлөгөө өгч оролцон ажилласан юм.

Цуврал бүтээлүүдэд нь одоог хүртэл Монгол орны усны салбар, усны менежментийн төлөвлөлт болон судалгаа, шинжилгээний ажилд ашиглагдаж буй томоохон тулгуур материал болсоор байгаа бөгөөд бүтээлүүдийг 2005 онд Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв, Шинжлэх ухааны академи, Монголын залуу үеийн хөгжлийн ассоциациас “XX зууны шинжлэх ухааны шилдэг бүтээл”-ээр шалгаруулан Улсын Их Хурлын даргын ивээл дор хүндэтгэн өргөмжилсөн юм.

Монгол улсын усны салбарын хөгжил дэвшилд оруулсан Унгар улсын эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн хувь нэмрийг бид бүхэн өндрөөр үнэлж, үргэлж талархаж явдаг юм. Хоёр орны шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагаа цаашид улам бүр өргөжин хөгжинө гэдэгт гүнээ итгэж байна.

БНУАУ-ААС МАНАЙ УСНЫ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГТ ИХЭЭХЭН БОДИТ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЖ БАЙСАН БИЛЭЭ

1. Монгол орны бэлчээр нутгийг усжуулах ажлын хүрээнд:

Бэлчээр усжуулалтын ажлын хэмжээ, далайцыг өргөтгөх, ажлын зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор 1938 онд Мал ба газар тариалангийн яамны дэргэд тус ажлыг удирдан чиглүүлэх үүрэг бүхий Монгол Улсад анх усны мэргэжлийн байгууллага болох “Ус хангамжийн департамент”-ийг байгуулсан нь усны аж ахуйг эрхэлсэн анхны төрийн байгууллагын суурь болсон байна. Энэ үеэс усаар дутагдалтай говийн аймгуудад энгийн худаг гаргах, гидрогеологийн зураглал хийх, газрын доорх усны горимыг судлах ажлыг гүйцэтгэхээс гадна усгүй болон усны хомсдолтой бэлчээрт худаг гаргаж мал аж ахуйн тэжээлийн байгалийн нөөцийг нэмэгдүүлэх, уст цэгийг бүртгэлжүүлэх, хамгаалах ашиглалтыг сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна (Дэмбэрэл ба Дамба, 1975).

Монголд усжуулалтын арга хэмжээ өргөжиж, хуурай уур амьсгалтай, гадаргын усаар дутагдалтай тал, говийн бүсэд юуны өмнө газрын доорх усыг ашиглах замаар эдийн засгийн салбаруудын усны хэрэгцээг хангах зорилт тавигдаж гадаад орнуудаас тусгай экспедицийг урьж ажиллуулсан юм. Монгол, Унгарын усны аж ахуйн хамтын ажиллагаа 1957 оны 3 дугаар сард Монгол, Унгарын засгийн газрын хооронд усны аж ахуйн талаар хамтран ажиллах гэрээ байгуулагдсанаар эхэлсэн түүхтэй. Газрын доорх усыг эрж хайхад геофизикийн арга нэвтрүүлэх, өрөмдмөл худаг байгуулах зэрэг ажлыг

өргөтгөхөөр БНУАУ-аас геофизикийн ба өрөмдлөгийн мэргэжилтнийг урьж, машин механизм, тоног төхөөрөмж захиалан авч Төв, Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудын нутагт ажиллуулсан байна. 1957-1959 онд БНУАУ-аас манайд хийгдэж байсан усны эрэл хайгуул, өрөмдлөгийн салбарын ажил болон тэдгээрт шаардагдах тоног төхөөрөмж, багаж материалын үнэ хөлс нь гадаад худалдааны тооцоогоор төлөгдөж байсан бөгөөд харин 1960 оноос Унгарын тал манай усны аж ахуйд 600 мянган рублийн (хуучнаар) буцалтгүй тусламж олгосон юм. 1961-1970 онд БНУАУ, манай усны аж ахуйд зориулан урт хугацааны зээл олгож эдийн засгийн тусламж үзүүлсний үрээр тус оронд Унгараас усны эрэл хайгуул, өрөмдлөгийн экспедиц ажиллаж 400 гаруй өрөмдмөл худаг байгуулсан нь их хэмжээний атар зэлүүд бэлчээрийг усжуулах, төв суурин, үйлдвэр аж ахуйн газруудыг усаар хангахад ихээхэн ач холбогдолтой болсон билээ.

БНУАУ-аас Монгол улсын усны салбарт үзүүлэх тусламж жилээс жилд улам нэмэгдэж усны салбарын хөгжилд шийдвэрлэх ач холбогдол үзүүлсэн юм. 1966-1970 онд БНУАУ-аас 30 гаруй мэргэжилтнийг жил бүр урьж 1.6 сая рублийн зээлийн хөрөнгө авч усны салбарын менежментийг сайжруулахад нэлээд арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Бэлчээр нутгийг усжуулах, газрын доорхи усны эрэл хайгуулын ажилд хийсэн геофизикийн судалгааны үр дүн их бөгөөд олон мэргэжилтнийг


дагалдуулан сургаж техник технологийн тухай ном бичиж, Унгарт усны аж ахуйн чиглэлээр инженер техникийн ажилтан, мэргэжилтнүүд бэлтгэн, УХТЭШХүрээлэнгийн судлаач гидрогеологч Ч.Лувсандорж /1979/, гидрологч Б.Дэшигдорж /1985/ нарыг докторын зэрэг хамгаалах сургалтад урьж цол хамгаалахад туслаж байсан юм.


Говийн болон баруун аймгуудад баригдсан усалтын жижиг системүүдэд шаардагдах бороожуулах усалгааны төхөөрөмж, сэлбэг материал, мөн геофизикийн хайгуулын ажилд шаардагдах багаж хэрэглэлээр тогтмол хангах, гидрохимийн лабораторийг тоноглож, 1984 онд монголд анх удаа Усны институтэд IBM –ийн компьютерээр тоноглогдсон мэдээллийн сан боловсруулах бааз байгуулж өгч байлаа.

2. Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах ерөнхий ба сав нутгийн төлөвлөлтөөр:

1970 оны эхэн үеэс усны хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан манай орны усны нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, хүн амын унд ахуй, эдийн засгийн салбаруудын усны хэрэгцээг сайжруулах, хүртээмжтэй хангах усны менежментийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон байна. Энэхүү зорилгоор БНУАУ-ын тусламжтайгаар “**Монгол Улсын усны нөөц, баялгийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах ерөнхий схем**” таван боть бүтээлийг БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1971 оны 8-р сарын 07-ны өдрийн 270-р тогтоолын заалтыг биелүүлэх үндсэн дээр БНМАУ-ын Усны Аж Ахуйн Яамны Усны Хайгуул төсөл, Эрдэм Шинжилгээний Институт,

БНУАУ-ын Усны Аж Ахуйн Улсын Төв байгууллагын Усны нөөц, ашиглалтын төв удирдах газрын оролцоотойгоор 1971-1975 онуудад боловсруулан гаргасан байна. Тус бүтээлд “Монгол орны голын олон жилийн дундаж урсацын модуль”, “Газар доорх усны нөөц”, “Усны аж ахуйн байдал”, “Гол мөрний усны нөөц”, “Бэлчээр усжуулалт ба усалгаатай газар тариалан”, “Усны эрчим хүч, усан тээвэр, усны нөөцийг зохицуулах арга хэмжээ” зэрэг 1:1 000 000-1:1 2000 000 масштабтай нийт 32 цуврал зургийг боловсруулан гаргажээ (Зураг-1). Энэхүү бүтээл нь Монгол орны байгаль цаг уурын нөхцөл, газрын доорх болон гадаргын усны нөөц, чанарт үнэлгээ өгч эдийн засгийн салбаруудын ус хэрэглээ-ашиглалтын тухайн үеийн байдал, хэтийн төлвийг үйлдвэрлэлийн хөгжлийн байршилтай уялдуулан тооцож, түүнийг хангах боломж, усны салбараас авч хэрэгжүүлбэл зохих менежментийн бүх арга хэмжээг дэс дараатайгаар тусгасан байдаг.





Зураг-1. “Монгол Улсын усны нөөц, баялгийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах ерөнхий схем”-ийн зарим зургууд

Энэ “Ерөнхий схем”-ийн зохицуулагчаар Унгар Улсын талаас Усны аж ахуйн Ерөнхий газрын, Усны Нөөцийг Ашиглах Төв Удирдах Газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Бекеш, Ерөнхий хэлтсийн дарга И.Балло, ерөнхий удирдагчид Т.Фритч, Л.Терек, схемийн I-IV боть бүтээлийг боловсруулахад А.Альтнедер, Ч.Боршош, П.Каркуш, Ш.Кернач, Е.Чанады, Б.Чермак, А.Виало, И.Иллеш, И.Балло, Я.Бекеш, И.Цинкотски, Б.Новаки, И.Пап, Ф.Папп, Д.Селлеши, К.Саны, Л.Башша, Г.Башша, Л.Дердь, И.Немет, И.Чики монголын талаас Д.Доржготов, Ж.Сүхээ, Л.Төмөр, Г.Хандай, Г.Цэрэнжав нарын олон залуус ажилласан байна. Схемийн I-V боть бүтээлийг боловсруулахад Монгол

талаас Усны Аж Ахуйн Яамны Усны Хайгуул Төсөл, Эрдэм Шинжилгээний Институтийн захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Чагнаа, Ерөнхий удирдагч доктор Г.Хандай нараар удирдуулсан монголын олон арван эрдэмтэн судлаачид оролцож гүйцэтгэсэн юм.

Энэхүү “Монгол Улсын усны нөөц, баялгийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах ерөнхий схем” цогц бүтээл Монгол орны байгаль цаг уурын нөхцөл, нийгэм эдийн засгийн хөгжлийн тулгуур хүчин зүйл усны нөөцийн үүсэх, саринах зүй тогтлыг маш тодорхой гаргаснаараа зөвхөн усны аж ахуйн төдийгүй хөдөө аж ахуй, эрчим хүч, усны эрсдлээс хамгаалах, байгаль орчныг хамгаалах олон асуудлыг тодорхой тусгаснаараа одоо ч үнэ цэнээ алдаагүй бүтээл болсон юм. Бүтээлд усны нөөц баялгийн хэмжээ, чанарт үнэлгээ өгч Монгол орны нутаг дэвсгэрт орших дэлхийн усны гурван том ай савыг тодорхойлж, 64 усны аж ахуйн нэгжийг тогтоон усзүйн цуврал зургуудыг зохиосон юм. Ерөнхий схемд зурагзүйн аргыг хэрэглэх замаар Монгол орны нийт усан баялгийг 34.6км³ /жил гэж тооцоолон гаргаснаас гадна манай орны нийт газар нутгийн 20.5%-ийг эзлэх Хойт мөсөн далайн ай савд энэ усан баялгийн 17.8км³/жил буюу 51.5% нь, газар нутгийн 11.5%-ийг эзлэх Номхон далайн ай савд 4.1км³ /жил буюу 11.8% нь, газар нутгийн 68.0%-ийг эзлэх Төв Азийн гадагш урсацгүй ай савд 12.7км³/жил буюу усан баялгийн 36.7% нь тус тус оногддог болохыг анх удаа тодорхойлсон байна. Монголд 3 том ай савын огтлол оршдгийг тогтоосон бөгөөд хожим 1990 онд УХТЭШИ-ийн судлаачид тэрхүү цэг дээр дурсгалын хөшөө босгосон юм.



*Фото-1, Гурван ай савын хагалбар цэг,
олон улсын усны өдөр усны салбарын хамт
олон 3-р сарын 22-нд*

Тус схемийн 5-р боть болох Атласын зургуудад дээрх арга хэмжээнүүдийг зурагзүйн аргаар бүрэн дүрслэн харуулсан бөгөөд атлас нь 1:1 000 000-ын масштабтай-3, 1:2 500 000-ын масштабтай -9 үндсэн зураг, 1:6 000 000, 1:12 000 000-ын масштабтай -20 туслах зургаас бүрдсэн ба эдгээрт усны нөөцийн болон УАА-н

салбарын мэдээллийн бүхий л онцлог шинжүүдийг зурагзүйн аргаар (график, диаграмм, картограмм, адил шугам, изогипс, изобад г.м) дүрслэн харуулсан Монголын анхны зурагзүйн томоохон бүтээл юм. Уг атласын Монгол орны усан баялгийг зурагзүйн нэгдмэл арга, тооцоогоор зурагласан сэдэвчилсэн зургуудад 3800 гаруй гол горхи, 3500 цэнгэг болон шорвог нуур, 7000 орчим булаг шанд, 260 гаруй мөнх цас, мөсөн голыг тэмдэглэж, Монгол орны хувьд анх удаа гадаргын усны мэдээллийг зургийн хэлээр илэрхийлсэн байна. Атласын зургийг зохиохдоо БНУАУ-ын зураг зүйн байгууллагад мөрдөгддөг аргачлалыг ашиглан усны аж ахуйн нэгжийн газар нутгийн ангиллыг хийж энэ ангиллаар усны нөөцийг тооцож гаргасан нь манай орны хувьд цоо шинэ ажил болсон юм. Тус ангиллыг үйлдэхдээ үндсэн нэгжийг аймгуудаар, аймгуудын газар нутгийг ус хурах талбай ба гидрогеологийн мужаар 2-5 дэд нэгжид хувааж авч үзсэн байдаг.



Фото-2, Ерөнхий схем зохиож байсан Унгар-Монгол судлаачид, зүүн гараас 1-р эгнээ Селлеши Д, Г.Жигмэд, Ч.Минжсин, Б.Сүхээ, С.Нямаа, 2-р эгнээнд Саны К, Г.Цэрэнжав, Эрдэнэ, Д.Төмөр, Дулмаа, Фритч Т, 3-р эгнээнд Теречик, Шагдарсүрэн, Доржготов, Светлана Чабо, Новаки Бела, Г Шагдарсүрэн, Г.Хандай, Л.Төмөр, Боршош Чабо нар

2.1 Сав нутгийн усны нөөцийг нэгдмэлээр ашиглах хамгаалах схемүүд:

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 127-р тогтоолын дагуу: “Монгол Улсын усны нөөц, баялгийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах ерөнхий схем” бүтээл дээр тулгуурлан БНМАУ-ын Усны Аж Ахуйн Яамны захиалгаар Унгарын “Усны Аж Ахуйн

Институтийн Новаки Бела, Монголын П.Цэнд-Ядам ахлагчтай багийн олон арван судлаачидтай хамтран 1977-1980 онд “Хэрлэн голын сав газрын усны нөөцийг иж бүрэн ашиглах, хамгаалах схем 2 боть”,



Фото-3, БНМАУ-ын Усны Аж Ахуйн Институтийн захирал Доктор Р.Мутч, УХТЭШИ-ийн захирал Ц.Балдандорж 1985 онд хэлэлцээ хийв.



Фото-4. БНУАУ-ын Усны Аж Ахуйн Институтийн захирал Доктор Р.Мутч, Кох.Д., ерөнхий инженер Л.Жанчивдорж, товчооны дарга П.Цэнд-Ядам нар хамтын ажиллагааны төлөвлөлт хийжээ

Унгарын “Усны аж ахуйн Институтийн Кох Дьердь, манай П.Цэнд-Ядам ахлагчтай баг 1980-1983 онд /фото-4/ “Их нууруудын хотгорын усны нөөцийг иж бүрэн ашиглах, хамгаалах схем” 3 боть, Унгарын “Усны Аж Ахуйн Институтийн А.Светник ахлагчтай баг 1984-1988

онд “Умард говийн усны нөөцийг иж бүрэн ашиглах, хамгаалах сав нутгийн схем” 4 боть, мөн “Онон, Улз, Халх гол” “Алтайн өвөр говь” зэрэг голуудын сав газрын схем боловсруулах Монголын судлаачдын багт зөвлөгөө өгч оролцон ажилласан юм.



Фото-5. БНУАУ-ын УАА Институтийн захирал, Доктор Р.Мутч-д, Л.Жанчивдорж дурсгалын зүйл гардуулжээ. 1985 он.



Фото -6. Саны Келемэн шавь Г.Удвалцэцэг, А.Раднаа нарын хамт

Унгарын картографч К.Саныг Монголын Засгийн газар Алтангадас одонгоор шагнаснаас гадна Унгарын төслийн багийн ахлагч Кок.Дьерль, Саны Келемен нарыг Монголын Усны аж ахуйн тэргүүний ажилтан





цол тэмдгээр шагнасан юм. Монголын Усны Институтийн ерөнхий инженер Л.Жанчивдорж 1987 онд БНУАУ-ын Засгийн газрын Усны аж ахуйн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдав.



Фото-7. Зүүн гараас П.Цэнд-Ядам, Верши Ласло, Л.Жанчивдорж, Кок. Д, Ц.Балдандорж, Саны .К, Г.Удвалцэцэг, И.Сюч нар

Эдгээр бүтээлүүдийн Атласуудыг БНУАУ-ын Усны аж ахуйн удирдах ерөнхий газрын Усны аж ахуйн институтийн оролцоотойгоор БНМАУ-ын Усны Аж Ахуйн Яамны Усны Хайгуул, Төсөл, Эрдэм Шинжилгээний Институт, Барилга-Архитектур, Техник Хяналтын Улсын Хорооны харьяа Улсын Геодези Зурагзүйн Газар хамтран зохиож, хэвлүүлсэн билээ. Тус схемийн зохицуулагчаар БНМАУ-ын Усны Аж Ахуйн Яамны нэгдүгээр орлогч сайд Э.Дамба, Усны Хайгуул, Төсөл, Эрдэм Шинжилгээний Институтийн

захирал Ц.Балдандорж, БНУАУ-ын Усны Аж Ахуйн Институтийн захирал Р.Мутч, редакцийн зөвлөлийн даргаар Э.Дамба, Ц.Балдандорж, БНМАУ-ын Барилга-Архитектур, Техник Хяналтын Улсын Хорооны харьяа Улсын Геодези Зурагзүйн Газрын дарга Б.Рагчаа, ерөнхий редактор Л.Жанчивдорж, Ж.Санжаажамц, Б.Новаки, Г.Тогоо П.Цэнд-Ядам нараар удирдуулсан Монгол, Унгар Улсын олон арван эрдэмтэн судлаачид оролцон гүйцэтгэжээ.



Зураг-2. “БНУАУ-ын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловсруулсан сав нутгийн усны нөөц, баялгийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах” бүтээлүүд, зарим зургууд



Фото-8. Их нууруудын хотгорын сав газрын усны нөөцийг иж бүрэн ашиглах, хамгаалах схем боловсруулах баг. Зүүн гар талаас нэгдүгээр эгнээнд К.Саны, Кох Дьердь, монгол гидрогеологч М.Ринзаан, арын эгнээнд П.Сүхбаатар, Верши Ласло, С.Цэрэннадмид, Г.Ринчиндорж, И.Винце нар



Фото-9. А.Светник олон жилийн дараа Монголд ирж хамтран ажиллаж байсан судлаачидтай уулзжээ. Зүүн гараас Ч.Минжин, Х.Дуламсүрэн, Б.Хоролмаа, А.Раднаа, М.Ринзаан, С.Банди, Х.Надмид, Ц.Минсэл, Г.Удвалцэцэг нар

Эдгээр бүтээлд улс ардын аж ахуйн салбаруудын нөөцийн чадамжийг нарийвчлан тооцож, улс ардын аж ахуйн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, салбаруудын хөгжлийн боломжийг, усны салбартай хэрхэн зохицуулан ажиллуулах тухай авч үзсэн байдаг. Усны балансыг 2030 оноор гаргаж Монгол орны эдийн засгийн чухал салбар хөдөө аж ахуйн ус хангамж, бэлчээр усжуулалтын асуудлыг бодлого, хэрэгжилтийн талаас товойлгон нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн байдалд үнэлгээ өгч улсын хэмжээний бэлчээр усжуулалтын төслийг үе шаттай хэрэгжүүлэх асуудлыг тусгайлан тусгасан байдаг. Мөн эрчим хүч /усны/ ашиглах, хөдөө аж ахуйн хөгжил, усалгаатай газар тариалан, хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын хөгжил, үерийн эрсдлээс хамгаалах систем хийгээд усны судалгаа гадаргын ба газрын доорх усны хяналтын сүлжээг өргөжүүлэх асуудлыг хөндсөн юм.


Гадаргын усны хяналт-шинжилгээний сүлжээний харуулын тоог нэмэгдүүлэх ашиглагдахгүй байгаа хуучин харуулуудыг сэргээн шинэчлэх /өмнө хийгдсэн олон жилийн ажиглалтын мэдээ материалтай/, харуулын ажиглалтын үнэн мэдээ материал үүсгэхэд анхаарах, ажиглалтын мэдээ материалын төрлийн тоог /хатуу урсац-хагшаас, ууссан хүчилтөрөгч, усны температур гм., зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг бүрдүүлэх/ нэмэгдүүлэх олон улсын жишигт ойртуулах, тогтмолжуулах зөвлөмж бий.

Урсацын тохируулга хийж ус хуримтлуулах усан санг байгуулах загас агнуур, тариалангийн усалгаа, бэлчээр усжуулалт, суурин газрын усан хангамж, усны эрчим хүч, усан спорт, аялал жуулчлал гм/ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэд хэдэн чиглэл зорилтыг нэгтгэн цогц байдлаар хийх менежментийн зөвлөмжид тусгасан байдаг.

Эдгээр цуврал бүтээлүүдийг 2005 онд Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв, Шинжлэх Ухааны Академи, Монголын залуу үеийн хөгжлийн ассоциациас “ХХ зууны шинжлэх ухааны шилдэг бүтээл”-ээр шалгаруулан Улсын Их Хурлын даргын ивээл дор хүндэтгэн өргөмжилж, “Монголын шинжлэх ухааны шигшмэл өв сангийн шилдэг

дээжис 99 боть”-д хэвлүүлэх эрхээр батламжилсан (Зураг 3) юм.

Дээрх цуврал бүтээлүүд нь одоог хүртэл ач холбогдлоо алдаагүй бөгөөд Монгол орны усны салбар, усны менежментийн төлөвлөлтөнд болон судалгаа, шинжилгээний ажилд томоохон тулгуур материал болон ашиглагдсаар байна.



Зураг-3. 2005 оны 3 сарын 3. УИХ-ын дарга Н.Энхбаяр, ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Чадраа нар Геозэкологийн хүрээлэнгийн усны салбарын дарга Л.Жанчивдоржид өргөмжлөл гардуулав

3.Услалтын системийн зураг төсөл, бүтээн байгуулалтад:

Унгар улс манай усны аж ахуйг хөгжүүлэх хэрэгт буцалтгүй тусламж үзүүлж, 1981 онд Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны отор тэжээлийн аж ахуйд 1306 га талбай бүхий услалтын систем, 1989 онд Дорнод аймгийн Баянтүмэнгийн дээд Чойбалсанд 2000 га услалтын систем тус тус барьж

ашиглалтад оруулсан юм. Унгарын усны аж ахуйн “ВИЗИТЕРВ” институт /ахлах инженер Боршош Чабо/ Хэрлэнбаян-Улаан, Дорнод аймгийн Баянтүмэнгийн услалтын системийн зураг төслийг, ус татамжийн байгууламж, хиймэл нуурыг Монголын зураг төсөлчид зохиосон байна.



Фото-10. Хэрлэнбаян-Улааны усалтын системийн ус татамжийн байгууламж, талбайн услагаатай тэжээлийн ургамлын ургац хураалт 1984 он

4. Хамтын ажиллагааны шинэ эхлэл ба тогтолцооны гажиг

2005 оноос зах зээлийн үеийн усны салбарын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор БНУАУ-ын судлаачид хамтын ажиллагааны хүрээнд айлчилж хамтран ажиллах, төлөөлөгч солилцох талаар тохиролцон эхлэсэн боловч Монголын тал уул уурхайн үйлдвэрлэлд саад хийлгэхгүй байлгах зорилгоор 2005 оноос зах зээлийн үед хэрхэн амьдрах ухаанаа олох гэж тэнцэж ядаж байсан Усны хэрэг эрхлэх газрыг 2012 оны 8-р сард татан буулгаж хамтын ажиллагаа үндсэндээ зогссон юм.

Монгол Унгарын усны аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Унгарын хөдөөг хөгжүүлэх Яамны Ус, байгалийн аюулгүй байдлыг хангах газрын дарга Иштван Ланг тэргүүтэй төлөөлөгчид /ерөнхий зохицуулагч Пап К, Дунай дундах сав газрын Байгаль хамгаалах, усны аж

ахйн удирдах газрын захирал Ловаш Атила, Ньирэдьхаз хотын VIZITERV Environ XX ерөнхий захирал Лайош Иллуш, орлогч захирал Кэртирти Андор, Байёо хотын ADUKVIZIG ХХК- төлөөлөгч Габор Кеке нар /2010 оны 6 сарын 21-30 нд Монголд айлчилж Хэрлэн голын савын усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын урьдчилсан судалгаа хийж хөрөнгө босгон 2014 онд мэргэжлийн судлаачдын баг ирүүлэн Монголын талтай хамтран холбогдох мэдээллийг боловсруулан "Өөрчлөгдөн байгаа уур амьсгалын нөхцөлд Дорнод-Монголын усны менежментийн загварчлал" /Integrated Water Management Model of East-Mongolia in changing climate/ саналыг Монголын талд буюу С.Оюун /БОАЖЯ/ сайдад хүлээлгэн өгсөн боловч БОАЖЯ-ны удирдлага солигдон шалтгаанаар өөр гүйцэтгэгч сонгосон байдаг.



Фото-11,12. Унгарын баг урьдчилан бэлтгэсэн төслөө Геоэкологийн хүрээлэнгийн захирал, доктор Ж.Цогтбаатар болон судлаачдад танилцуулан уулзалт хийв. 2014 он

Хамтран хэрэгжүүлэхээр ярилцаж байгаа санал

1. Унгар ус судлал, ус зохистой ашиглах, усны хор хөнөөлтэй тэмцэх чиглэлээр өндөр мэдлэг чадвартай, туршлагатай мэргэжилтэн бэлтгэж, хамтран судалгаа хийх
2. Унгарын усны аж ахуйн судалгааны байгууллагатай /хүрээлэнтэй/ хамтран “Дэлхийн дулаарлын нөлөө ба усны гамшигт үзэгдлээс Монголын томоохон хотуудыг хамгаалах” чиглэлээр хамтарсан судалгаа хийх зэрэг болно.

*Монгол Улсын зөвлөх инженер, доктор Л.Жанчивдорж,
Газарзүй, Геоэкологийн хүрээлэнгийн Усны нөөц,
ус ашиглалтын салбарын дарга, доктор С.Чинзориг*